

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОДЛОГО

Энэхүү баримт бичгийн эхийг ЕСБХБ зөвхөн уншигчийн хэрэгцээнд зориулан орчуулсан болно. ЕСБХБ орчуулгын үнэн зөвийг хангахад зохих анхаарал хандуулсан хэдий ч орчуулгын үнэн зөв байдлыг баталгаажуулахгүй, батлахгүй. Ийм аливаа орчуулгад итгэх эсэх нь тухайн уншигчийн өөрийн хүлээх эрсдэл юм. Ямар ч нөхцөлд ЕСБХБ, түүний ажилтан эсвэл төлөөлөгчийн зүгээс уншигч эсвэл өөр хэн нэгний өмнө орчуулгын алдаа мадаг, эндүү ташаа байдал, мөн тодорхой агуулгыг орхигдуулсан, устгасан, гажуудуулсан ба/буюу өөрчилсөн, эсвэл түүний улмаас учирсан гэм хорын төлөө шалтгаан үл харгалзан хариуцлага хүлээхгүй. Англи хэл дээрх болон орчуулсан хувилбарын хооронд зөрүү, зөрчил гарсан тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

Гарчиг

Бүлэг I: Зорилго	3
Бүлэг II: Тодорхойлолт	4
Бүлэг III: Хамрах хүрээ	5
1. ЕСБХБ-ны үүрэг, хариуцлага	5
2. ЕСБХБ-ны үүрэг амлалт	5
3. Байгаль орчин, нийгмийн хүрээний Гүйцэтгэлийн Шаардлага	6
4. Байгаль орчин, нийгмийн асуудлуудыг төсөлд тусгах нь	7
5. ЕСБХБ-ны олон нийтэд тайлагнах, хариуцлага хүлээх үүрэг.....	9
6. Байгууллага болон хэрэгжилтийн зохицуулалт.....	8
7. Хавсралт	8
Бүлэг IV: Татгалзал, Үл хамаарах зүйл болон Нийтэд ил болгох.....	10
1. Татгалзал	10
2. Үл хамаарах зүйл	10
3. Нийтэд ил болгох	10
Бүлэг V: Шилжилтийн үеийн заалтууд	10
Бүлэг VI: Хүчин төгөлдөр болох огноо.....	10
Бүлэг VII: Шийдвэр гаргалтын хүрээ.....	10
Бүлэг VIII: Үнэлгээ ба тайлагнал.....	10
1. Үнэлгээ	10
2. Тайлагнал	10
Бүлэг IX: Холбогдох баримт бичиг	10
Хавсралт 1: ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалт	11
Хавсралт 2: “А” ангиллын төслүүд.....	12
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, удирдлага	15
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 2: Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл	19
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах	22
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 4: Эрүүл мэнд, аюулгүй байдал ба хамгаалалт	25
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 5: Газар чөлөөлөх, газар ашиглахыг хориглох, албадан нүүлгэн суурьшуулах	29
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6: Биологийн олон янз байдлын хадгалалт, байгалийн амьд нөөцийн тогтвортой удирдлага	39
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 7: Нутгийн уугуул иргэд	43
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 8: Соёлын өв	47

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 9:	
Санхүүгийн зуучлагчид	50
Хавсралт А: Санхүүгийн зуучлагчдын лавлагаа жагсаалт	51
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 10:	
Мэдээллийг ил болгох, талуудын оролцоог хангах.....	52

Бүлэг I: Зорилго

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (цаашид “ЕСБХБ”, эсвэл “Банк” гэх) нь ЕСБХБ-ыг үүсгэн байгуулах тухай гэрээний¹ дагуу явуулж буй бүхий л үйл ажиллагаандаа “байгаль орчинд халгүй, тогтвортой хөгжил”-ийн зарчмыг хөхиүлэн дэмждэг. ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдал бол тус Банкны шилжилтийн эдийн засгийг дэмжих бодлогод нийцсэн үр дүнд хүрэхэд нэгэн чухал суурь үзүүлэлт юм гэж үздэг. Иймд байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг дэмжсэн төслүүд Банкны үйл ажиллагаанд эн тэргүүний ач холбогдолтойд тооцогдох болно.

Энэхүү баримт бичиг нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Банкны зүгээс төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийг хэрхэн үнэлэх, хянах талаар тоймлон харуулах;
- ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүдийн хэрэгжих бүхий л хугацаанд тухайн төслүүдээс үүдсэн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ба эрсдлийг зохицуулан шийдвэрлэх чиглэлд тавигдах хамгийн наад захын шаардлагыг заах;
- Банкны байгаль орчин, нийгмийн өндөр үр шимтэй төслүүдийг дэмжих стратегийн зорилтыг тодорхойлох; мөн
- Төслийг энэхүү Бодлогын дагуу боловсруулах, хэрэгжүүлэх, бодит ажил болгоход ЕСБХБ болон зээлдэгчдийн аль алиных нь хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус тодорхойлох.

Энэхүү баримт бичиг хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөр 2014 онд батлагдсан ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд хүчингүй болно.

¹ Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкыг үүсгэн байгуулах тухай гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 (vii).

Бүлэг II: Тодорхойлолт

Энэхүү Бодлогын баримт бичигт ашиглагдсан нэр томъёонууд нь дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

"холбогдох байгууламж"	ЕСБХБ-наас төслийн хүрээнд санхүүжүүлээгүй боловч ЕСБХБ-ны үзэж байгаагаар төслийн амжилтыг тодорхойлох буюу төслийн тохиролцсон үр дүнг гаргахад чухал ач холбогдолтой барилга байгууламж, үйл ажиллагаа. Энэ нь шинэ байгууламж, үйл ажиллагаа бөгөөд: (i) түүнгүйгээр төсөл хэрэгжих боломжгүй, мөн (ii) хэрэв төсөл байгаагүй бол тэрхүү байгууламжийг барих, өргөтгөх, эцэслэн гүйцэтгэх буюу тийнхүү барьж байгуулах, эцэслэн гүйцэтгэхээр төлөвлөх боломжгүй байх байсан.
"олон улсын сайн туршлага" буюу "ОУСТ"	дэлхий даяар эсвэл бүс нутгийн хувьд ижил, төстэй нөхцөл байдалд ижил төрлийн ажил эрхэлж буй чадварлаг, туршлагатай мэргэжилтнүүдээс зохих ёсоор хүсэн хүлээдэг мэргэжлийн үр чадвар, хичээл зүтгэл, сонор сэрэмж, алсын харааг ашиглах. Үүний үр дүнд төсөлд тухайн төслийн онцлог нөхцөл байдалд тохирсон техник, стандартыг ашиглах боломжтой болно.
"эрсдэл, нөлөөллийг бууруулах шатлал"	хөгжлийн үйл ажиллагааны эхэн үеэс байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бий болгохоос зайлсхийхийн тулд авсан арга хэмжээ, мөн тийнхүү сэргийлэх боломжгүй тохиолдолд болзошгүй сөрөг нөлөөллийг хамгийн доод түвшинд байлгах, бууруулах, хамгийн сүүлчийн арга хэмжээ болгон хохирлыг барагдуулах зэрэг нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэх арга барил.
"төслийн"	санхүүжилтийн гэрээнд тусгагдсан, хэрэгжүүлэхийн тулд зээлдэгчийн ЕСБХБ-наас санхүүжилт хүссэн бөгөөд ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөлийн баталсан, эсвэл хэрэв Захирлуудын Зөвлөлөөр бүрэн итгэмжлэгдсэн бол Банкны удирдлагын баталсан ажил үүрэг, бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бизнесийн үйл ажиллагаанууд.
"нийгмийн"	төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, тэдний олон нийт, ажилтан, ажилчдад хамаарах, нийгэм эдийн засгийн байдал, эмзэг өртөмхий байдал, хүйс, хүйсийн баримжаа, хүний эрх, бэлгийн чиг баримжаа, соёлын өв, хөдөлмөр эрхлэлт, ажиллах нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдал ба шийдвэр гаргалтанд оролцох оролцоотой холбоотой асуудлууд.
"эмзэг өртөмхий хүмүүс"	хүйс, хүйсийн баримжаа, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, үндэс угсаа, нутгийн уугуул байдал, нас (хүүхэд, залуучууд, өндөр настнуудыг оролцуулаад), бие махбодын эсвэл оюуны хөгжлийн бэрхшээл, бичиг үсэгт тайлагдсан байдал, үлс төрийн үзэл бодол эсвэл нийгмийн байдал гэх мэт шинж чанараараа төслийн нөлөөлөлд бүсдаас илүү ихээр өртөж болзошгүй хувь хүмүүс буюу бүлэг хүмүүс. Эмзэг өртөмхий хувь хүмүүс буюу бүлэг хүмүүс гэдэгт эмзэг өртөмхий нөхцөлд байгаа, тухайлбал, ядуурлын шугамнаас доогуур түвшинд амьдардаг хүмүүс, өөрийн эзэмшил газаргүй, ганц бие эцэг/эх бүхий гэр бүлүүд, байгалийн баялгаас хамааралтай нутгийн иргэд, олон нийт, явуулын ажилтан, ажилчид, дүрвэгсэд, дотоодын дүрвэгсэд болон бусад нүүлгэн шилжүүлсэн хүмүүс зэрэг үндэсний хууль тогтоомж ба/буюу олон улсын нийтийн эрх зүйгээр хамгаалагдах боломжгүй хүмүүс багтана.

Бүлэг III: Хамрах хүрээ

1. ЕСБХБ-ны үүрэг, хариуцлага

- 1.1. ЕСБХБ-ны хүлээх хариуцлага нь ЕСБХБ-ны баталсан төслүүдэд санхүүжилт олгодог олон улсын санхүүгийн байгууллага болохын хувьд гүйцэтгэх үүрэгтэй нь нийцдэг. Аливаа хөрөнгө оруулалт болон техникийн хамтын ажиллагааны төслийн хувьд ЕСБХБ-ны оролцооны түвшин нь тухайн төслийн мөн чанар, хамрах хүрээ, хандивлагчдын хөрөнгө санхүүжилт бүрдсэн байдал, мөн харилцагч зээлдэгчидтэй тогтоосон хамтын ажиллагаа, харилцаа холбооны тодорхой нөхцөл байдлаар тодорхойлогдоно.
- 1.2. ЕСБХБ нь байгаль орчны болон нийгмийн үндэслэл шалтгаанаар төслийг санхүүжүүлэхээс татгалзаж болно. Энэхүү Бодлогын Хавсралт 1-т харуулсан ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалтын дагуу ЕСБХБ-наас санхүүжүүлдэггүй хэд хэдэн төрлийн үйл ажиллагаанууд бий.
- 1.3. ЕСБХБ нь олон тооны хандивлагчдын санхүүжилтийг захиран зарцуулдаг. Хандивлагчдын хөрөнгөөр бүхэлдээ буюу хэсэгчлэн санхүүжсэн бүх төсөл, үйл ажиллагаанууд энэхүү Бодлогыг дагаж мөрдөнө. Хандивлагчдын хөрөнгөөр санхүүжсэн төслүүдийн хувьд ЕСБХБ ба хандивлагчдын хооронд тохиролцсон ёсоор байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой хандивлагчдын нэмэлт шаардлагууд тавигдаж болно.

2. ЕСБХБ-ны үүрэг амлалт

- 2.1. ЕСБХБ-ны санхүүжүүлсэн бүх төсөл энэхүү Бодлогыг дагаж мөрдөхөөр зохион байгуулагдсан байх ёстой.
- 2.2. Европын байгаль орчны зарчмуудад² нэгдсэний хувьд ЕСБХБ нь төслийг Европын Холбоо (цаашид “ЕХ” гэх)-ны байгаль орчны зарчим, арга туршлага, суурь стандартуудад³ нийцүүлэн зохион байгуулж, газар зүйн байршлаас үл хамааран төслийн түвшинд хэрэгжүүлэх нөхцлийг хангахыг эрмэлздэг. Хүлээн авагч улсын дотоодын хууль журам нь ЕХ-ны байгаль орчны суурь стандартуудаас ялгаатай тохиолдолд төслүүд аль хатуу чанга журам стандартыг нь хангах шаардлагатай болно.
- 2.3. ЕСБХБ нь тухайн улсын үндэсний хууль тогтоомжийг болон төслийн үнэлгээний шатанд тогтоосон холбогдох олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргийг зөрчсөн төслийг мэдсээр байж санхүүжүүлэхгүй.
- 2.4. ЕСБХБ нь өөрийн санхүүжүүлсэн төслүүдэд хүний эрхийг⁴ дээдлэх үүрэг хүлээсэн. Банкны зүгээс зээлдэгч, харилцагчдаа бизнесийн үйл ажиллагааныхаа хүрээнд хүний эрхийг хүндэтгэх, бүсдын эрхийг зөрчихөөс зайлсхийх, бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн эрсдэл ба сөрөг нөлөөллийг арилгах шаардлага тавина. ЕСБХБ өөрийн санхүүжүүлэх төслүүдийг олон улсын сайн туршлага (ОУСТ)-д нийцүүлэн тасралтгүй сайжруулсаар байх бөгөөд төслийн үнэлгээ, хяналт шинжилгээний явцад хүний эрхийн эрсдлийг

тодорхойлох, шийдвэрлэх үйл явцыг үе шаттайгаар бэхжүүлэхийг эрмэлзэх болно.

- 2.5. ЕСБХБ нь жендэрийн тэгш байдлыг орчин үеийн, амжилттай сайн ажиллаж буй зах зээлийн эдийн засаг, ардчилсан нийгмийн суурь үзэл санаа гэж үзэж, хүйсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, бүрэн эрхийнхээ хүрээнд жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих үүргийг өөртөө хүлээдэг. Банк өөрийн зээлдэгчдээсээ аливаа боломжит жендэрийн онцлогтой, пропорциональ бус сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаарддаг. Түүнчлэн, Банк зээлдэгчдээ хүчирхийлэл, дарамт, тэр дундаа бэлгийн дарамт, мөлжлөг, хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэл, дээрэлхэлт, айлган сүрдүүлэлт ба/буюу мөлжлөгөөс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ авахыг шаардах болно.
- 2.6. ЕСБХБ нь зээлдэгч харилцагчдаа төслийн нөлөөлөлд бүсдаас илүүтэй өртсөн байж болзошгүй эмзэг бүлэг, хүмүүсийг тодорхойлох, мөн тэдгээр бүлэг, хүмүүсийг хэт их сөрөг нөлөөлөлд өртөхөөс сэргийлэх болон шийдвэрлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх шаардлага тавина. Үүнд төслийн үр дүнд бий болсон үнэ тарифын өөрчлөлт нь хүн амын ядуу болон эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн анхан шатны үйлчилгээний үнийн боломжит байдалд хэр зэрэг хүндрэл учруулж болохыг үнэлэх, мөн төлбөрийн чадвартай холбоотой бэрхшээлийг арилгах үр дүнтэй схем боловсруулж, хэрэгжүүлэх үүргээ биелүүлэх зэрэг орох болно.
- 2.7. ЕСБХБ нь үйл ажиллагаа явуулдаг улс орнуудад үүссэн уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврыг тогтоон, шийдвэрлэхийн чухлыг ойлгож, хүлээн зөвшөөрч байна. Банк шаардлагатай үед нүүрстөрөгчийн хий огт ялгаруулахгүй буюу бага ялгаруулах хөрөнгө оруулалт болон уур амьсгалын өөрчлөлтийг бууруулж, дасан зохицох боломжуудыг дэмжих, төслүүдэд хүлэмжийн хий ялгаруулахаас сэргийлэх буюу хамгийн бага түвшинд байлгах боломжит арга замуудыг тогтоох чиглэлд шинэлэг хөрөнгө оруулалт, техникийн туслалцаагаар хангана. Харилцагчдаа төслийн үйл ажиллагаанд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх эрсдлийг үнэлэх шаардлага тавихын зэрэгцээ ЕСБХБ нь тэднийг уур амьсгалд дасан зохицох арга хэмжээ, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах хөрөнгө оруулалтыг төлөвлөн хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдлийг удирдахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 2.8. ЕСБХБ нь зээлдэгчдээ байгалийн амьд нөөцийн хадгалалт, сэргээлт, удирдлага болон тогтвортой ашиглалтыг хангахдаа болгоомжтой хандахыг шаардана. Харилцагчид биологийн олон янз байдлыг цэвэр алдагдалд оруулахгүй байх зорилгоор дэмждэг биологийн олон янз байдал болон экотогтолцоог хамгаалах, боломжтой бол сайжруулах, мөн байгалийн

² Европын байгаль орчны зарчмууд (ЕБОЗ буюу “ЕРЕ”)–ыг Европын Хөгжлийн Банк, ЕСБХБ, Европын Хөрөнгө Оруулалтын Банк, Нордикийн байгаль орчны санхүүжилтийн корпораци, Нордикийн Хөрөнгө Оруулалтын Банкны Зөвлөлөөс батлан гаргасан. ЕРЕ нь төслийн санхүүжилттэй холбоотой байгаль орчны зарчим, үйл ажиллагаа ба стандарт хоорондын үйлдээс холбоог бэхжүүлэх хүсэл эрмэлзлэлийн хариуд гаргасан санаачлага юм. ЕРЕ-ийн хүрээнд хүлээх үүрэг амлалтыг ГШ.1, 3, 4 ба 10-т тусгасан байна.

³ Европын Холбоо (ЕХ)-ны байгаль орчны бодитой стандарт нь ЕХ-ны хоёрдогч хууль тогтоомж, тухайлбал журам, захирамжид багтсан байдаг. ЕХ-ны гишүүн улс, байгууллагуудад үйлчлэх процедурын хэм хэмжээ ба гишүүн улс, ЕХ-ны байгууллага, ЕХ-ны хуулийн этгээд, иргэдэд үйлчлэх Европын Холбооны дээд шүүх, анхан шатны шүүхийн шийдвэр энэ тодорхойлолтод хамаарахгүй.

⁴ Энэхүү бодлогын баримт бичгийн зорилгын хувьд ЕСБХБ нь Хүний эрхийн олон улсын билл болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тулгуур 8 конвенцуудыг удирдлага болгоно.

амьд нөөцийг тогтвортой захиран зарцуулах арга хэмжээг холбогдох төслүүдэд багтаасан байх ёстой.

- 2.9. ЕСБХБ нь ил тод байдал, хариуцлага болон талуудын оролцоог хангах зарчмуудыг мөрдлөг болгож, харилцагчдаа даа тэдгээр зарчмуудыг нэвтрүүлэх, дагаж хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмждэг. Банк харилцагчдаасаа олон нийтийн мэдээлэл, зөвлөгөөнтэй холбоотой үндэсний хууль тогтоомжийн холбогдох шаардлагуудыг дагаж мөрдөх, төслийн нөлөөнд өртсөн байж болзошгүй ба/буюу төслийг сонирхогч оролцогч талуудыг тодорхойлох, гомдол барагдуулах тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэхийг шаарддаг. Мөн зээлдэгчдээс төслийн мөн чанар, цар хүрээ, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл, нөлөөллийн хэмжээнд харгалзуулан төслөөс үүсэх эрсдэл, нөлөөллийн талаар хангалттай мэдээллийг нийтэд ил тод болгох, оролцогч талуудыг үр дүнтэй, тэгш хүртээмжтэй, соёлын хувьд зохистой байдлаар оролцуулах, ийм оролцоо, хамтын ажиллагаагаар дамжин ирсэн санал хүсэлтийг харгалзан үзэхийг шаардана.
- 2.10. ЕСБХБ харилцагч зээлдэгчдэдээ үйл ажиллагаандаа нэмүү өртгийг бүтээж, урт хугацааны тогтвортой байдлаа сайжруулж, байгаль орчин, нийгмийн удирдлагын чадавхаа бэхжүүлэхэд нь туслах зорилгоор тэдэнтэй түншлэлийг бий болгоно. Банк үйл ажиллагаа явуулдаг улс орнууддаа байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг бүс нутгийн болон салбарын түвшинд хөхиүлэн дэмжих үр дүнтэй арга хэмжээнүүдийг зохицуулах чиглэлд бусад олон улсын санхүүгийн байгууллагууд, Европын Холбоо, хоёр талт хандивлагчид, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах болно. Аливаа төслийг олон талт хөгжлийн банк болон хоёр талт хөгжлийн байгууллагатай хамтран санхүүжүүлж байгаа тохиолдолд ЕСБХБ нь төслийн үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн удирдлага, хяналт шинжилгээ болон тайлагнах ажлыг гүйцэтгэхэд баримтлах нийтлэг арга зарчмыг тохиролцохын тулд тэдэнтэй хамтран ажиллах болно. Нийтлэг арга зарчим нь энэхүү Бодлого, түүний доторх Гүйцэтгэлийн Шаардлагуудтай агуулга, үр дүнгийн хувьд материаллаг байдлаар нийцэж байгаа тохиолдолд ЕСБХБ түүнийг хүлээн зөвшөөрч болно. Банк зээлдэгчдээс төсөлдөө Банкны шаардлага юм уу эсвэл нийтлэг арга зарчмыг дагаж мөрдөхийг шаардана.
- 2.11. ЕСБХБ-ны улс орны түвшний стратеги, салбарын стратеги болон бодлогод ЕСБХБ-ны урьдчилан тооцоолсон үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн болзошгүй сорилт ба боломжуудыг тусган авч үзнэ.
- 2.12. ЕСБХБ нь техникийн хамтын ажиллагаа болон бодлогын яриа хэлэлцээгээр дамжуулан өөрийн үйл ажиллагаа явуулдаг улс орнуудад байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл ба бололцоог харгалзан үзэх, удирдан зохицуулах чадавхыг бэхжүүлэх боломжийг эрэлхийлэх болно. Банк харилцагчдаа төслөөрөө байгаль орчин, нийгмийн хувьд тогтвортой үр дүнд хүрэхэд нь тус дөхөм болох дэмжих орчин бүрдүүлнэ.

3. Байгаль орчин, нийгмийн хүрээний Гүйцэтгэлийн Шаардлагууд

- 3.1. ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын голлох чиглэлүүдэд төслүүдийн хангах ёстой Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ-ууд)-ыг цогцоор нь авч тусгасан. ГШ-уудын гол цөм нь эрсдэл, нөлөөллийг бууруулах шатлал болон олон улсын сайн туршлага (ОУСТ)-ыг нэтрүүлэхэд оршино.
- 3.2. ГШ-уудыг дор харуулав. Үүнд:
- | | |
|-------|---|
| ГШ.1 | Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, удирдлага |
| ГШ.2 | Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл |
| ГШ.3 | Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах |
| ГШ.4 | Эрүүл мэнд, аюулгүй байдал ба хамгаалалт |
| ГШ.5 | Газар чөлөөлөх, газар ашиглахыг хориглох, албадан нүүлгэн суурьшуулах |
| ГШ.6 | Биологийн олон янз байдлын хадгалалт, байгалийн амьд нөөцийн тогтвортой удирдлага |
| ГШ.7 | Нутгийн уугуул иргэд |
| ГШ.8 | Соёлын Өв |
| ГШ.9 | Санхүүгийн Зуучлагчид |
| ГШ.10 | Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоог хангах |
- ГШ.1 – 8 болон ГШ.10 -д шүүд хөрөнгө оруулалтын төслүүдэд тавигдах шаардлагуудыг багтаасан. ГШ.2, ГШ.9 болон ГШ.4-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагууд дотор санхүүгийн зуучлагчид (СЗ)-ын төсөлд тавигдах шаардлагуудыг тусгасан. ГШ тус бүр нь ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүдийн хувьд тухайн зээлдэгч өөрөө шүүд хэрэгжүүлдэг, эсвэл гуравдагч этгээдээр дамжуулан гүйцэтгэдэг⁵ эсэхээс үл хамаарч ханган биелүүлэх ёстой нарийн тодорхой шаардлагуудыг агуулна. Холбогдох үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөх нь бүх ГШ-ын салшгүй хэсэг юм.
- 3.3. Шинэ байгууламж эсвэл бизнесийн үйл ажиллагаатай холбоотой төслүүдийг анхнаас нь ГШ-д нийцүүлэн төлөвлөнө. Хэрэв төсөл нь зээлдэгчийн одоогийн, ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөлөөс зөвшөөрөл авах үед ГШ-ыг хангаагүй барилга байгууламж, бизнесийн үйл ажиллагааг шинэчлэх, сайжруулахад чиглэсэн бол, эсвэл Захирлуудын Зөвлөлөөс зөвшөөрөн батлах эрхийг олгосон бол Банкны удирдлага, эсвэл хэрэв төсөл нь анхнаасаа ГШ-ыг хангаагүй бол зээлдэгч байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) боловсруулж батлах шаардлагатай бөгөөд үг төлөвлөгөөнд тэдгээр байгууламж, үйл ажиллагааг ЕСБХБ-наас зөвшөөрсөн хугацааны дотор ГШ-д нийцүүлэхэд чиглэсэн техникийн болон санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой, зардал багатай цуврал арга хэмжээнүүдийг багтаасан байна. ЕСБХБ ба зээлдэгчид нь харилцан тохиролцож БОНУАТ-нд зээлдэгчийн зүгээс ГШ-ын дагуу төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийг хянан зохицуулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай засаж залруулах болон урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах нарийвчилсан арга

⁵ Гуравдагч этгээд нь тухайлбал, төсөл/зээлдэгчийн нэлээд гүнзгий хамтран ажилладаг засгийн газрын агентлаг, гэрээт ажил гүйцэтгэгч, эсвэл ханган нийлүүлэгч байж болно.

хэмжээнүүдийг хэрэгжүүлэх цаг хугацааны хүрээтэй нь тусган оруулна. БОНУАТ нь санхүүжилтийн гэрээний нэг хэсэг байх бөгөөд шаардлагатай бол тухайн БОНУАТ-ний хэрэгжилтийг дэмжих чиглэлд зээлдэгчдийн хүлээх үүргийг дотроо агуулсан байна.

- 3.4. Төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээнд тухайн төсөлд холбогдох байгууламжийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ багтсан байна. Зээлдэгч холбогдох байгууламжаас үүдэлтэй байгаль орчны ба/эсвэл нийгмийн эрсдэл, нөлөөллийг холбогдох хууль, ОУСТ болон ГШ-ийн зорилтуудын дагуу зохицуулж, бууруулах шаардлагатай. Холбогдох байгууламж нь ГШ-ын зорилтыг хангахуйц бүтэцтэй байх боломжгүй тохиолдолд төслийн үнэлгээ нь тэрхүү холбогдох байгууламжийн төсөлд үзүүлж болзошгүй байгаль орчны болон/эсвэл нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлно.
- 3.5. Төслийн ойр орчмын бусад байгууламж эсвэл үйл ажиллагаа, одоогийн байгууламж, мөн ГШ-ууд үл үйлчлэх, зээлдэгчийн хяналтаас гадуурх байгууламж эсвэл үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд ноцтой байж болзошгүй эрсдэл, нөлөөлөл үүссэн нь илэрсэн тохиолдолд зээлдэгч төсөлд учрах эрсдлийг бууруулах чиглэлд зохих хэмжээний хүчин чармайлт гаргана.

4. Байгаль орчин, нийгмийн асуудлуудыг төсөлд тусгах нь

Ангилал

Шууд хөрөнгө оруулалт⁶

- 4.1. ЕСБХБ нь шаардлагатай байгаль орчин, нийгмийн судалгаа, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын оролцооны мөн чанар, түвшинг тодорхойлохын тулд төсөл бүрийг ангилдаг. Энэ нь төслийн мөн чанар, байршил, мэдрэмтгий чанар, цар хүрээ, мөн байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй шинэ бөгөөд нэмэлт нөлөөллийн хэмжээтэй уялдсан байна.
- 4.2. Төсөл нь байгаль орчин, нийгэмд шинээр буюу нэмэлтээр үзүүлэх шууд болон хуримтлагдсан нөлөөлөл зэрэг байгаль орчин, нийгмийн нөлөөлөл өндөртэй байж болзошгүй, мөн төслийг ангилах үед тэрхүү нөлөөллийг шууд тодорхойлох, үнэлэх боломжгүй тохиолдолд тухайн төслийг “А” ангилалд оруулна. “А” ангилалд багтсан төслүүдэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн албан ёсны, оролцоонд тулгуурласан үнэлгээ хийгдэх шаардлагатай. А ангиллын төслүүдийн жагсаалтыг энэхүү Бодлогын баримт бичгийн Хавсралт 2-т үзүүлэв.
- 4.3. Төслийн байгаль орчинд ба/буюу нийгэмд учирч болзошгүй нөлөөлөл нь ихэвчлэн тухайн газар нутгийн онцлогтой холбоотой болон/эсвэл нөлөөллийг бууруулах үр дүнтэй арга хэмжээний тусламжтайгаар амархан тодорхойлж, шийдвэрлэх боломжтой бол уг төслийг “В” ангилалд оруулна. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хамрах хүрээг ЕСБХБ тухайн тохиолдол бүрээр тогтооно.
- 4.4. Төсөл байгаль орчинд болон/эсвэл нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлал бага буюу байхгүй тохиолдолд тухайн төслийг “С” ангилалд оруулна.

- 4.5. Үнэлгээний зохих ангилал, хамрах хүрээг тодорхойлохын тулд ангилах үед хангалттай мэдээлэл байхгүй тохиолдолд байгаль орчин, нийгмийн анхан шатны шалгалтыг (БОНАШШ) явуулна.

Санхүүгийн Зуучлагчид

- 4.6. Төслийн санхүүжилтийн бүтцэд Санхүүгийн зуучлагчид (СЗ)-аар дамжуулан санхүүжилт олгох үйл ажиллагаа багтсан бол тухайн төслийг “СЗ” гэсэн ангилалд оруулна.

Төслийн үнэлгээний ерөнхий арга зарчим

- 4.7. Төслийг санхүүжүүлэх эсэхээ шийдэх, хэрэв санхүүжүүлэх ёстой бол төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, ажиллуулах явцад байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх арга замыг тогтооход нь ЕСБХБ-д туслах зорилгоор бүх төслүүд байгаль орчин, нийгмийн үнэлгээнд хамрагддаг. Үнэлгээний хамрах хүрээ нь тухайн тохиолдол тус бүрээр яв цав тодорхойлогдох боловч төслийн мөн чанар, цар хүрээнд нийцсэн, байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн түвшинд тохирсон байх болно. Үнэлгээ нь төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл болон зээлдэгчийн холбогдох ГШ-ын дагуу төслийг хэрэгжүүлэх чадавх, үүрэг амлалтыг үнэлнэ. Төсөл нь одоо байгаа барилга байгууламж, бизнесийн үйл ажиллагаа болон/эсвэл холбогдох байгууламжийг хамарсан тохиолдолд үнэлгээнд тэдгээр байгууламж, үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг харгалзан авч үзнэ.
- 4.8. Банкинд энэхүү Бодлогын дагуу байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх бололцоо олгохын тулд зохих мэдээллээр хангах нь зээлдэгчийн үүрэг юм. Банкны үүрэг нь: (i) зээлдэгчийн мэдээллийг шалгах; (ii) холбогдох ГШ-ыг хангахын тулд байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг арилгахад чиглэсэн нөлөөллийг бууруулах шатлалд нийцсэн зохих арга хэмжээг боловсруулахад зээлдэгчид туслах зааварчилгаа өгөх; мөн (iii) байгаль орчны болон нийгмийн нэмэлт үр өгөөжийг хүртэх боломжийг тодорхойлоход туслах юм.
- 4.9. Банкны хөрөнгө оруулалт нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, зарим төрлийн шууд хөрөнгө оруулалт гэх мэт тодорхой төсөл, биет хөрөнгөд чиглээгүй, эсвэл ирээдүйд хөрөнгө оруулалт хийхэд хүргэх тохиолдолд орлогын санал болгож буй зарцуулалт, байгаль орчин, нийгмийн үл мөр нь ЕСБХБ-ны хөрөнгө оруулах шийдвэр гаргах үед үндсэндээ тодорхойгүй байна. Иймд Банк: (i) тухайн салбараас хамаарах эрсдэл, нөлөөлөл, бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдалд үндэслэн хөрөнгө оруулалтыг үнэлж; (ii) харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг ГШ-д нийцүүлэн зохицуулах хүчин чадавх, үүрэг амлалтыг үнэлнэ.
- 4.10. Хэрэв төсөл нь олон салбартай компанид зориулсан компанийн ерөнхий санхүү, эргэлтийн хөрөнгө буюу өмчийн санхүүжилттэй холбоотой, орлогын зарцуулалтыг тодорхой биет хөрөнгөд зориулаагүй бол зээлдэгч нь өөрийн компанийн байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог ГШ-д нийцүүлэх, мөн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдлийг удирдах чиглэлд компанийн түвшинд авах арга хэмжээг боловсруулах шаардлага тулгарна.

⁶ ЕСБХБ-ны төслүүдийг “шууд хөрөнгө оруулалтын төсөл”, “санхүүгийн зуучлалын (СЗ) төсөл” гэж хуваадаг. СЗ төслийн хувьд шууд харилцагч нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө оруулалтын сан, эсвэл ижил төстэй байгууллага байна. Бусад төслүүд нь шууд хөрөнгө оруулалтын төсөлд тооцогдоно.

- 4.11. Хөрөнгийн зах зээлийн арилжаанд⁷ захиалгын өмнө болон дараа байгаль орчин, нийгмийн баримт бичгийг нийтэд ил тод болгохдоо бүртгэлтэй үнэт цаасыг материаллаг, олон нийтэд нээлттэй бүс мэдээлэлд үндэслэн арилжаалахаас сэргийлсэн хөрөнгийн зах зээлийн холбогдох дүрэм, журам болон хөрөнгө оруулагчдад тэгш хандахтай холбоотой зарчмуудыг дагаж мөрдөнө. Хөрөнгийн зах зээлийн арилжааны шинж чанараас шалтгаалан Банкны байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь эрсдэлд суурилсан байх болно. Бизнесийн үйл ажиллагаатай (мөн хөрөнгийн зах зээлийн ийм гүйлгээгээр босгосон орлогоор санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдтэй) холбоотой байгаль орчны ба/буюу нийгмийн эрсдлийг зохицуулах чиглэлд харилцагчийн чадавх, үүрэг амлалтыг холбогдох үндэсний хууль тогтоомж, ОУСТ болон ГШ-ын дагуу үнэлэхийн тулд зөвхөн олон нийтэд нээлттэй мэдээлэлд найдах шаардлага тулгарч болох юм. Үнэлгээгээр бэлэн байгаа мэдээлэл нь төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл болон ГШ-д нийцсэн байдлыг тодорхойлоход хангалттай эсэхийг тогтооно. Захиалга хийсний дараа Банк харилцагчдаас ГШ-ыг дагаж мөрдөхийг шаардана. Өндөр эрсдэлтэй төсөл болон “А” ангиллын төслийг хөрөнгийн зах зээлийн хэрэгслээр санхүүжүүлэхгүй.
- 4.12. Баригдаж эхэлсэн төслийг санхүүжүүлэх, эсвэл тухайн эзэн орноос зөвшөөрөл авсан, түүний дотор байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь батлагдсан төслийг санхүүжүүлэх хүсэлт хүлээн авбал Банкны гүйцэтгэх үнэлгээнд ЕСБХБ-ны шаардлагыг хангахын тулд нэмэлт судалгаа хийх, нөлөөллийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах хэрэгтэй эсэхийг тогтоох зорилгоор тухайн төслийг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлж буй байдлыг ГШ-тай харьцуулсан дүн шинжилгээ багтана.
- 4.13. ЕСБХБ-ны үнэлгээ нь зээлдэгчдээс төсөлд өртсөн байж болзошгүй болон/эсвэл төслийг сонирхож магадгүй оролцогч талуудыг тодорхойлох, төслөөс үүсэх эрсдэл, нөлөөллийн талаар хангалттай мэдээллийг ил болгох, оролцогч талуудтай үр дүнтэй, соёлын хувьд зохистой байдлаар харилцахыг шаарддаг. Ялангуяа, ЕСБХБ нь харилцагчдаа төслийн нөлөөнд өртсөн хүмүүс болон холбогдох оролцогч талуудтай харилцах, ингэхдээ төсөлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл ба оролцогч талуудын сонирхлын түвшинтэй уялдуулах шаардлага тавьдаг. БОННУ-нд хамрагдах ёстой, байгаль орчинд ихээхэн нөлөөлөл үзүүлэх боломжтой төслүүдийн хувьд НҮБ-ын Европын Эдийн Засгийн Хорооны Мэдээллийн хүртээмж, Шийдвэр гаргалтанд олон нийтийн оролцоо, Байгаль орчны асуудлаарх шударга ёсыг хангах тухай конвенцын үзэл санаа, зарчмуудыг харгалзан тэдгээр оролцогч талуудын оролцоог хангана. Олон улсын хилээр нэвтрэн байгаль орчинд ихээхэн нөлөө үзүүлэх боломжтой төслийн хувьд Банк тухайн төслийн газарзүйн байршлаас үл хамааран, Хил дамнасан нөхцөл байдалд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийхдээ НҮБ-ын Европын Эдийн Засгийн Хорооны конвенцын арга хандлагыг баримтлахыг дэмжих болно. Банк зарим тохиолдолд оролцогч талуудын үзэл бодлыг сонсох зорилгоор өөрийн гэсэн олон нийтийн зөвшилцөх үйл ажиллагааг зохион байгуулж болно.

- 4.14. СЗ-ын төслүүдийн тухайд ЕСБХБ нь дараах чиглэлүүдэд үнэлгээ хийх зорилгоор СЗ болон тэдний багцад зохих магадлан шалгалтыг явуулна. Үүнд: (i) СЗ-ын одоо байгаа байгаль орчин, нийгмийн бодлого, журам, түүнийг хэрэгжүүлэх чадавх; (ii) СЗ-ын одоо байгаа багц болон ирээдүйд хүлээгдэж буй төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл; болон (iii) СЗ-ын одоо байгаа байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ.

Шийдвэр гаргалт

- 4.15. ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөлд буюу хэрэв Захирлуудын Зөвлөл зөвшөөрөл олгох бүрэн эрхээ Банкны удирдлагад шилжүүлсэн бол тухайн удирдлагад хүргүүлсэн төслийг батлахад зориулагдсан баримт бичигт байгаль орчин, нийгмийн үнэлгээний тодорхойлолт, бодитой эрсдэл ба нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааны хураангуй болон зээлдэгч төслийн эрсдэл, нөлөөллийг хэрхэн шийдвэрлэж байгаа буюу шийдвэрлэх тухай мэдээлэл багтана. Захирлуудын Зөвлөл эсвэл Банкны удирдлагын аль хамаарах нь төслийн нийт үр шим, эрсдлийг үнэлэх үйл ажиллагааны хүрээнд шийдвэр гаргахдаа оролцогч талуудын санал, хүсэлтийг харгалзан үзнэ.
- 4.16. ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөл нь ЕСБХБ-ны санхүүжилтийн нөхцөл болгон байгаль орчин, нийгмийн үнэлгээний тодорхой элементүүдийг Захирлуудын Зөвлөл баталж, санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурсны дараа гүйцэтгэхээр тохиролцож болно. Зөвлөл санал болгож буй аргын нийт үр нөлөөлөл, эрсдэл, ашиг тусыг авч үзнэ. Төсөл ийм нөхцөлтэйгөөр батлагдсан тохиолдолд Төслийн хураангуй баримт бичигт арга аргачлалын тайлбар тодорхойлолтыг оруулна.

Хууль эрх зүйн баримт бичиг

- 4.17. Төслийн талаар ЕСБХБ-ны харилцагчидтай хийх санхүүжилтийн гэрээнд ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн шаардлагыг тусгасан тодорхой заалтууд орно. Үүнд холбогдох бүх ГШ-ыг дагаж мөрдөх, түүнчлэн байгаль орчин, нийгмийн асуудлаарх тайлагнал, оролцогч талуудын оролцоо, хяналт шинжилгээнд хамаарах заалтууд орно. Эрх зүйн баримт бичигт зээлдэгч ба хөрөнгө оруулагч компани нь санхүүжилтийн гэрээний шаардлагад нийцүүлэн байгаль орчны болон нийгмийн заалтуудыг хэрэгжүүлээгүй бол Банкны зүгээс шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэх эрх ба/буюу авах арга хэмжээг мөн тусгана.

Хяналт шинжилгээ

- 4.18. ЕСБХБ нь өөрийн санхүүжүүлсэн шууд санхүүжилттэй болон СЗ-ын төслүүд энэхүү Бодлогын зорилтуудад нийцэж байгаа эсэхийг Банк тухайн төсөлд санхүүгийн ашиг сонирхолтой байх хугацаанд хянаж, үнэлнэ. Хяналт үнэлгээний хэр хэмжээ нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй дүйцэхүйц байна. ЕСБХБ нь төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэл, БОНУАТ-ний хэрэгжилт, мөн харилцагч үйл ажиллагаагаа санхүүжилтийн гэрээнд тусгагдсан байгаль орчин, нийгмийн гэрээ хэлцэлд хэрхэн нийцүүлж байгааг харуулах жил бүрийн байгаль орчин, нийгмийн тайланг хянан үздэг. Хэрэв зээлдэгч санхүүжилтийн гэрээнд

⁷ Хөрөнгийн зах зээлийн арилжаа гэдэгт биржид бүртгэлтэй бонд болон жувьцаа зэрэг олон нийтэд нээлттэй зарлагдсан үнэт цаасны арилжаа болон олон нийтэд нээлттэй зарлагдаагүй, харин материаллаг, олон нийтэд нээлттэй бүс мэдээллийн үндсэн дээр арилжаалахыг нь хязгаарласан хөвөөр байгаа үнэт цаасны арилжааг авч үзнэ.

заасан нийгэм, байгаль орчны авсан үүрэг амлалтаа биелүүлээгүй бол ЕСБХБ нь эзэлдэгчийн зүгээс нийцүүлэхийн тулд авах шаардлагатай залруулах арга хэмжээнүүдийг хэлэлцэн тохиролцож болно. Зээлдэгч нь тохиролцсон залруулах арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд Банк шаардлагатай гэж үзвэл ийм арга хэмжээ авах ба/буюу санхүүжилтийн гэрээнд заасан эрх болон/эсвэл залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой. Мөн ЕСБХБ нь Банкны байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд болон/эсвэл бие даасан шинжээчдийг төсөлтэй газар дээр нь танилцуулах замаар зээлдэгчдийн бэлтгэсэн хяналт шинжилгээний мэдээллийг үе үе шалган баталгаажуулж болно. Зээлдэгчтэй холбоотой хэрэг зарга хараахан эцэслэн шийдэгдээгүй үед Банкны хяналт тавих боломж хязгаарлагдаж болох юм.

Үйл ажиллагааны өөрчлөлт

- 4.19. ЕСБХБ зөвшөөрч, санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурсны дараа төслийн мөн чанар, хамрах хүрээнд өөрчлөлт орж болно. Тэрхүү өөрчлөлт нь түүнтэй холбоотой байгаль орчны болон нийгмийн чухал үр дагавартай байж болно. Энэ мэт материаллаг өөрчлөлт орно хэмээн төсөөлж байгаа үед Банк нь холбогдох өөрчлөлтийн байгаль орчин, нийгмийн үнэлгээг энэхүү Бодлого, бусад нэмэлт үнэлгээ болон оролцогч талуудын оролцоонд тавигдах шаардлагуудын дагуу хийх бөгөөд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг төслийн өөрчилсөн/шинэчлэн найруулсан баримт бичигт тусгана. Үйл ажиллагааны өөрчлөлт нь байгаль орчны ба/буюу нийгмийн хувьд Захирлуудын Зөвлөлийн баталснаас материаллаг байдлаар эрс ялгаатай нөхцөл байдалд хүргэх тохиолдолд уг өөрчлөлтийн талаар Банкны удирдлагад мэдэгдэж, шаардлагатай бол ЕСБХБ-ны холбогдох бодлогод нийцүүлэн мэдээлэл өгөх, зөвшөөрөл авах зорилгоор Захирлуудын Зөвлөлд танилцуулна.

5. ЕСБХБ-ны олон нийтэд тайлагнах, хариуцлага хүлээх үүрэг

- 5.1. ЕСБХБ нь ил тод байдал, хариуцлагатай байдал, оролцогч талуудын оролцоог хангах зарчмуудыг баримталдаг. Банк өөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон дотоод үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн асуудал, мөн энэхүү Бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг агуулсан тогтвортой байдлын тайланг жил тутам гаргана. Банк нь ЕСБХБ-ны Мэдээллийн Хүртээмжийн Удирдамж (МХУ)-ийн дагуу холбогдох оролцогч талуудтай үр дүнтэй ариа хэлэлцээ хийнэ. ЕСБХБ харилцагчдынхаа дунд ижил төстэй сайн түршлагыг хөхиүлэн дэмжих болно.
- 5.2. Банк нь ЕСБХБ-ны МХУ-ийн зохих заалтуудын дагуу төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн талаарх мэдээллийг Төслийн хураангуй баримт бичигт тоймлон оруулна.
- 5.3. ЕСБХБ-ны хариуцлагын тогтолцоо болох Төслийн бие даасан хариуцлагын механизм нь Банкны төслийн улмаас хор хохирол амссан хувь хүн, байгууллага, бүлгүүдэд банкны үйл ажиллагаанаас хамааралгүйгээр гомдол гаргах, асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа авах боломжийг олгодог. Хэрэв хувь хүмүүс болон бүлгүүд Банкыг энэхүү Бодлого болон МХУ-ийн төсөлд хамаарах бүрэлдэхүүн хэсгүүдийг дагаж мөрдөөгүй гэж үзвэл үүнийг гомдол гаргахдаа ашиглаж болно.

6. Байгууллага болон хэрэгжилтийн зохицуулалт

- 6.1. Дээр дурдсан стратегийн чиглэлүүдийг хангалттай тусгах үүднээс ЕСБХБ нь энэхүү Бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэг хариуцлага, зохих нөөцийг хуваарилна. Банк нь байгаль орчин, нийгмийн үнэлгээ, хяналт шинжилгээний үйл явцыг хянах, байгаль орчин, нийгэмд тустай төслүүдийг санаачлах, хөгжүүлэхэд шаардагдах боловсон хүчний нөөцийг бүрдүүлнэ.
- 6.2. ЕСБХБ нь энэхүү Бодлогыг хэрэгжүүлэхэд туслах байгаль орчин, нийгмийн журам, зохих заавар зөвлөмж, арга хэрэгслийг боловсруулж, хэвшүүлэх бөгөөд ажилтнуудыг энэхүү Бодлогын шаардлагын талаар зохих сургалтад хамрагдах нөхцлийг хангана.
- 6.3. ЕСБХБ цаашид бодлоготой холбоотой ерөнхий асуудлууд болон салбарын бодлого, стратегийг эцэслэхээсээ өмнө Байгаль орчин, Нийгмийн Зөвшилцөх Зөвлөлийн санал зөвлөмжийг тусгаж, тус Зөвлөлөөс дэмжлэг туслалцаа авсаар байх болно. Мөн ЕСБХБ-ны төсөл, үйл ажиллагаатай холбоотой тодорхой асуудлуудаар Зөвлөлийн саналыг авч болно.

7. Хавсралт

ГШ.1-ээс 10-ын агуулга нь энэхүү Бүлэг III-т багтсан.

Бүлэг IV: Татгалзал, Үл хамаарах зүйл ба Нийтэд ил болгох

1. Татгалзал

Захирлуудын Зөвлөл нь энэхүү Бодлогын нөхцлөөр илэрхий зөвшөөрөгдөөгүй Бодлогын шаардлагыг дагаж мөрдөхгүй байхыг зөвшөөрч болно.

2. Үл хамаарах зүйл

Энэхүү Бодлого нь ЕСБХБ-наас санхүүжүүлсэн ба/буюу хэрэгжүүлдэг зөвлөх үйлчилгээ, орон нутгийн иргэд, олон нийтийн санаачилгын төсөл, бодлогын яриа хэлэлцээ, техникийн хамтын ажиллагаа, мөн ЕСБХБ-ны засаглал, захиргаа болон шийдвэр гаргах үйл явцад хамаарахгүй.

3. Нийтэд ил болгох

Энэхүү Бодлогыг Захирлуудын Зөвлөлөөр батлагдсан даруйд Банкны вэб хуудсанд байршуулан олон нийтэд ил болгоно.

Бүлэг V: Шилжилтийн үеийн заалтууд

Энэхүү Бодлого хүчин төгөлдөр болохоос өмнө Банкны удирдлагаас⁸ эхний шатны зөвшөөрөл авсан төслүүд нь тухайн төслийг анх батлагдах үед хүчин төгөлдөр байсан бодлогыг дагаж мөрдөнө.

Бүлэг VI: Хүчин төгөлдөр болох огноо

Энэхүү Бодлого нь 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

Бүлэг VII: Шийдвэр гаргалтын хүрээ

Хариуцагч

Эрсдэл ба Хянан нийцүүлэлт хариуцсан Дэд Ерөнхийлөгч энэхүү Бодлогыг боловсруулах ажлыг хариуцна.

Үүрэг хүлээгч

Байгаль орчин, Тогтвортой байдлын Газрын Гүйцэтгэх Захирал нь энэхүү Бодлогын хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ.

Бүлэг VIII: Үнэлгээ ба тайлагнал

1. Үнэлгээ

Энэхүү Бодлогын баримт бичигт 2024 онд олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар үнэлгээ хийх ёстой.

Захирлуудын Зөвлөл нь энэхүү Бодлогын шинэчилсэн найруулгыг хэрэв түүнд багтсан өөрчлөлт нь шинж чанар, хэмжээний хувьд их биш буюу эсвэл Банкны олон нийтийн хэлэлцүүлэгт хамрагдсан өөр нэг Бодлогод орсон өөрчлөлтийн улмаас бий болсон бол аль ч шатанд олон нийтээр хэлэлцүүлэлгүйгээр баталж болно.

2. Тайлагнал

Хамааралгүй.

Бүлэг IX: Холбогдох баримт бичиг

Мэдээллийн Хүртээмжийн Бодлого (2019) болон Мэдээллийн Хүртээмжийн Удирдамж (2019)

Төслийн Хариуцлагын Бодлого (2019) болон Төслийн Хариуцлагын Хараат бүс Механизм: Удирдамж (2019)

⁸ Энэхүү Бодлогыг батлах үед шууд болон СЗ-ын хөрөнгө оруулалтын хувьд эхний зөвшөөрлийг “Үзэл баримтлалын үнэлгээ” гэнэ.

Хавсралт 1 : ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалт

ЕСБХБ нь доорх чиглэлийн үйл ажиллагаануудад ЕСБХБ-ны санхүүжилтийг зарцуулах аливаа төсөлд зориудаар шууд эсвэл СЗ-аар дамжуулан шууд бусаар санхүүжилт олгохгүй. Үүнд:

- а. Хүлээн авагч улсын (өөрөөр хэлбэл үндэсний) хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, конвенцын дагуу хууль бусад тооцогддог, эсвэл олон улсад зогсоох буюу хориг тавихаар хугацаа заасан дараах бүтээгдэхүүн, эсвэл үйл ажиллагааг үйлдвэрлэх, худалдаалах. Үүнд:
 - (i) ПХБ⁹ агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа
 - (ii) Эм, пестицид/гербицид болон бусад аюултай бодисын¹⁰ үйлдвэрлэл, худалдаа
 - (iii) Озон задалдаг бодисын¹¹ үйлдвэрлэл, худалдаа
 - (iv) Удаан задардаг органик бохирдуулагчийн¹² үйлдвэрлэл, ашиглалт
 - (v) Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)¹³-оор зохицуулагддаг зэрлэг амьтан ба ургамлын худалдаа, зэрлэг амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа
 - (vi) Олон улсын нийтийн эрх зүйн¹⁴ хүрээнд хориглогдсон хог хаягдлын хил дамнуулсан тээвэрлэлт
- б. Албадан нүүлгэх¹⁵
- в. Эрчим хүчний нүүрс олборлолт буюу нүүрсээр галладаг цахилгааны эх үүсвэрийн хүчин чадал
- г. Газрын тосны хайгуул, өрөмдлөг, олборлолтын дээд түвшний (upstream) үйл ажиллагаа
- д. Төслийн орлогыг зөвхөн хүлэмжийн хийн ялгаруулалт, эсвэл одоо байгаа олборлох талбайн шаталтыг бууруулахад зарцуулах ховор, онцгой тохиолдлоос бусад газрын тосны хайгуул, өрөмдлөг, олборлолтын төслүүд

- е. Нугас, галууг хүчээр тэжээх үйл ажиллагаа
- ё. Үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн, эсвэл үслэг эдлэл үйлдвэрлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагааны үндсэн зориулалтаар амьтныг тэжээх
- ж. Асбест болон орц найрлаганд нь асбестыг зориудаар нэмсэн¹⁶ бараа бүтээгдэхүүн, хольцыг үйлдвэрлэх, зах зээлд байршуулах, ашиглах
- з. Мөнгөн үс болон мөнгөн усны нэгдлийн экспорт, мөн мөнгөн үс агуулсан олон төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт, импорт¹⁷
- и. Биологийн олон янз байдлын нөөц, соёлын өвийг хамгаалахтай холбоотой хүлээн авагч улсын хууль тогтоомж эсвэл олон улсын конвенцоор хориглосон үйл ажиллагаа
- й. Далайн орчинд 2.5 км-ээс дээш урттай хөвөгч тор ашиглан загас барих
- к. Олон улсын далайн байгууллага (IMO)-ын шаардлагыг хангаагүй¹⁸ усан онгоцонд тос болон бусад аюултай бодис тээвэрлэх
- л. Экспорт, импортын зохих зөвшөөрөлгүй, эсвэл холбогдох экспортлох, импортлох, шаардлагатай бол, дамжин өнгөрөх улсаас дамжин өнгөрөхийг зөвшөөрсөн бусад нотлох баримтгүй барааг худалдаалах.

⁹ ПХБ: полихлорт бифенил нь химийн маш хортой бодисуудын бүлэг юм. ПХБ нь 1950-1985 онд үйлдвэрлэгдсэн тосоор ажилладаг цахилгаан трансформатор, конденсатор, хуваарилах төхөөрөмжөөс илэрдэг.

¹⁰ Лавлагаа баримт бичиг: Европын Холбооны Парламент болон Зөвлөлийн Химийн аюултай бодисын экспорт, импортын тухай 2012 оны 7-р сарын 4-ний өдрийн 649/2012 тоот журам (EX), тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулснаар; Нэгдсэн Үндэстний Байгууллагын хэрэглэх ба/буюу борлуулахыг хориглосон, буцаан татсан, хатуу хязгаарласан эсвэл Засгийн газраас зөвшөөрөөгүй бүтээгдэхүүний нэгдсэн жагсаалт; Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц; Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан Пестицидийг аюулаар нь ангилах тухай зөвлөмж.

¹¹ Озон задалдаг бодис (ОЗБ): Давхраат мандлын задарсан озонтой урвалд орсноор олон нийтийн мэдэх "озоны цорхой" -г үүсгэдэг химийн нэгдлүүд. Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протоколд ОЗБ ба тэдгээрийн хэрэглээний зорилтот бууралт, үе шаттайгаар хэрэглээнээс бүрэн халах хугацааг жагсаасан байна. Монреалын протоколоор зохицуулагддаг аэрозоль, хөргөгч бодис, хөөс үүсгэгч бодис, уугагч, галаас хамгаалах бодис зэрэг химийн нэгдлүүдийн жагсаалтыг уг протоколд гарын үсэг зурсан улс орнуудын талаарх болон ОЗБ-ын хэрэглээг зогсоох зорилтот хугацааны тухай мэдээллийн хамт НҮБ-ын Байгаль орчны Хөтөлбөрөөс авах боломжтой.

¹² Лавлагаа баримт бичиг: Удаан задардаг органик бохирдуулагч (УЗОБ)-ийн тухай Стокгольмын конвенц, 2009 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар.

¹³ CITES: Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц. CITES конвенцод багтсан төрөл зүйлсийн талаарх мэдээллийг CITES-ын Ажлын албанаас авах боломжтой.

¹⁴ Лавлагаа баримт бичиг: Аюултай хог хаягдлыг жил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хянал тавих тухай Базелийн конвенц; Хог хаягдлыг тээвэрлэх тухай 2006 оны 6-р сарын 14-ний өдрийн 1013/2006 тоот журам (E3); болон Нөхөн сэргээх үйл ажиллагаанд зориулагдсан хог хаягдлын хил дамнан тээвэрлэлтийг хянах тухай C(92)39 тоот Эцсийн шийдвэрийг өөрчлөх тухай ЭЗХАХБ-ын Зөвлөлийн C(2001)107 тоот Эцсийн шийдвэр.

¹⁵ "Албадан нүүлгэх" гэж хувь хүн, бүлэг, олон нийтийг эзэмшиж байгаа орон сууц ба/буюу хамааралтай байгаа газар, нийтийн өмчийн эх үүсвэрээс бүрмөсөн эсвэл түр хугацаагаар албадан буюу хүчээр нүүлгэн шилжүүлэх, улмаар тухайн хувь хүн, бүлэг, олон нийтийг зохих хэлбэрийн хууль эрх зүйн болон бусад хамгаалалтаар хангахгүйгээр тодорхой сууц, оршин суух газар, эсвэл байршилд оршин суух эсвэл ажиллах боломжийг нь хязгаарласан эсвэл үгүй хийсэн үйлдэл ба/буюу эс үйлдэхгүйг хэлнэ.

¹⁶ Асбест (кризотил)-ийн хувьд Химийн бодисын бүртгэл, үнэлгээ, зөвшөөрөл, хязгаарлалт (REACH)-ын талаарх Европын Холбооны Парламент болон Зөвлөлийн 1907/2006 тоот Журмын Хавсралт XVII-г өөрчлөх тухай Европын Комиссын 2016 оны 6-р сарын 22-ны өдрийн 2016/1005 тоот журам (EX).

¹⁷ Европын Холбооны Парламент болон Зөвлөлийн мөнгөн усны талаарх 2017 оны 5-р сарын 17-ны өдрийн 2017/852 тоот журам (EX).

¹⁸ Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай олон улсын конвенц (SOLAS) -ын гэрчилгээ (Олон улсын аюулгүй байдлын удирдлагын дүрэмд нийцсэнийг гэрчлэх гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй), Европын Холбооны хар жагсаалтад орсон, эсвэл Боомтын улсын хяналтын тухай Парисын харилцан ойлголцлын санамж бичиг (Парисын санамж бичиг)-ээр хориглосон шингэн тээвэрлэгч хөлөг онгоц, мөн Далайг хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай олон улсын конвенц (MARPOL) -ын 13G журмын дагуу ашиглалтаас хасагдах хөлөг онгоцнууд багтана. Их бие нь 25 жилээс дээш насжилттай хөлөг онгоцыг ашиглах ёсгүй.

Хавсралт 2: “А” ангиллын төслүүд

Энэхүү жагсаалт нь доор жагсаасан ангилалд багтах “ногоон талбай”, эсвэл томоохон өргөтгөл буюу хувиргалт-өөрчлөлтийн төслүүдэд хамаарна. Доор жагсаасан төслийн төрлүүд нь байгаль орчинд ба/буюу нийгэмд ихээхэн хэмжээний нэмэлт болон шинэ нөлөөлөл үүсгэж болзошгүй бөгөөд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ шаардлагатай төслүүдийн жишээ юм. Төсөл бүрийг хэрхэн ангилах нь тухайн төслийн шинж чанар, байршил, эмзэг байдал, цар хүрээний онцлогоор тодорхойлогдох нэмэлт, шинэ хэлбэрийн байгаль орчин, нийгмийн бодит болон болзошгүй нөлөөллийн шинж чанар, ач холбогдлоос хамаарна.

- Газрын тос боловсруулах үйлдвэрүүд (газрын тосноос зөвхөн тосолгооны материал үйлдвэрлэх үйлдвэрээс бусад) болон өдөрт 500 тонн ба түүнээс дээш хэмжээний нүүрс болон битүмэн занарыг хийжүүлэх, шингэрүүлэх байгууламжууд
- 300 мегаватт¹⁹ ба түүнээс дээш хэмжээний хүчин чадалтай дулааны цахилгаан станцууд болон бусад эрчим хүч үйлдвэрлэгч байгууламжууд, цөмийн цахилгаан станцууд болон бусад цөмийн реакторууд, мөн тэдгээр цахилгаан станц буюу реактор (хамгийн дээд хүчин чадал нь 1 киловаттын тасралтгүй дулааны ачааллаас хэтрэхгүй, задран хуваагдах чадвартай, үржил шимт материалыг үйлдвэрлэх, хувиргах судалгааны байгууламжаас бусад)-ыг салгах, ашиглалтаас гаргах ажиллагаа
- (а) Цацрагжуулсан цөмийн түлшийг дахин боловсруулах байгууламжууд; болон (б) дараах зориулалттай байгууламжууд: (i) цөмийн түлшний үйлдвэрлэл, баяжуулалт; (ii) цацрагжуулсан цөмийн түлш болон өндөр цацраг идэвхт хаягдлын боловсруулалт; (iii) цацрагжуулсан цөмийн түлшний эцсийн устгал; (iv) зөвхөн цацраг идэвхт хаягдлын эцсийн устгалд ашиглах; мөн (v) зөвхөн цацрагжуулсан цөмийн түлш болон цацраг идэвхт хаягдлыг үйлдвэрлэлийн байрнаас өөр газарт хадгалах (10 жилээс дээш хугацаагаар хадгалах төлөвлөгөөтэй)
- Ширэм болон ганг анхлан хайлуулах нэгдсэн ажиллагаа; хүдэр, баяжмал, эсвэл хоёрдогч түүхий эдээс металлургийн, химийн болон электролитийн аргаар өнгөт түүхий металл үйлдвэрлэхэд зориулсан байгууламж
- Химийн нэгдмэл байгууламж, тухайлбал дотроо зэрэгцүүлэн байрлуулсан бөгөөд бие биетэйгээ функциональ холбоотой хэд хэдэн нэгж бүхий, тэдгээр нь үндсэн органик химийн бодисууд; үндсэн органик бүс химийн бодисууд; фосфор, азот эсвэл кали дээр суурилсан бордоо (энгийн эсвэл нийлмэл бордоо); ургамлын эрүүл мэндэд тустай үндсэн бүтээгдэхүүн болон биоцид; химийн эсвэл биологийн үйл явц ашиглан гаргаж авсан эмийн үндсэн бүтээгдэхүүн; эсвэл тэсрэх бодис үйлдвэрлэхэд зориулсан химийн хувиргах үйл явцыг ашиглан бодисыг аж үйлдвэрийн хэмжээнд үйлдвэрлэх байгууламж
- Холын зайн төмөр замын хөдөлгөөнд зориулсан шугамын барилга угсралт; 2100 метр ба түүнээс дээш урттай хөөрөх, буух зурвас бүхий нисэх онгоцны буудлууд; авто зам, хурдны зам болон дөрөв ба түүнээс дээш эгнээтэй шинэ зам, эсвэл одоо байгаа замыг 4 ба түүнээс дээш эгнээтэй болгохын тулд шинэчлэх ба/буюу өргөтгөх, тэдгээр шинэ зам, эсвэл замын шинэчилсэн ба/буюу өргөтгөсөн хэсэг нь 10 км болон түүнээс дээш тасралтгүй үргэлжилсэн урттай байх
- 800 мм-ээс дээш голчтой, 40 км-ээс дээш урттай дамжуулах хоолой, хий, газрын тос, химийн бодисыг их хэмжээгээр тээвэрлэх терминал ба тэдгээртэй холбоотой байгууламжууд, эсвэл геологийн аргаар хадгалах зориулалтаар нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂)-ийн урсгалыг тээвэрлэх терминал, тэдгээртэй холбоотой байгууламжууд, тухайлбал хүчдэл нэмэгдүүлэх станцууд
- Геологийн аргаар хадгалах зориулалтаар нүүрстөрөгчийн давхар ислийг агуулах сайтууд
- Жилд нийт 1.5 мегатонн ба түүнээс их хэмжээний CO₂-ийг хуримтлуулах хүчин чадалтай, геологийн агуулахад зориулсан CO₂-ийн урсгалыг барих байгууламжууд
- Томоохон хэмжээний далайн боомт, улс орны дотоодын усан зам болон боомт, худалдааны боомт, газартай холбогдсон ачиж буулгах усан зогсоол, гадна боомтууд (гаталгат онгоцны зогсоолоос бусад)
- Аюултай, хортой, хор хөнөөлтэй хог хаягдлыг шатаах, химийн аргаар боловсруулах, бүлж устгах зориулалттай хог боловсруулах, зайлуулах байгууламжууд
- Өдөрт 100 тонноос дээш хэмжээний энгийн хог хаягдлыг шатаах, химийн аргаар боловсруулах хүчин чадалтай, хог хаягдал зайлуулах томоохон хэмжээний байгууламжууд
- Хуримтлуулсан буюу хадгалсан шинэ болон нэмэлт усны хэмжээ 10 сая шоо метрээс давсан үед усыг тогтоох буюу байнга хадгалах зориулалттай том²⁰ далан болон бусад байгууламжууд
- Жилд олборлох, цэнэглэх усны хэмжээ 10 сая шоо метр буюу түүнээс дээш бол газрын доорх ус олборлох ажиллагаа, эсвэл газрын доорх усыг зохиомлоор цэнэглэх схем
- Усны хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор голын сав газруудын хооронд усны нөөцийг шилжүүлэх ажиллагаа бөгөөд тийнхүү шилжүүлсэн усны хэмжээ жилд 100 сая шоо метрээс давсан тохиолдолд, эсвэл олборлох сав газрын усны урсгал нь олон жилийн дунджаар жилд 2000 сая шоо метрээс давсан голын сав газруудын хооронд усны нөөцийг шилжүүлэх ажиллагаа ба шилжүүлсэн усны хэмжээ нь тэрхүү урсгалын 5 хувиас хэтэрсэн тохиолдолд. (Хоёр тохиолдолд хоёуланд нь ундны усыг хоолойгоор дамжуулахыг оруулаагүй болно.)
- (i) Мод эсвэл ижил ширхэгтэй материалаас зөөлөн эдийг нь авч боловсруулах; (ii) өдөрт 200-аас дээш метр-тонн салхинд хатаасан цаас болон банз үйлдвэрлэх хүчин чадалтай аж үйлдвэрүүд
- Талбайн гадаргуугийн хэмжээ нь 25 га-аас хэтэрсэн карьер болон ил уурхайн үйл ажиллагаа, эсвэл гадаргуу нь 150 га-аас дээш хэмжээтэй талбайгаас хүлэр олборлох ажиллагаа

¹⁹ Уурын болон нэг эргэлтэй хийн турбин цахилгаан станцын 140 мВт цахилгаан эрчим хүчтэй тэнцэнэ.

²⁰ Том далангийн олон улсын комисс (ТДОУК)-ын тодорхойлсноор том даланд суурьнаасаа дээш 15 м болон түүнээс илүү өндөр өргөгдсөн далан орно. Өндрөөрөө 5м-15м боловч хадгалах усны багтаамж нь 3 сая шоо метрээс илүү бол тухайн даланг мөн том даланд тооцно.

18. Газрын тосны хувьд өдөрт 500 тонноос давсан, байгалийн хийн хувьд өдөрт 500,000 шоо метрээс хэтэрсэн хэмжээтэйгээр арилжааны зориулалтаар олборлох
19. 200,000 тонн ба түүнээс дээш хэмжээтэй газрын тос, нефтийн гаралтай химийн бодис, эсвэл химийн бодисыг хадгалах хүчин чадал бүхий байгууламж
20. Их хэмжээний мод бэлтгэх, эсвэл их хэмжээний ой мод устгах үйл ажиллагаа
21. Хот, суурин газрын 150,000-аас дээш хүн амын ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламж
22. Хотын хатуу хог хаягдал боловсруулж устгах томоохон хэмжээний байгууламжууд
23. Өргөн хүрээтэй аялал жуулчлал ба жижиглэн худалдааг хөгжүүлэх үйл ажиллагаа
24. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралт
25. Салхины эрчим хүчний томоохон чадлын эх үүсвэрүүд (салхин цахилгаан станц)
26. Томоохон хэмжээний талбай бүхий газрын хөрс сайжруулалт, далайн ёроолын хөрсний бохирдлыг хамж авах ажиллагаа
27. Эрчимжсэн тариалалт хийх, газар ашиглалтын зориулалтыг өөрчлөх, эсвэл биологийн олон янз байдлын чухал төрөл зүйлс, амьтан ургамлын амьдрах орчныг өөрчлөх зэрэг үйл ажиллагааг багтаасан томоохон хэмжээний анхан шатны хөдөө аж ахуйн буюу ойжуулалтын үйл ажиллагаа
28. Өдөрт 12 тонноос илүү эцсийн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай арьс шир боловсруулах үйлдвэрүүд
29. (а) 85,000 дэгдээхий, 60,000 өндөглөгч тахианы байр; (б) 30 кг-аас дээш жинтэй 3,000 гахайны байр; эсвэл (в) 900 мэгжний байрнаас дээш хүчин чадалтай гахай, тахиаг эрчимтэй өсгөх байгууламжууд
30. Хэдийгээр тухайн төслийн ангилал энэ жагсаалтад ороогүй боловч олон улсын, үндэсний эсвэл орон нутгийн ач холбогдол бүхий эмзэг байршилд өнгөрсөн, одоогийн ба үндэслэлтэйгээр урьдчилан таамаглах боломжтой холбогдох бусад үйл явдлуудтай хавсарсан хуримтлагдсан нөлөөлөл зэрэг мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлж болзошгүй буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүд²¹. Тийм эмзэг байршил гэдэгт тухайлбал, хуулиар хамгаалагдсан ба/буюу олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үндэсний засгийн газраас ийм статус олгохоор санал болгосон тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдлын чухал төрөл зүйлсийг дэмжих чухал амьдрах орчин буюу бусад экотогтолцоо, археологийн эсвэл соёлын ач холбогдолтой газар нутаг, мөн нутгийн уугуул иргэд, эсвэл бусад эмзэг бүлгийн хүмүүсийн хувьд чухал бүс нутаг багтана.
31. Төслийн шууд болон шууд бус нөлөөнд өртсөн буюу өртөж болзошгүй хувь хүн, бүлэг хүмүүст нийгмийн ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төслүүд
32. Их хэмжээгээр албадан нүүлгэн суурьшуулах, эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэх, хохирол дагуулж болзошгүй төслүүд.

²¹ Үүнд байгаль орчны буюу нийгмийн зорилго бүхий (усны эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч зэрэг) төслүүд багтана, гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, удирдлага

Танилцуулга

1. Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох цогц үнэлгээ хийх, мөн зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг хангах нь ихээхэн чухал болохыг онцлон тэмдэглэсэн болно. Амжилттай, үр ашигтай байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо (БОНУТ) нь байгаль орчин, нийгмийн зохистой болоод тогтвортой гүйцэтгэлийг хөхиүлэн дэмждэг бөгөөд санхүүгийн, байгаль орчны болон нийгмийн үр дүнг сайжруулахад эерэгээр нөлөөлөх боломжтой. Энэ нь удирдлагын зүгээс санаачилж дэмжсэн хувьсан өөрчлөгддөг, тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд зээлдэгч, түүний ажилтан, ажилчид, төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд олон нийт, шаардлагатай тохиолдолд бусад оролцогч талууд хоорондын утга учиртай харилцаа холбоог хамардаг.
2. Уг ГШ нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг үнэлэх, тэдгээр эрсдэл, нөлөөллийг зохицуулах, хянах журам боловсруулах, хэрэгжүүлэх явцад зээлдэгчийн хүлээх үүргийг тодорхойлсон.

Зорилт

3. Уг ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх;
 - төслийн үйл ажиллагааны улмаас ажилтан, ажилчид, нөлөөлөлд өртсөн иргэд олон нийт, байгаль орчинд үзүүлэх байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг бууруулах шатлалын арга барилыг хэрэгжүүлэх;
 - төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөлд тохирсон БОНУТ-г холбогдох ГШ-уудад нийцүүлсэн хэлбэрээр бүрдүүлэх; мөн
 - удирдлагын тогтолцоог үр дүнтэй ашиглах замаар зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулахыг хөхиүлэн дэмжих.

Үйлчлэх хүрээ

4. Энэхүү ГШ нь Байгаль орчин, нийгмийн бодлогод заасанчлан ЕСБХБ-ны санхүүжүүлсэн бүхий л төсөлд үйлчилнэ. Зээлдэгч байгаль орчин, нийгмийн үнэлгээнийхээ хүрээнд уг ГШ-ын холбогдох заалтууд болон тэдгээрийг төсөл боловсруулах, барьж байгуулах, хэрэгжүүлэх, хүлээлгэн өгөх буюу хаах, мөн нөхөн сэргээх үйл явцад хэрхэн зохицуулж, шийдвэрлэхийг тодорхойлно.
5. Шинэ байгууламж эсвэл бизнесийн үйл ажиллагаатай холбоотой төслийг анхнаас нь ГШ-уудыг хангасан байдлаар төлөвлөнө. Хэрэв төсөл нь ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөлөөс зөвшөөрөл авах үед ГШ-уудыг хангаагүй зээлдэгчийн одоогийн барилга байгууламж, бизнесийн үйл ажиллагааг шинэчлэх, сайжруулахад чиглэсэн бол, эсвэл Захирлуудын Зөвлөлөөс зөвшөөрөн батлах эрхийг олгосон бол Банкны удирдлага, эсвэл төсөл

нь анхнаасаа ГШ-уудыг хангаагүй бол зээлдэгч байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) боловсруулж батлах шаардлагатай. Уг төлөвлөгөөнд тэдгээр байгууламж, эсвэл үйл ажиллагааг ЕСБХБ-наас зөвшөөрсөн хугацааны дотор ГШ-уудад нийцүүлэхэд чиглэсэн техникийн болон санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой, зардал багатай цогц арга хэмжээнүүдийг багтаасан байна. ЕСБХБ ба зээлдэгч нь харилцан тохиролцож БОНУАТ-нд зээлдэгчийн зүгээс ГШ-уудын дагуу төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийг хянан зохицуулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай засаж залруулах болон урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах нарийвчилсан арга хэмжээг хэрэгжүүлэх цаг хугацааны хүрээтэй нь тусгана. БОНУАТ нь санхүүжилтийн гэрээний нэг хэсэг болох бөгөөд шаардлагатай бол тухайн БОНУАТ-ний хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх зээлдэгчийн үүргийг заасан байна.

6. Холбогдох байгууламжийн байгаль орчны болон/эсвэл нийгмийн эрсдэл, нөлөөллийг байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явцад тусган авч үзнэ. Зээлдэгч нь холбогдох байгууламжаас үүдэлтэй байгаль орчны болон/эсвэл нийгмийн эрсдэл, нөлөөллийг хамаарах хууль тогтоомж, ОУСТ болон ГШ-уудын зорилтуудын дагуу зохицуулж, бууруулах нөхцлийг хангана.
7. Төслийн ойр орчмын бусад байгууламж эсвэл үйл ажиллагаа, одоогийн байгууламж, мөн ГШ-ууд үл үйлчлэх, зээлдэгчийн хяналтаас гадуурх байгууламж эсвэл үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд ноцтой байж болзошгүй эрсдэл, нөлөөлөл үүссэн нь илэрсэн тохиолдолд зээлдэгч төсөлд учрах эрсдлийг бууруулах чиглэлд зохих хэмжээний хүчин чармайлт гаргана.
8. Төслийн оролцогч талуудтай хамтран ажиллах нь энэхүү үйл явцын салшгүй хэсэг мөн. Оролцогч талуудын оролцоотой холбоотой шаардлагуудыг ГШ.10-т тодорхой тусгасан болно.

Шаардлага

Байгаль орчин, нийгмийн үнэлгээ

9. Зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг авч үзнэ. Одоогийн байгууламж эсвэл бизнесийн үйл ажиллагаа ба/буюу холбогдох байгууламжтай холбоотой төслийн хувьд зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь тэрхүү байгууламж, үйл ажиллагаанд хамаатай байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг авч үзнэ. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явц нь одоогийн ба/буюу хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, мөн байгаль орчин, нийгмийн суурь мэдээлэл, түүний дотор хүйсээр ангилсан өгөгдөл зэрэг зохих нарийвчлал бүхий мэдээлэлд тулгуурлана. Түүнчлэн, үнэлгээгээр (i) тухайн төсөл хэрэгжиж буй улс орны байгаль орчин, нийгмийн холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагууд, түүний дотор тухайн хүлээн авагч улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах хууль тогтоомж; болон (ii) ГШ-уудын дагуу биелүүлэх ёстой холбогдох шаардлагуудыг тус тус тодорхойлно. Энэхүү аргачлалын гол цөм нь нөлөөллийг бууруулах шатлал болон ОУСТ-ыг нэвтрүүлэх явдал юм.

10. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь тухайн төслийн хуримтлагдсан эрсдэл, нөлөөллийг холбогдох бусад өнгөрсөн, одоогийн болон үндэслэлтэй урьдчилан таамаглах боломжтой үйл ажиллагаа, мөн төслийн хүрээнд эхлүүлсэн хожим, эсвэл өөр байршилд учирч болох төлөвлөгдөөгүй боловч урьдчилан таамаглах боломжтой үйл ажиллагаа наас үүдэлтэй эрсдэл, нөлөөлөлтэй хослуулан тодорхойлж, тогтоож болно.
11. Хэрэв тухайн төслөөс байгаль орчин, нийгэмд эрсдэл, сөрөг нөлөөлөл үзүүлэхээр бол зээлдэгч нь үнэлгээний ажлын салшгүй хэсэг байдлаар төсөлд хамаатай оролцогч талуудыг тодорхойлж, ГШ 10-ын дагуу төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэх явцад тэдний санал бодлыг тусгах үүднээс оролцогч талуудын утга учиртай оролцоог хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. Энэхүү оролцогч талуудыг тодорхойлох үйл явцад төслийн сөрөг нөлөөлөлд хэтэрхий их өртсөн байж болзошгүй хүмүүсийг олж тогтоох ёстой. Эмзэг бүлгийн иргэдийг төслийн нөлөөлөлд хэтэрхий их өртөхөөс сэргийлэх зорилгоор эрсдэл, нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.
12. Үнэлгээний үйл явц нь төслийн болзошгүй эрсдэл, нөлөөллийн хэмжээнд тохирсон ба хувь тэнцүү байх бөгөөд төслийн холбогдох бүхий л шүүд болон шүүд бус байгаль орчин, нийгмийн эрсдэл болоод нөлөөлөл, мөн төслийн мөчлөгийн холбогдох үе шатуудыг нэгдсэн байдлаар хамарсан байна. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас төсөлд үүссэн жендэрийн асуудал ба эрсдлийг үнэлгээний туршид авч үзнэ. Зээлдэгчийн хувьд байгаль орчин, нийгмийн үнэлгээг хүний эрх зэрэг тодорхой эрсдэл, нөлөөлөлд анхаарсан нэмэлт судалгаагаар баяжуулах нь зүйтэй байж болно. Үнэлгээгээр боломжит сайжруулах арга замуудыг ч мөн тодорхойлж, үнэлнэ.
13. Нарийн төвөгтэй эсвэл маргаантай, эсвэл байгаль орчны буюу нийгмийн ихээхэн хэмжээний олон талт эрсдэл, эсвэл нөлөөлөл дагуулж болзошгүй төслүүдийн хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэг буюу хэд хэдэн бие даасан шинжээчдийг ажиллуулах шаардлагыг зээлдэгчид тавьж болно. Ийм шинжээчид нь тухайн төслөөс хамааран зөвлөх багийн бүрэлдэхүүнд багтаж, эсвэл зээлдэгч тэдэнд ажил олгож болох бөгөөд төсөлд хөндлөнгөөс зөвлөгөө өгч, хяналт тавих болно.
14. Төсөл нь байгаль орчинд болон/эсвэл нийгэмд ихээхэн хэмжээний нөлөөлөл, тухайлбал шүүд ба хуримтлагдсан байгаль орчин, нийгмийн нөлөөлөл зэрэг шинэ бөгөөд нэмэлт, мөн төслийг ангилах үед шүүд тодорхойлох, үнэлэх боломжгүй нөлөөлөл үүсгэж болзошгүй тохиолдолд уг төслийг “А” ангилалд багтаадаг. “А” ангилалд багтсан төслүүдэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-ний албан ёсны, олон нийтийн оролцоонд тулгуурласан үйл явц шаардлагатай. БОННУ-нд төслийн байршил, технологи, хэмжээ, цар хүрээ, дизайн, нөлөөллийг бууруулах боломжууд болон “төсөлгүй” хувилбарын дүн шинжилгээ багтана. “А” ангиллын төслүүдийн жагсаалтыг Бодлогын Хавсралт 2-т үзүүлэв.
15. Хэрэв төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь зөвхөн тухайн төсөл хэрэгжиж буй байршилд хамааралтай ба/буюу нөлөөллийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах замаар тодорхойлох, шийдвэрлэх боломжтой бол уг төслийг “Б” ангилалд оруулна. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хамрах цар хүрээг ЕСБХБ тохиолдол бүрээр тогтооно.
16. Төслийн байгаль орчин ба/буюу нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл хамгийн бага, эсвэл байхгүй бол түүнийг “В” ангилалд багтаана.
17. Олон талбайд үйл ажиллагаа явуулж буй зээлдэгч нь корпорацийн санхүү, эсвэл шүүд хөрөнгө оруулалт хүсэж байвал уг шаардлагын 9-өөс 15-д заасан үнэлгээг хийлгэх нь тохиромжгүй байж болно. Энэ тохиолдолд Банк зээлдэгчийн одоогийн БОНУТо, мөн компанийн өмнөх болон одоогийн гүйцэтгэл нь холбогдох ГШ-уудыг хангаж буй эсэхэд үнэлгээ хийж, байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг зохицуулах зорилгоор БОНУАТ боловсруулан, байгууллагын түвшинд хэрэгжүүлнэ. Мөн тухайн байршилд зориулсан тусгай арга хэмжээг авч үзэж болно.

Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо

18. Зээлдэгч нь төслийн мөн чанар, цар хэмжээнд тохирсон, мөн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн түвшинд нийцсэн БОНУТо-г ОУСТ-ын дагуу бүрдүүлэх, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү удирдлагын тогтолцооны зорилго нь байгаль орчин, нийгмийн шаардлагуудын хэрэгжилтийг боловсронгуй, харилцан уялдаатай үйл явцад нэгтгэх, зээлдэгчийн үндсэн үйл ажиллагаанд оруулах явдал юм.

Байгаль орчин, нийгмийн бодлого

19. Зээлдэгч шаардлагатай тохиолдолд төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг хангахад чиглэсэн байгаль орчин, нийгмийн зорилт, зарчмуудыг тодорхойлсон цогц бодлого баримталж ажиллана. Энэхүү бодлого нь ГШ-уудын зарчмуудад нийцсэн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, удирдлагын үйл явцыг тогтоож өгнө.

Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө

20. Байгаль орчин, нийгмийн үнэлгээгээр тодорхойлсон асуудлууд, талуудын оролцооны үр дүнг харгалзан, зээлдэгч нь ГШ-уудыг хангахын тулд төслийн байгаль орчин, нийгмийн мэдэгдэж буй эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх үйл ажиллагаа болон гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Тухайн төслөөс хамааран, энэхүү хөтөлбөр нь хамтдаа байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНУТө) гэж нэрлэгддэг баримтжуулсан үйл ажиллагааны бодлого, удирдлагын тогтолцоо, холбогдох журам, төлөвлөгөө, арга түршлага, капиталын хөрөнгө оруулалт зэргээс бүрдэж болно.
21. БОНУТө-нд нөлөөллийг бууруулах шатлалын арга барилыг тусгаж, техникийн болоод санхүүгийн хувьд боломжтой бол эрсдэл, нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах, бууруулах, нөхөн олговор олгон шийдвэрлэхээс илүүтэйгээр тэрхүү эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх, сэргийлэхэд илүү анхаарч, төслийн бүхий л үе шатыг холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага болон ГШ-уудыг хангасан байхаар зохион байгуулна.
22. Үнэлгээний явцад төслийн нөлөөлөлд өртсөн хувь хүн, эсвэл бүлэг хүмүүсийг бололцоо муутай, эмзэг бүлгийнх гэж тодорхойлсон тохиолдолд БОНУТө-нд төслөөс үүдэлтэй эрсдэл, нөлөөлөл тэдэнд хэт хүндээр тусахааргүй байх нөхцлийг хангах, мөн төслөөс үр шим хүртэх боломжуудыг ашиглах бололцоогоор хангах тусгайлсан арга хэмжээнүүдийг багтаасан байна.
23. БОНУТө-ний нарийвчлал, дэлгэрэнгүй байдал нь тухайн төслийн эрсдэл, нөлөөлөл болон төслийг сайжруулах боломжид тохирсон байна. БОНУТө-нд хүсэж буй үр дүнгээ тодорхой хугацааны туршид аль болох хэмжиж болохуйц зорилтот тоо хэмжээ, шалгуур үзүүлэлтээр илэрхийлэн тусгаж өгнө. Төслийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх үйл явц төслийн хугацаанд өөрчлөгдөж байдгийг харгалзан БОНУТө нь төслийн нөхцөл байдлын өөрчлөлт, урьдчилж тооцоогүй үйл явдал, хууль

тогтоомжид орсон шинэчлэлт, хяналт шинжилгээ, шалгалтын үр дүнд мэдрэмжтэй байж, шаардлагатай өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр тусгана.

Байгууллагын чадавх, үүрэг амлалт

24. Зээлдэгч үндэсний холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага, мөн ГШ-уудын нийцлийг тогтмол хангаж байх зорилгоор БОНУТо-г авч явах үүрэг, хариуцлага, эрх мэдлийг тодорхойлсон байгууллагын бүтцийг бий болгон, хэрэгжүүлж, шаардлагатай бол улам бэхжүүлнэ. Зээлдэгч БОНУТо-г хадгалах, хэрэгжүүлэх тодорхой үүрэг хариуцлага, эрх мэдэл бүхий тодорхой ажилтан, мөн удирдах түвшний төлөөлөгч (-д)-ийг томилж ажиллуулна. Байгаль орчин, нийгмийн асуудлаар хүлээх гол үүрэг хариуцлагыг тодорхойлж, холбогдох ажилтнуудад танилцуулсан байх ёстой. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үр дүнтэй гүйцэтгэлийг тасалдалгүйгээр бүрдүүлэх үүднээс хангалттай дэмжлэг, хүн хүчний болон санхүүгийн нөөцөөр тогтмол хангана.
25. Зээлдэгч нь төслийн нийгэм, байгаль орчны гүйцэтгэлтэй холбоотой үйл ажиллагааг шууд хариуцан ажиллах ажилтан, ажилчдыг зохих сургалтад хамруулж, мэргэшүүлнэ.

Гуравдагч этгээдийн эрсдэл

26. БОНУТо болон түүнд заагдсан тодорхой шаардлага, арга хэмжээнүүд нь төслийг зээлдэгч шууд хариуцан гүйцэтгэх, эсвэл гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх эсэхээс үл харгалзан тухайн төсөлд үйлчилнэ.
27. Төслийн талбайд ажиллаж буй гэрээт ажил гүйцэтгэгчдэд гэрээний удирдлагын зохистой тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх замаар БОНУТо-ны шаардлагыг хангуулах нь зээлдэгчийн хүлээсэн үүрэг юм. Үр дүнтэй гэрээний удирдлагад дараах чиг үүргүүд багтана. Үүнд:
- гэрээт ажил үйлчилгээтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдлийг үнэлэх, БОНУТе-ний холбогдох нөхцлийг тендерийн бичиг баримтанд зохих байдлаар оруулах, гэрээний дагуу гэрээт ажил гүйцэтгэгчийг эдгээр стандартыг дагаж мөрдөх, зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгах ба/буюу засаж залруулах арга хэмжээг авахыг шаардах;
 - гэрээт ажил гүйцэтгэгч төслийн хүрээнд ноогдсон үүрэг даалгавраа гэрээнд заасан байгаль орчин, нийгмийн нөхцөл болзлын дагуу гүйцэтгэх мэдлэг, үр чадвар эзэмшсэн эсэхэд хяналт тавих;
 - гэрээт ажил гүйцэтгэгч гэрээнд заасан байгаль орчин, нийгмийн нөхцөлд нийцүүлэн ажиллаж буй эсэхэд хяналт шинжилгээ хийх; мөн
 - туслан гүйцэтгэгч ажиллуулах тохиолдолд гэрээт ажил гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчтэйгээ байгаль орчин, нийгмийн асуудлаар ижил зохицуулалттай байхыг шаардах.

28. Зээлдэгч нь өөрийн гол ханган нийлүүлэгчидтэй²² холбоотой эрсдлийг тодорхойлоход зохих хүчин чармайлт гаргах шаардлагатай. Магадлан шалгалтын явцад тогтоогдсон аливаа арга хэмжээ ба/буюу нөлөөллийг бууруулах арга хэмжээг БОНУТе-нд зохих байдлаар тусгах хэрэгтэй. Зээлдэгч өөрийн гол ханган

нийлүүлэгчдийг зохих түвшинд хянаж чадах тохиолдолд байгаль орчин, нийгмийн үнэлгээгээр тухайн гол ханган нийлүүлэгчид төслийн хүрээнд байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл учруулах магадлалтай эсэхийг анхаарч үзнэ. Хэрэв тийм эрсдэл байгаа бол зээлдэгч нь ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын тогтолцоог бий болгон хэрэгжүүлэх ба тэрхүү тогтолцоо нь эдгээр ханган нийлүүлэлтийн сүлжээний нарийн цогц байдал, төслийн мөн чанар, цар хүрээнд нийцсэн байгаль орчин, нийгмийн холбогдох эрсдэл, нөлөөлөлд тохирсон байна. Удирдлагын тогтолцоо нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд хийсэн үнэлгээ, эсвэл явц дундын хяналт шинжилгээний үр дүнд илрүүлсэн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх арга хэмжээ авах үйл явцыг тусгана. Ингэхдээ: (а) зээлдэгч тухайн эрсдэл, нөлөөллийг үүсгэсэн, эсвэл үүсгэхэд оролцсон эсэх, (б) зээлдэгчийн зүгээс ханган нийлүүлэгчийг хяналтандаа байлгах хөшүүрэг, (в) тэдний харилцаа зээлдэгчийн хувьд аль зэрэг чухал болох, (г) эрсдэл, нөлөөлөл хэр зэрэг ноцтой болох, мөн (д) ханган нийлүүлэгчтэй харилцаагаа тасалвал ямар сөрөг үр дагавар гарах вэ гэдэгт анхаарах хэрэгтэй. Ханган нийлүүлэлтийн сүлжээнд дагаж мөрдөх хөдөлмөрийн стандартын шаардлагуудыг ГШ.2-т, байгалийн амьд нөөцийн ханган нийлүүлэх сүлжээнд тавих шаардлагуудыг ГШ.6-д тодорхой дурдсан болно.

Төслийн хяналт шинжилгээ ба тайлагнал

29. Зээлдэгч төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийнэ. Тус хяналт шинжилгээ нь (i) төсөл ГШ-уудын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох, (ii) сургамж авах, хөрөнгө нөөцийг хуваарилах, үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах боломжуудыг тодорхойлох зорилготой байна.
30. Хяналт шинжилгээний шаардлагууд нь төслийн мөн чанар, түүний байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэл, нөлөөллийн зэрэгт нийцсэн байна. Хяналт шинжилгээгээр дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:
- Байгаль орчин, нийгмийн үнэлгээний явцад илрүүлсэн байгаль орчин, нийгмийн томоохон эрсдэл, нөлөөлөл;
 - Төслийн үнэлгээ, түүний дараах хяналт шинжилгээний явцад тодорхойлсон ГШ-уудын холбогдох хэсгүүд;
 - БОНУТе эсвэл БОНУАТ-нд тусгасан арга хэмжээнүүд;
 - Ажилтан, ажилчид болон хөндлөнгийн оролцогч талуудаас хүлээн авсан гомдлууд, мөн тэдгээрийг шийдвэрлэсэн байдал;
 - Хууль журамд заасан хяналт шинжилгээ хийх, тайлагнах шаардлагууд; болон
 - Бусад талууд (тухайлбал, бараа худалдах, худалдан авах гэрээний талууд, санхүүжүүлэгч, эсвэл гэрчилгээ

²² Гол ханган нийлүүлэгчид гэж төслийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бараа, материалыг тогтмол шууд нийлүүлдэг ханган нийлүүлэгчид юм. Төслийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь төслийн тодорхой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үйлдвэрлэл ба/буюу үйлчилгээ бөгөөд түүнгүйгээр төслийг үргэлжлүүлэх боломжгүй.

олгогч)-аас шаардсан аливаа хяналт шинжилгээ, тайлан багтана.

31. Зээлдэгч нь хяналт шинжилгээг гүйцэтгэх хангалттай тогтолцоо, нөөц, ажиллах хүчнийг бүрдүүлэх ёстой. Зээлдэгч нь хяналт шинжилгээний үр дүнг хянан үзэж, шаардлагатай тохиолдолд засаж залруулах арга хэмжээг авна. Түүнчлэн, зээлдэгч нь хөндлөнгийн шинжээч, орон нутгийн иргэд, эсвэл иргэний нийгмийн байгууллага зэрэг гуравдагч этгээдээр өөрийн хийсэн хяналт шинжилгээний мэдээллийг баяжуулах буюу баталгаажуулж болно. Холбогдох эрх бүхий байгууллага, эсвэл гуравдагч этгээд байгаль орчин, нийгмийн тодорхой эрсдэл, нөлөөллийг зохицуулах, холбогдох бууруулах арга хэмжээг авах үүрэг хүлээсэн тохиолдолд зээлдэгч нь тэдгээр эрх бүхий байгууллага, гуравдагч этгээдтэй тэрхүү нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх талаар хамтран ажиллана.
32. Зээлдэгч төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар, тухайлбал ГШ-уудын нийцэл, БОНУТо, БОНУТө, БОНУАТ болон Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар ЕСБХБ-нд зохих ёсоор тогтмол тайлагнана. Хяналт шинжилгээний үр дүнгээс хамаарч зээлдэгч нь шаардлагатай засаж залруулах буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг ЕСБХБ-тай тохиролцсоны үндсэн дээр тодорхойлж, шинэчилсэн БОНУТө эсвэл БОНУАТ-нд тусгах үүрэгтэй. Зээлдэгч нь тохиролцсоны дагуу засаж залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, гүйцэтгэлээ сайжруулах үүднээс тэдгээр арга хэмжээний мөрөөр анхаарал хандуулж ажиллана.
33. Зээлдэгч өөртэй нь, эсвэл төсөлтэй холбоотой, томоохон сөрөг үр дагавар авчирсан буюу авчирч болзошгүй байгаль орчин, нийгмийн шинжтэй хэрэг явдал, эсвэл осол гарсан тохиолдолд ЕСБХБ-нд яаралтай мэдэгдэх ёстой.
34. Төслийн цар хүрээ, загвар, үйл ажиллагаанд байгаль орчны ба/буюу нийгмийн эрсдэл, нөлөөллийг материаллаг байдлаар өөрчлөх магадлалтай аливаа өөрчлөлт орсон тохиолдолд зээлдэгч энэ талаар ЕСБХБ-нд яаралтай мэдэгдэх ёстой. Зээлдэгч нь ЕСБХБ-тай тохиролцсоны дагуу ГШ-уудад нийцсэн холбогдох нэмэлт үнэлгээ, талуудын оролцоог хангах арга хэмжээг авч, энэ талаар БОНУТө эсвэл БОНУАТ-нд тусгана.
35. Байгаль орчин, нийгмийн томоохон хэмжээний эрсдэл, сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй төслүүдийн хувьд төслийн хөндлөнгийн үнэлгээг үе үе хийх, эсвэл байгаль орчин, нийгмийн тодорхой эрсдэл, нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх хөндлөнгийн шинжээчдийг ажиллуулах шаардлагыг зээлдэгчид тавьж болно. Энэхүү ажлын цар хүрээ, түүний мөрөөр авах арга хэмжээг тухайн тохиолдол нэг бүрээр тодорхойлно.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 2: Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрийн нөхцөл

Танилцуулга

1. Энэхүү ГШ нь зээлдэгчид болон тэдний бизнесийн үйл ажиллагааны хувьд ажиллах хүчин бол үнэ цэнтэй хөрөнгө бөгөөд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтын хэлэлцээр хийх эрх зэрэг ажилтан, ажилчдын эрхийг хүндэтгэх үндсэн дээр бий болсон хүний нөөцийн сайн удирдлага хийгээд ажилтан, ажилчид-удирдлага хоорондын зохистой харилцаа нь бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрэлдүүлэх гол хүчин зүйл болохыг хүлээн зөвшөөрсөн болно.

Зорилт

2. Уг ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - ажилтан, ажилчдын эрх ашиг²³, суурь зарчмуудыг хүндэтгэн хамгаалах
 - зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалын²⁴ дагуу ажилтан, ажилчдад шударга хандах, үл ялгаварлан гадуурхах, тэгш боломж олгох;
 - ажилтан, ажилчид-удирдлага хоорондын оновчтой харилцааг бүрдүүлэх, хадгалах, сайжруулах;
 - хөдөлмөрийн болон хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль тогтоомж, зээлдэгчийн нэгдэж орсон аливаа хамтын гэрээг дагаж мөрдөх;
 - ажил эрхэлж буй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, тэр дундаа залуу ажилтан, ажилчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цагаач ажилчид, дүрвэгсэд, гуравдагч этгээдийн хөлсөлсөн ажилтан, ажилчид, зээлдэгчийн ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх ажилчид зэрэг эмзэг өртөмхий ажилтан, ажилчдыг хамгаалах;
 - албадан хөдөлмөр болон хүүхдийн хөдөлмөр (Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас тодорхойлсон) ашиглахаас урьдчилан сэргийлэх;
 - ажилтан, ажилчдыг ажлын байртай холбоотой асуудлыг дэвшүүлэх, шийдвэрлэх хүртээмжтэй бөгөөд үр дүнтэй арга хэмжээгээр хангах.

Үйлчлэх хүрээ

3. Энэхүү ГШ нь Байгаль орчин, нийгмийн бодлогод заасанчлан ЕСБХБ-ны санхүүжүүлсэн бүхий л төсөлд үйлчилнэ. Уг ГШ-ын үйлчлэх хүрээ нь байгаль орчин, нийгмийн үнэлгээний явцад тогтоогдох бөгөөд зээлдэгч болон төслийн ажилтан, ажилчид хоорондын гэрээний харилцааны хэлбэрээс шалтгаална.

4. Тус ГШ нь зээлдэгчийн шүүд, эсвэл гуравдагч этгээдийн ажиллуулж буй үндсэн, хагас цагийн, түр хугацааны, байнгын, улирлын чанартай, цагаач ажилчид зэрэг төслийн бүх ажилтан, ажилчидтай холбоотойгоор зээлдэгчид тавигдах шаардлагыг тогтоож, гол ханган нийлүүлэгчдийн хангах ёстой шаардлагыг тодорхой заасан. Төслийн ажилтан, ажилчид гэж төслийн талбай дээр, эсвэл төслийн үндсэн чиг үүрэгтэй шүүд холбоотой ажил гүйцэтгэх ажилтан, ажилчид юм.
5. Гэрээт ажилчдад²⁵ хамаарах ГШ-ын заалтуудыг энэхүү ГШ-ын 22-24-т тусгасан. Ханган нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой ажиллах хүчний шаардлагыг энэхүү ГШ-ын 25-27-д тусгасан болно.
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хамгаалалтын шаардлагуудыг ГШ.4-өөс харж болно.

Шаардлага

Ерөнхий

7. Төслүүд дор хаяж дараах зохицуулалтуудын шаардлагыг хангасан байна. Үүнд: (i) хөдөлмөрийн тухай, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн хамгааллын тухай үндэсний хууль тогтоомж, (ii) ОУХБ-ын суурь конвенцуудад тусгагдсан үндсэн зарчим, стандартууд, (iii) энэхүү ГШ орно.

Байгууллагын харилцааны удирдлага

Хүний нөөцийн бодлого

8. Зээлдэгч нь энэхүү ГШ-ын шаардлагууд болон үндэсний хууль тогтоомжийн дагуу ажиллах хүчийг удирдах, зохион байгуулах арга зарчмыг тодорхойлохдоо байгууллагынхаа хэмжээ болон ажиллах хүчинд нийцсэн хүний нөөцийн бодлого, удирдлагын тогтолцоо, журмыг баталж мөрдөнө. Эдгээр бодлого, журам нь ойлгомжтой, хүртээмжтэй, ажилтан, ажилчдад танилцуулагдсан байх ба ажиллах хүчний ярьдаг хэлээр бичигдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа

9. Зээлдэгч нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны эхэнд болон хөдөлмөрийн нөхцөлд материаллаг өөрчлөлт орсон тохиолдолд ажилтан, ажилчидтай бичгээр гэрээ байгуулах бөгөөд үүнд зээлдэгчтэй үүсгэсэн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг тодорхойлсон байна. Гэрээнд тухайн орны хөдөлмөрийн болон хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, мөн холбогдох хамтын гэрээний дагуу ажилтан, ажилчдын эдлэх эрх, хөдөлмөрийн нөхцөл ба хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нөхцлүүд (үүнд цалин хөлс авах эрх, ажлын цаг, амралтын цаг, илүү цагийн зохицуулалт, илүү цагийн нэмэгдэл хөлс орно) болон тэтгэмж (өвчний чөлөө, эх/эцэг

²³ ОУХБ-ын дараах суурь конвенцуудыг удирдлага болгоно. Үүнд: C029 Албадан хөдөлмөрийн тухай (1930) болон Нэмэлт протокол R029 (2014); C087 Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай (1948); C098 Хамтын хэлэлцээр хийх эрхийн тухай (1949); C100 Тэгш шан хөлс олгох тухай (1951); C105 Албадан хөдөлмөрийг устгах тухай (1957); C111 Алагчлахгүй байх тухай (Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) (1958); C138 Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай (1973); C182 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай (1999);

²⁴ Зохистой хөдөлмөр гэдэгт хүмүүс ажил эрхэлж байхдаа тээж явдаг хүсэл эрмэлзлийг нэгтгэн ойлгоно. Үүнд, үр бүтээлтэй, зохих ёсны орлого өгдөг ажил эрхлэх боломж, ажлын байран дахь аюулгүй байдал, гэр бүлийн нийгмийн хамгаалал, хувь хүний хөгжил ба нийгэмшлийн илүү сайн нөхцлүүд, хүмүүсийн асуудлаа илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх, амьдралд нь нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад оролцох эрх, бүх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд ижил тэгш хандаж, тэгш боломж олгох зэрэг багтана.

²⁵ 'Гэрээт ажилчид' гэж зээлдэгч шүүд ажил олгоогүй боловч гэрээт ажил гүйцэтгэгч, зүүчлагч агентлаг, брокер эсвэл бусад зүүчлагчид зэрэг гуравдагч этгээдээр дамжуулан ажил гүйцэтгэж буй төслийн ажилтан, ажилчдыг хэлнэ.

болсны буюу хүүхэд асаргааны чөлөө, амралт, баярын өдөр гэх мэт)-ийг тусгана. Аливаа материаллаг өөрчлөлтийг баримтжуулж, ажилтан, ажилчдад танилцуулна. Уг мэдээлэл нь ажилтан, ажилчдад ойлгомжтой, хүртээмжтэй байх ба тэдний ярьдаг хэл дээр бичигдсэн байна. Хүний нөөцийн удирдлага нь ажилтан, ажилчдын хувь хүний нууц, мэдээллийн аюулгүй байдлаа хангах эрхийг хүндэтгэсэн хөдөлмөр эрхлэлтийн шинэчилсэн бүртгэл хөтөлсөн байна.

10. Ажилтан, ажилчдыг дараах зүйлсээр хангах үүднээс харилцаа холбоог удирдана. Үүнд: (i) тэдэнд нөлөөлж болзошгүй өөрчлөлтүүд, ялангуяа төсөлтэй холбоотой хүлээгдэж буй өөрчлөлтийн талаарх хангалттай мэдээлэл (ii) ажлыг тасралтгүй сайжруулахад чиглэсэн, түүний дотор энэхүү ГШ-ын 21-т заасан гомдол хэрхэн мэдүүлэх тухайд санал бодлоо илэрхийлэх боломж орно.

Хүүхдийн хөдөлмөр

11. Зээлдэгч нь насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлтийн тухай үндэсний хууль тогтоомж, эсвэл олон улсын хөдөлмөрийн стандартууд дотроос хүүхэд хамгааллыг хамгийн дээд зэргээр хангасныг нь дагаж мөрдөнө.
12. Зээлдэгч эдийн засгийн мөлжлөгийн чанартай, эсвэл аюултай байж болох, хүүхдийн боловсролд сөргөөр нөлөөлөх, эсвэл хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэц, оюун санаа, ёс суртахуун болон нийгмийн хөгжилд хор нөлөө үзүүлж болох хэлбэрээр хүүхдийг ажиллуулахгүй. Ажилтан, ажилчдын дундах 18 нас хүрээгүй залуу хүмүүсийг зээлдэгч тогтоох ба тэднээр аюултай ажил гүйцэтгүүлэхгүй. Ажил эхлэхээс өмнө 18-аас доош насны хүмүүсийн гүйцэтгэх бүх ажлын эрсдлийн үнэлгээг зохих ёсоор хийж, эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөл болон ажлын цагт нь тогтмол хяналт тавина.

Албадан хөдөлмөр

13. Зээлдэгч шийтгэл ногдуулахаар айлган сүрдүүлэх, эсвэл хүч хэрэглэхээр заналхийлэх, тухайлбал ажилд авахад эрх мэдлээр далайлгаж, залилан мэхлэх байдлаар хүнээр хүсэл зоригийнх нь эсрэг ажил үйлчилгээ эрхлүүлэхгүй. Үүнд хөлсгүй хөдөлмөр, хорих ангийн албадан хөдөлмөр, боолын хөдөлмөр буюу түүнтэй төстэй хөдөлмөрийн гэрээний зохицуулалт, эсвэл хүн худалдаалах²⁶ зэрэг сайн дурын бус, албадан хөдөлмөр багтана.

Үл ялгаварлан гадуурхах ба тэгш боломж олгох

14. Төслүүд ажил эрхлэлттэй холбоотой үл ялгаварлан гадуурхах тухай шаардлагуудыг хангасан байна. Ялангуяа, төсөлтэй холбоотойгоор зээлдэгч нь:
- ажлын зайлшгүй шаардлагад хамааралгүй хувь хүний шинж чанар болох хүйс, арьс өнгө, яс үндэс, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэл, холбооны гишүүнчлэл, үндэс угсаа, нийгмийн гарал, шашин шүтлэг эсвэл итгэл үнэмшил, гэрлэлтийн болон гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаанд үндэслэн ажилд авах эсэх шийдвэр гаргахгүй;

- хөдөлмөр эрхлэлтийн харилцааг тэгш боломж ба шударга хандах зарчимд үндэслэх бөгөөд ажилд сонгон шалгаруулах, ажилд авах, үүрэг даалгавар өгөх, нөхөн олговор (цалин хөлс, урамшуулал багтана) олгох, мөн ажлын байрны болон хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, жишээ нь: ажлын байрыг хөгжлийн бэрхшээлд нийцүүлэн өөрчлөх, сургалтад хамрагдах, албан тушаал дэвших боломж, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох буюу тэтгэвэрт гарах, хөдөлмөрийн сахилга зэрэг хөдөлмөр эрхлэлтийн харилцааны аливаа асуудлаар ялгаварлан гадуурхахгүй;
- бүх хэлбэрийн хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлт, айлган сүрдүүлэлт ба/буюу мөлжлөг, түүний дотор жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)²⁷-ээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ авна.

Өнгөрсөн хугацаанд гарсан ялгаварлан гадуурхсан үйлдлийг арилгах, залруулахад туслах, хамгаалах тусгай арга хэмжээ, орон нутгийн хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжих, эсвэл үндэсний хууль тогтоомжийн дагуу ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн тодорхой ажилд сонгон шалгаруулалт хийх арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

Ажилтан, ажилчдын байгууллага

15. Зээлдэгч нь ажилтан, ажилчдад өөрсдийн төлөөлөгчдийг сонгох, байгууллагаа байгуулах, эсвэл үндэсний хууль тогтоомжийн дагуу өөрсдийн сонгосон байгууллагад нэгдэх болон хамтын хэлэлцээр хийх эрхтэй гэдгийг нь мэдэгдэнэ. Зээлдэгч тэдгээр байгууллагад буюу хамтын хэлэлцээрт төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж байгаа, оролцож байгаа, эсвэл оролцох хүсэлтэй ажилтан, ажилчдыг ялгаварлан гадуурхахгүй бөгөөд тэдний эсрэг арга хэмжээ авахгүй, ажилтан, ажилчдын байгууллагыг байгуулах, үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй. Зээлдэгч нь тухайн улс орны хуулийн дагуу ажилтан, ажилчдын төлөөлөгчид буюу байгууллагатай хамтран ажиллаж, тэдэнд үр дүнтэй хэлэлцээр хийхэд шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь гарган өгнө. Хэрэв үндэсний хууль тогтоомж ажилтан, ажилчдын байгууллагыг байгуулах, үйл ажиллагаа явуулахыг ихээхэн хязгаарлаж байвал зээлдэгч нь ажилтан, ажилчдыг байгууллагын хэмжээ, ажиллах хүчинд зохицсон ажиллах нөхцөл болон хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотой нөхцлийн тухайд эрх ашгаа илэрхийлэх, эрхээ хамгаалах хувилбарт механизмуудыг бий болгохыг хориглохгүй. Зээлдэгч тэдгээр механизмд нөлөөлөх, хянахыг эрмэлзэхгүй. Үндэсний хууль тогтоомжоор зохицуулаагүй тохиолдолд зээлдэгч ажилтан, ажилчдыг өөрсдийн төлөөллийг сонгох, өөрсдийн сонгосон ажилтан, ажилчдын байгууллагыг байгуулах, нэгдэх, хамтын гэрээ хэлэлцээр хийхэд саад учруулахгүй, тэрхүү байгууллага, хамтын хэлэлцээрт оролцож байгаа эсвэл оролцох хүсэлтэй ажилтан, ажилчдыг ялгаварлан гадуурхахгүй, тэдний эсрэг арга хэмжээ авахгүй. Зээлдэгч ажилтан, ажилчдын төлөөлөл ба ажилтан, ажилчдын байгууллагатай хамтран ажиллаж, тэдэнд үр дүнтэй хэлэлцээр хийхэд шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь гарган өгнө.

²⁶ Хүн худалдаалах гэж айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх болон бусад байдлаар албадан тулгах, хүлгалах, залилах, хуран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах зэрэг аргаар хүнийг татан элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, нуун дарагдуулах, хүлээн авах, эсвэл мөлжлөгийн зорилгоор тухайн хүнд хяналт тавьж байгаа этгээдээс зөвшөөрөл авахын тулд төлбөр, шан харамж өгөх буюу авах үйлдэл гэж тодорхойлсон. Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд эмэгтэйчүүд нэн өртөмхий байдаг.

²⁷ “Хүчирхийлэл ба дарамт” гэдгийг бие махбодь, нийгэм, сэтгэл зүйн, эсвэл эдийн засгийн хохирол учруулах зорилготой, ЖСХ гэх мэт нэг удаагийн буюу дахин давтагдах хүлээн зөвшөөрч үл болох зан үйл, дадал зуршил, эсвэл аюул заналхийллийн тасралтгүй үргэлжлэл гэж ойлгох ёстой. ЖСХ бол хувь хүний хүсэл зоригийн эсрэг үйлдэгдсэн аливаа хор хөнөөлтэй үйлдлийн ерөнхий нэр томъёо бөгөөд энэ нь нийгэмд тогтсон хүйсийн ялгаан дээр үндэслэсэн байдаг. ЖСХ-д бие махбодь, оюун санаанд болон бэлгийн харьцаанд хор уршиг, зовлон зүдгүүр учруулах, ийм үйлдэл хийхээр заналхийлэх, албадлага болон эрх чөлөөг хязгаарлах бусад үйлдэл багтана.

Цалин, урамшуулал ба ажлын нөхцөл

16. Санал болгож буй цалин, урамшуулал, ажлын нөхцөл (ажлын цагийг оруулан) нь тухайн улс/бүс нутаг болон салбарын бусад ажил олгогчдын санал болгож буй цалин, урамшуулал, ажлын нөхцөлтэй дор хаяж ойролцоо байна. Илүү цагийн ажлыг сайн дүрын үндсэн дээр хийх ба холбогдох үндэсний хуульд заасны дагуу илүү цагийн цалин урамшууллыг олгоно.
17. Зээлдэгч нь хамтын хэлэлцээрийн нэг тал, эсвэл түүний дагуу ямар нэг үүрэг хүлээсэн бол тухайн гэрээг хүндэтгэн үзэх ёстой. Хэрэв ийм гэрээ байгуулаагүй, эсвэл уг гэрээнд ажлын нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотой нөхцлийг тусгаагүй тохиолдолд зээлдэгч үндэсний хуульд нийцсэн ажлын байрны ба хөдөлмөр эрхлэлтийн зохих нөхцлөөр хангана.
18. Зээлдэгч нь цагаач ажилчдыг бүртгэн ижил төрлийн ажил эрхэлж байгаа дотоодын ажилтан, ажилчидтай ижил төстэй нөхцлөөр ажиллах боломжоор хангана.

Ажилтан, ажилчдын байр

19. Зээлдэгч төслийн ажилтан, ажилчдыг байраар хангахдаа тухайн байрны чанар, удирдлага болон үйлчилгээний хангалтыг зохицуулах бодлого гаргаж хэрэгжүүлнэ. Байрны үйлчилгээг ОУСТ-ын жишгээр үзүүлэх бөгөөд үл ялгаварлан гадуурхах, тэгш боломжоор хангах, түүний дотор бэлгийн дарамт болон ЖСХ-ийн бусад хэлбэрээс хамгаалах зарчимд нийцсэн хэлбэрээр зохицуулна. Ажил олгогчийн олгосон байранд ажилтан, ажилчдын чөлөөтэй орох, гарах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлаж болохгүй.

Бөөнөөр халах

20. Төсөлтэй холбоотойгоор ажилтан, ажилчдыг бөөнөөр халахын²⁸ өмнө зээлдэгч орон тоог цөөрүүлэх, ажлын байрыг хасахаар төлөвлөж буй хувилбаруудыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. Шинжилгээгээр орон тоог цөөрүүлэх, ажлын байрыг хасах оновчтой хувилбарыг тодорхойлоход хүндрэлтэй байвал зээлдэгч тухайн улс орны хууль, тогтоомж болон ОУСТ-д нийцүүлж, үл ялгаварлан гадуурхах, харилцан зөвшилцөх зарчимд үндэслэсэн, орон тоог цөөрүүлж, ажлын байрыг хассаны улмаас ажилтан, ажилчдад гарч болох сөрөг нөлөөллийг үнэлэх, багасгах, арилгахад чиглэсэн бөөнөөр халах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ. Бөөнөөр халахад ажилтан, ажилчдыг сонгох үйл явц нь шударга, бодитой, тогтмол ашиглагддаг шалгууруудын үндсэн дээр ил тод байх бөгөөд гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг бүрдүүлнэ. Зээлдэгч бөөнөөр халахтай холбоотой хууль эрх зүйн, хамтын гэрээний бүх шаардлагыг дагаж мөрдөх ба үүнд төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх, ажилтан, ажилчид болон тэдний байгууллагыг мэдээллээр хангах, зөвшилцөх ажил багтана. Ажилтан, ажилчид, тэдний байгууллагатай зөвшилцөх ажлын үр дүнг бөөнөөр халах эцсийн төлөвлөгөөнд тусгана. Төлбөл зохих цалингийн үлдэгдэл, нийгмийн даатгал, тэтгэврийн даатгалын шимтгэлийг: (i) хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон өдөр буюу өмнө нь хийсэн байх, (ii) боломжтой бол тухайн ажилтан, ажилчинд ашигтай байдлаар, (iii) хамтын хэлэлцээрт заасан хугацаанд төлнө. Ажилтан,

ажилчны ашиг тусын тулд төлбөр төлбөл тухайн ажилтан, ажилчинд төлбөрийн баримт олгоно. Зээлдэгч ЕСБХБ-нд төлөвлөж буй ажиллах хүчний цомхотголын тухай урьдчилан мэдэгдэх ба ЕСБХБ-ны хүсэлтээр бөөнөөр халахаар санал болгож буй төлөвлөгөөний хувийг өгнө.

Гомдол барагдуулах механизм

21. Зээлдэгч ажлын байртай холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд ажилтан, ажилчдад (ба хэрэв байвал ажилтан, ажилчдын байгууллагад) зориулан гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгоно. Ажилтан, ажилчдад гомдол барагдуулах механизмын талаар ажилд орох үед нь танилцуулж, санал, гомдлоо гаргахад хялбар, хүртээмжтэй байхаар зохион байгуулна. Тус механизм нь зохих түвшний удирдлагын оролцоотой, санал гомдлыг шуурхай шийдвэрлэдэг, ойлгомжтой, ил тод үйл явцтай байх бөгөөд холбогдох хүмүүст ямар нэг хариу шийтгэлгүйгээр цаг тухай бүрт нь хариу өгнө. Механизм нь нууцаар гомдол гаргах, тухайлбал ЖСХ-ийн тухай мэдээлэх зэрэг тусгай хамгааллын арга хэмжээ шаардсан гомдлыг шийдвэрлэх зохицуулалтыг агуулсан байна. Уг механизм нь хуулийн дагуу, эсвэл арбитрайн, эсвэл эвлэрүүлэн зуучлах журмаар хэрэгжиж болох шүүх, захиргааны бусад арга хэрэгслийг ашиглахад саад учруулахгүйгээс гадна ажилтан, ажилчдын байгууллага, эсвэл хамтын гэрээгээр хангагдсан гомдол барагдуулах механизмыг орлохгүй.

Гэрээт ажилчид

22. Гэрээт ажил гүйцэтгэгч болон бусад зүүчлагчаар дамжуулан гэрээт ажилчид авч ажиллуулж байгаа тохиолдолд зээлдэгч нь гэрээ байгуулахаас урьтаж дараах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Үүнд: (i) тэдгээр гэрээт ажил гүйцэтгэгч болон зүүчлагчид өнөөг хүртэл ажил эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хэрхэн ханган гүйцэтгэж ирсэн хийгээд энэхүү ГШ болон ГШ.4-ийн шаардлагуудыг хангах одоогийн чадавхыг нь үнэлэх, (ii) уг ГШ-ын 7-19 ба 21-т заасан шаардлагууд болон ГШ.4-ийн 11-15-д заасан шаардлагуудыг даган биелүүлэхийг тэднээс шаардах.
23. Зээлдэгч нь гуравдагч этгээдийн гэрээлсэн төслийн ажилтан, ажилчдыг ажилд авах, ажиллуулах, ажлаас халахтай холбоотой эрсдлийг тодорхойлж, төсөл болон энэхүү ГШ-ын заалтуудын хүрээнд гуравдагч этгээдийн ажил олгогчдын гүйцэтгэлийг удирдах, хянахад нийцсэн бодлого, журам гаргана. Түүнчлэн, зээлдэгч нь эдгээр шаардлагыг гуравдагч этгээдийн ажил олгогчидтой байгуулах гэрээ хэлэлцээрт тусгахад анхаарч, шаардлагатай бол гэрээний удирдлагын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Туслан гүйцэтгэгч ажиллуулах тохиолдолд зээлдэгч нь гуравдагч этгээдийн зүгээс туслан гүйцэтгэгчидтэй байгуулах гэрээ хэлцэлдээ тэдгээртэй ижил шаардлагыг тусгасан байхад анхаарна.
24. Зээлдэгч нь гэрээт ажилчдыг энэхүү ГШ-ын заалтуудад нийцсэн, гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг ашиглах боломжоор хангана. Гуравдагч этгээд гомдол гаргах механизмыг бүрдүүлж чадахгүй бол зээлдэгч нь гуравдагч этгээдээр дамжуулан ажил гүйцэтгэж буй ажилтан, ажилчдад зориулсан гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг бүрдүүлж өгнө.

²⁸ Ажилтан, ажилчдыг бөөнөөр халах гэдэгт эдийн засгийн, техникийн, эсвэл зохион байгуулалтын шалтгаан, эсвэл тухайн ажилтны гүйцэтгэл буюу бусад хувийн асуудалтай холбоогүй шалтгаанаар орон тоог цөөрүүлэх, ажлын байрыг олноор хасах тохиолдол багтдаг.

Ханган нийлүүлэлтийн сүлжээ

25. ГШ.1-т заасан ханган нийлүүлэлтийн сүлжээг үнэлэх явцад зээлдэгч нь төслийн гол ханган нийлүүлэгчдийн²⁹ үйл ажиллагаанд хүүхдийн хөдөлмөр болон албадан хөдөлмөр³⁰ эрхлүүлэхтэй холбоотой гарах эрсдлийг тодорхойлж үнэлсэн байна.
26. Хэрэв энэхүү эрсдлийн үнэлгээгээр гол ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаанд ОУХБ-ын стандартыг зөрчсөн хүүхдийн хөдөлмөр, эсвэл албадан хөдөлмөр эрхлүүлсэн буюу эрхлүүлэх өндөр эрсдэлтэйг олж тогтоосон, эсвэл төслийн үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа материалын ханган нийлүүлэлтийн сүлжээний доод шатанд хүүхдийн хөдөлмөр, эсвэл албадан хөдөлмөр эрхлүүлэх томоохон эрсдэл бүртгэгдсэн бол зээлдэгч доорх шаардлагуудын дагуу зөрчлийг арилгах тохирсон арга хэмжээ авна. Үүнд:
- (i) Хүүхдийн хөдөлмөртэй холбоотойгоор илэрсэн зөрчлийг сайн санааны үүднээс засах буюу арилгах арга хэмжээ авна. Зээлдэгч тухайн ханган нийлүүлэгчээс дээрх зөрчлийг арилгахад анхаарч авсан арга хэмжээний баталгаа, эсвэл ОУСТ-ын дагуу зөрчлийг арилгах хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа гэсэн нотолгоог хүлээн авсан тохиолдолд л тэрхүү ханган нийлүүлэгчээс үргэлжлүүлэн бараа материал худалдан авна. Түүнчлэн, зээлдэгч тэрхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцыг тогтмол тайлагнаж мэдээлнэ;
 - (ii) Албадан хөдөлмөрлүүлсэн зөрчил илэрсэн тохиолдолд зээлдэгч ханган нийлүүлэгчийн зүгээс албадан хөдөлмөрлүүлэх нөхцлийг арилгах тал дээр хангалттай арга хэмжээ авч байгааг нотолсон баримт хүлээн авсан тохиолдолд л тухайн ханган нийлүүлэгчээс үргэлжлүүлэн бараа материал худалдан авна; мөн
 - (iii) Хүүхдийн ба/буюу албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй холбоотой эрсдэл байгаа тохиолдолд, зээлдэгч ханган нийлүүлэлтийн сүлжээнд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлт, хүүхдийн ба/буюу албадан хөдөлмөр эрхлэлтийн шинэ эрсдэл, тохиолдлыг олж тогтоохын тулд гол ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааг тогтмол хянана. Мөн, гол ханган нийлүүлэгчдийн ажилтан, ажилчдад хор үршигтай эрсдэл үүссэн тохиолдолд зээлдэгч холбогдох ханган нийлүүлэгчдэд ажилтан, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд хор үршигтай эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эсвэл бууруулах зорилгоор журам болон бусад хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тавина. Тэдгээр журам, хяналтын арга хэмжээний үр дүнг тодорхойлох зорилгоор зээлдэгч үе үе хяналт үнэлгээ хийнэ.
27. Зээлдэгчийн дээрх эрсдэлүүдийг бүрэн тодорхойлж шийдвэрлэх чадавх нь түүний гол ханган нийлүүлэгчдийг хэр хэмжээнд удирдан зохицуулж, эсвэл тэдэнд хэр нөлөөлж байгаагаас шалтгаална. Эрсдлийг арилгах, залруулах боломжгүй тохиолдолд зээлдэгч нь эрсдэлд өртсөн гол ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг ЕСБХБ-тай тохиролцсон боломжит хугацааны дотор энэхүү ГШ-ыг хангаж байгаагаа нотолж чадах бусад ханган нийлүүлэгчдэд шилжүүлнэ.

²⁹ Төслийн гол ханган нийлүүлэгчид болон үйл ажиллагааны үндсэн чиг үүргүүдийн тодорхойлолтыг ГШ.1-ийн 28 дахь заалтаас харна уу.

³⁰ ОУХБ-ын 138, 182, 29, 105 дугаар конвенцуудад тодорхойлсноор.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах

Танилцуулга

1. Энэхүү ГШ нь уур амьсгалын нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарал, нөөцийн удирдлага болон бохирдлоос³¹ сэргийлэх, хянахад төслийн түвшинд баримтлах арга замыг тодорхойлсон. Энэ нь нөлөөллийг бууруулах шатлалын арга барил, байгаль орчны хохирлыг нэн тэргүүнд эх үүсвэр дээр нь арилгах ёстой гэсэн зарчим ба “бохирдуулагч өөрөө төлнө” гэсэн зарчимд тулгуурладаг. Төсөлтэй холбоотой эрсдэл ба нөөцийн ашиглалт, хог хаягдлын үүсэл, хийн ялгарлаас үүдэлтэй нөлөөллийг төслийн байршил, орон нутгийн байгаль орчны нөхцөл байдлын хүрээнд үнэлэх шаардлагатай. Нөөцийг үр ашигтай, үр дүнтэй ашиглах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах, хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг бууруулах, багасгах, зайлсхийх чиглэлд шийдвэрлэх арга хэмжээ, технологи, дадлага туршлагыг нэвтрүүлэх ёстой.
2. Уг ГШ урьд өмнө хаягдал³² гэж үзэж байсан зүйлсээс ашиг тустай, үнэ цэнтэй бүтээгдэхүүн гаргаж авах боломжтой нөөцийн нөхөн сэргээлт ба/буюу Тойрог Эдийн Засаг³³ гэсэн шинэ ойлголт, дадал туршлагыг хүлээн зөвшөөрдөг.
3. ГШ нь нөөцийг хамгийн зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, хянахын тулд боломжит хамгийн шилдэг техник, аргачлал, ОУСТ-ыг ашиглах нь чухлыг онцолсон.

Зорилт

4. Энэхүү ГШ дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - нөөцийн ашиглалт, төслөөс ялгарах бохирдлоос үүдэлтэй хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах шатлалын арга барилыг хэрэгжүүлэх;
 - төслийн ХХЯ-аас зайлсхийх, бууруулах, удирдах;
 - пестицид зэрэг аюултай бодис, материалын эрсдэл, нөлөөллийг удирдах, бууруулах, зайлсхийх; болон
 - боломжтой бол нөөцийн үр ашгийг дээшлүүлэх төсөлтэй холбоотой боломжийг тодорхойлох.

Үйлчлэх хүрээ

5. Энэ ГШ нь Байгаль орчин, нийгмийн бодлогод заасанчлан ЕСБХБ-ны санхүүжүүлсэн бүхий л төсөлд үйлчилнэ. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээнийхээ хүрээнд уг ГШ-ын холбогдох шаардлагуудыг тодорхойлж, улмаар тэдгээрийг төсөл хэрэгжих хугацаанд хэрхэн шийдвэрлэж, биелүүлэх талаар авч үзнэ. Энэхүү ГШ-ын заалтуудыг хангахын тулд зайлшгүй авах ёстой арга

хэмжээний хэрэгжилтийг зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо (БОНУТо) болон тухайн төслийн онцлогтой байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНУТө)-ний хүрээнд зохицуулна.

Шаардлага

Нөөцийн зохистой ашиглалт

6. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хүрээнд төсөлтэй холбоотойгоор нөөцийг үр ашигтай ашиглах боломж, хувилбаруудыг ОУСТ-тай үялдуулан тодорхойлно. Ингэхдээ зээлдэгч нь өөрийн эрчим хүч, ус болон бусад нөөц, материалын хэрэглээг багасгах, үр ашгийг нэмэгдүүлэх, мөн төслийг хэрэгжүүлэх явцад гарсан хаягдал материалыг сэргээх, дахин ашиглах тал дээр техникийн болоод санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой³⁴, зардлын үр ашигтай³⁵ арга хэмжээ авна. Гол анхаарлыг төслийн хамгийн чухалд тооцогддог чиг үүргийн үйл ажиллагаанд хандуулах ба зээлдэгчийн төсөлд хамрагдаагүй бизнесийн бусад үйл ажиллагаанд дээрхтэй ижил боломжуудыг мөн авч үзнэ. Жишиж болохуйц буюу суурь мэдээлэл байгаа бол зээлдэгч нь үр ашгийн харьцангуй түвшинг тогтоох зорилгоор өөрийн үйл ажиллагааг ОУСТ-тай харьцуулан үнэлнэ.
7. Зээлдэгч нь түүхий эд материал, эрчим хүч ба ус хэмнэх, байгаль орчинд ялгарч буй хаягдал материалыг багасгах, зайлсхийх зорилготойгоор бүтээгдэхүүний загвар боловсруулах болон үйлдвэрлэх үйл явцдаа нөөцийг зөв зохистой ашиглах арга хэмжээ болон цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх зарчмыг нэвтрүүлж ажиллана.

Ус

8. Техникийн болон санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой, хэмнэлттэй, ОУСТ-ын дагуу ус зарцуулалтыг багасгах, нөхөн сэргээх бүх боломжуудыг тодорхойлж, төсөл боловсруулах ажлын нэг хэсэг гэж авч үзнэ. Төслийн хэрэгцээнд тохирсон усан хангамжийг бий болгох шаардлагатай тохиолдолд зээлдэгч нь боломжтой бол хүний хэрэглээнд тохиромжгүй техникийн зориулалттай ус ашиглахыг эрэлхийлнэ.
9. Усны эрэлт хэрэгцээ өндөртэй (өдөрт 5,000 шоо метрээс их) төслийн хувьд дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - үнэлгээгээр усны нарийвчилсан балансыг гаргаж, тогтоон барьж, ЕСБХБ-нд жил бүр тайлагнах;
 - тусгай зориулалтын усны хэрэглээг (нэгж үйлдвэрлэлд зарцуулсан усны хэмжээгээр хэмжигдсэн) үнэлэх;

³¹ "Бохирдол" гэж хатуу, шингэн эсвэл хийн төлөвт байгаа аюултай болон аюулгүй химийн бохирдуулагчдыг хоёуланг нь хэлдэг ба энэ нь усны дулааны бохирдол, богино болон урт настай уур амьсгалын бохирдуулагчдын ялгарал, хүрээлэн буй орчны бохирдол (хөрс, агаар, усны гэх мэт), эвгүй үнэр, чимээ шуугиан, чичиргээ, цацраг, цахилгаан соронзон энерги, мөн гэрэл гэх мэт боломжит харааны нөлөөг бий болгох зэрэг бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаана.

³² Европын Холбооны Парламент болон Зөвлөлийн хог хаягдлын талаарх болон зарим Захирамжийг (Европын Холбооны хог хаягдлын хүрээний захирамж) хүчингүй болгох тухай 2008 оны 11-р сарын 19-ний өдрийн 2008/98/ЕС тоот Захирамжид тодорхойлсон.

³³ Европын Зөвлөлийн Тойрог эдийн засгийн багцад тусгасан.

³⁴ Техникийн хувьд боломжтой гэдэг нь тухайн санал болгосон арга хэмжээнүүдийг байгаа чадвар, тоног төхөөрөмж, материалыг ашиглан хэрэгжүүлж болох эсэхийг тооцох тухай юм. Ингэхдээ уур амьсгал, газар зүй, дэд бүтэц, аюулгүй байдал, засаглал, чадавх, ажиллагааны найдвартай байдал зэрэг орон нутгийн хүчин зүйлсийг бодолцох ёстой. Санхүүгийн хувьд боломжтой гэдэг нь арилжааны хүчин зүйлс, тухайлбал тийм арга хэмжээнүүд авснаар төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны болон үрсгал зардалтай харьцуулахад үүсч болох нэмэгдэл зардлын харьцангуй хэмжээ ээргийг тооцох тухай болно.

³⁵ Зардлын үр ашиг гэдгийг төслийг хэрэгжүүлэх хугацааны туршид авч үзсэн арга хэмжээний хүрээнд гарах үндсэн хөрөнгийн болон үйл ажиллагааны зардал, санхүүгийн үр ашигт үндэслэн тооцоолно.

- үйл ажиллагааг одоо байгаа үйлдвэрлэлийн стандартууд болон ус ашиглалтын үр ашгийн талаарх ОУСТ-ын жишигт хүргэх; мөн
 - ус ашиглалтын үр ашиг болон нөхөн сэргээлтийн хувьд тасралтгүй сайжруулах боломжуудыг тодорхойлох шаардлагатай.
10. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээнийхээ хүрээнд гуравдагч этгээдийн ус ашиглагчид болон орон нутгийн экотогтолцоотой холбоотойгоор ус олборлолтын хуримтлагдсан нөлөөлөл үүсэж болзошгүйг анхааралдаа авах шаардлагатай. Тус үнэлгээ нь уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй нөлөөг ч мөн авч үзнэ. Сөрөг нөлөөлөл, эрсдэл тогтоогдвол зээлдэгч нөлөөллийг бууруулах шатлалын арга барил болон ОУСТ-ын дагуу тэдгээрийг арилгах тохирсон арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Хаягдал³⁶

11. Зээлдэгч нь хог хаягдлын хэмжээг багасгаж, хаягдал гаргахгүй байхын зэрэгцээ хаягдлын хор үршгийг аль болох багасгах арга хэмжээг авна. Хог хаягдал бий болохоос зайлсхийх боломжгүй боловч хаягдлын хэмжээ нь багассан тохиолдолд зээлдэгч хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээх, эсвэл эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах ба ингэхдээ хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй байдлаар шийднэ. Хог хаягдлыг сэргээх, дахин боловсруулах буюу дахин ашиглах боломжгүй тохиолдолд зээлдэгч нь тухайн хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй, аюулгүй аргаар, түүний дотор хаягдал материалтай харьцах, боловсруулахаас үүсэх ялгаралт, үлдэгдлийн зохистой хяналтыг дотроо агуулсан байгаль орчинд ээлтэй, аюулгүй аргаар, шаардлагатай бол ЕХ-ны байгаль орчны стандартын дагуу зохих ёсоор цэвэрлэх ба/буюу зайлуулах шаардлагатай.
12. Гарсан хаягдлыг үндэсний ба/буюу ЕХ-ны дүрэм журмын хүрээнд аюултай гэж үзвэл зээлдэгч хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхтэй холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй хязгаарлалтууд болон холбогдох бусад хууль эрх зүйн шаардлагуудыг харгалзан үзнэ.
13. Зайлуулах хог хаягдлыг талбайгаас шилжүүлсэн ба/буюу гуравдагч этгээдээр энэ ажлыг хийлгэсэн бол, зээлдэгч хаягдлыг хаях эцсийн цэг хүртэлх хадгалан хамгаалалтын хэлхээний баримт бичгийг авах ба холбогдох зохицуулах эрх бүхий байгууллагаар баталгаажсан тусгай зөвшөөрөлтэй гэрээлэгчээр тус ажлыг гүйцэтгүүлнэ. Зээлдэгч нь хог хаягдлын менежментийн тухайд зохих анхаарал тавих үүрэг хүлээнэ.

Бохирдлоос сэргийлэх ба хянах

14. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээгээрээ төсөлд авч хэрэгжүүлэх бохирдлоос сэргийлэх болон хянах тохиромжтой арга, технологи, дадлага туршлага ("техник")-ыг тодорхойлно. Энэхүү үнэлгээ нь төслийн бүрэлдэхүүнд багтаж буй байгууламж, үйл ажиллагааны онцлог, төслийн газар зүйн байрлал болон орон нутгийн байгаль орчны нөхцөл байдлыг харгалзан авч үзнэ. Түүнчлэн, тус үнэлгээгээр хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах эсвэл

зайлсхийхэд хамгийн тохирсон, техникийн болон санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой, зардал багатай, бохирдлоос сэргийлэх, хянах техникийг тодорхойлно. Төсөлд ашиглах тэрхүү техник нь эрсдэл, нөлөөллийг бууруулах, багасгахаас илүүтэйгээр сэргийлэх, зайлсхийхэд чиглэсэн байх шаардлагатай ба нөлөөллийг бууруулах шатлалын арга барилд тулгуурласан, ОУСТ-д нийцсэн, мөн төслийн сөрөг нөлөөлөл, эрсдлийн мөн чанар, цар хүрээнд тохирсон байвал зохилтой.

15. Зээлдэгч нь төслийн түвшинд³⁷ дагаж мөрдөж болохуйц ЕХ-ны холбогдох байгаль орчны стандартыг хангасан байхаар төслийг боловсруулсан байна. Шинж чанар, цар хүрээнээсээ хамааран ЕХ-ны үйлдвэрлэлээс ялгарах хаягдлын талаарх захирамжийг³⁸ дагаж мөрдөх ёстой төслүүдийн хувьд байршлаасаа үл хамааран ЕХ-ны Хамгийн сайн боломжит техник (ХСБТ), мөн ЕХ-ны ХСБТ-ийн Дүгнэлт-д заасан холбогдох бохирдол ялгаруулалтын түвшний стандартыг хангасан байх шаардлагатай.
16. Төслийн түвшинд дагаж мөрдөх шаардлагатай ЕХ-ны аливаа байгаль орчны бодитой стандарт байхгүй тохиолдолд зээлдэгч нь ЕСБХБ-тай тохиролцсоны үндсэн дээр ОУСТ-тай үялдуулан байгаль орчны бусад стандартыг сонгон мөрдөж болно. Үүнээс гадна, төслийг холбогдох үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах ба төсөл нь үндэсний хууль тогтоомж, дүрэм журмын бусад шаардлагуудын дагуу тохинож, үйл ажиллагаа явуулна. Хүлээн авагч улсын дүрэм журам нь ЕХ-ны байгаль орчны стандарт болон мэдэгдэж буй байгаль орчны бусад зохих стандартад заасан түвшин, арга хэмжээнээс өөр байвал тэдгээрээс хамгийн хатуу, чанга шаардлагатайг нь дагаж баримтална.
17. Төслүүд анхнаасаа ЕХ-ны байгаль орчны стандартууд, эсвэл дагаж мөрдөхөөр тохиролцсон байгаль орчны бусад стандартууд болон тухайн улс орны дүрэм журмын шаардлагуудад нийцсэн байх ёстой. Одоо байгаа барилга байгууламж ба/буюу үйл ажиллагаатай холбоотой төслийн хувьд тэдгээр байгууламж ба/буюу үйл ажиллагаа нь зохих хугацааны туршид энэхүү ГШ-ын 15 болон/эсвэл 16-р заалтыг хангасан байх шаардлагатай ба төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл нь холбогдох стандартад нийцэж байгаа эсэхийг албан ёсны үнэлгээгээр тодорхойлно.
18. ЕХ-ны гишүүн орнууд, ЕХ-нд нэгдэж буй, нэгдэхээр нэр дэвшсэн, нэр дэвшиж болзошгүй улс орны нутаг дэвсгэрт байрладаг, одоо байгаа барилга байгууламж ба/буюу үйл ажиллагааг сэргээн сайжруулахад чиглэсэн бөгөөд ЕХ-ны холбогдох байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөхөөр тохиролцсон төслүүдийн хувьд эдгээр стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх цаг хугацаа нь тухайн улсын зүгээс зөвшөөрсөн цаг хугацааг харгалзан үзнэ. Бусад бүх улс оронд хэрэгжиж буй төслүүдийн хувьд ЕХ-ны байгаль орчны стандартуудад нийцүүлэн хэрэгжүүлэх цаг хугацаа нь орон нутгийн нөхцөл, стандартыг авч хэрэгжүүлэх өртөг зардлыг тооцсон байх ба Европын хөршийн бодлого, мөн ЕХ болон тухайн хүлээн авагч улсын хооронд тохиролцсон хоёр талт гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцсэн байх шаардлагатай.

³⁶ Энэхүү ГШ-ын хүрээнд хог хаягдал гэдэг нь байгаль орчинд халгүй байдлаар хаяхаас өмнө физик, химийн ба/буюу биологийн зохистой үйл явцыг ашиглан боловсруулах, цэвэрлэх шаардлагатай хийн, шингэн ба/буюу хатуу бодис, материалын гетероген холимог гэж тодорхойлсон.

³⁷ Энэхүү ГШ-ын хувьд, ЕХ-ны 2 дахь шатны эрх зүйн баримт бичигт төслийн түвшинд (тухайлбал, хүрээлэн буй орчинтой харьцуулсан) хэрэгжүүлэх тоон болоод чанарын тодорхой шаардлагууд орсон байвал ЕХ-ны байгаль орчны стандартуудыг тухайн төслийн түвшинд ашиглаж болно.

³⁸ Европын Холбооны Парламент болон Зөвлөлийн үйлдвэрлэлээс ялгарах хаягдлын талаарх (бохирдлын нэгдсэн сэргийлэлт ба хяналт) 2010 оны 11-р сарын 24-ний өдрийн 2010/75/EU тоот захирамж

19. Төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид, зээлдэгч нь техникийн болон санхүүгийн хувьд хэрэгжих боломж, хэмнэлттэй байдлаа хадгалахын зэрэгцээ хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах шатлалын арга барилд нийцсэн бохирдлоос сэргийлэх, хянах техникийг ашиглана. Энэ нь ердийн, ердийн бус, эсвэл санамсаргүй нөхцөл байдлын улмаас үүссэн бохирдуулагч бодист ч хамаарна.

Хүлэмжийн хий

20. Зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь төслийг боловсруулж, хэрэгжүүлэх явцад төсөлтэй холбоотой ХХЯ-аас зайлсхийх, хамгийн бага хэмжээнд байлгах чиглэлд олон хувилбаруудыг авч үзэх ба техникийн болон санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой, зардал багатай хувилбаруудыг сонгон хэрэгжүүлнэ. Эдгээр хувилбарууд нь төсөл хэрэгжих өөр байршил, техник, үйл явц болоод сэргээгдэх буюу нүүстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, тогтвортой хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон мал аж ахуйн менежментийн арга түршлага, дэгдэмхий ялгаралтыг бууруулах, хийн шаталтыг бууруулах зэрэг арга хэмжээ байж болох ба эдгээрээр хязгаарлагдахгүй болно.
21. Төслүүдээс (1) жилд 100,000 тонноос илүү хэмжээний CO₂-той тэнцэх нийт ялгаралтай, эсвэл ялгаралтай байхаар хүлээгдэж буй; эсвэл (2) хөрөнгө оруулалт хийсний дараа жил бүр 25,000 тонноос илүү хэмжээний CO₂-той тэнцэх эерэг эсвэл сөрөг ялгаралтын цэвэр өөрчлөлт бий болгоно гэж тооцоолж буй төслүүдийн хувьд хувьд зээлдэгч нь тэдгээр ялгаралтын хэмжээг ЕСБХБ-ны Хүлэмжийн хийн ялгаралтын үнэлгээний аргачлалын дагуу тооцоолно. ХХЯ-ын үнэлгээний хамрах хүрээ нь төсөлд хамаарах байгууламж, үйл ажиллагаа болон ашиглалтаас гарч буй бүх шууд ялгаралтаас гадна төсөлд ашигласан эрчим хүчний үйлдвэрлэлтэй холбоотой шууд бус ялгаралтыг мөн багтаан авч үзнэ. Зээлдэгч ХХЯ-ын хэмжээг тооцох ажлыг жил бүр хийх ба ЕСБХБ-нд тайлагнана.

Аюултай бодис болон материалын зохистой ашиглалт ба удирдлага

22. Төсөлтэй шууд холбоотой бүхий л үйл ажиллагаанд, зээлдэгч аюултай бодис, материалын хэрэглээг багасгах буюу зайлсхийх ба хүний эрүүл мэнд болон байгаль орчныг тэдгээр бодисын хор хөнөөлтэй байж болзошгүй нөлөөллөөс хамгаалах үүднээс тэдгээрийг аюул багатай бодис, материалаар орлуулан ашиглахад анхаарна. Зайлсхийх, эсвэл орлуулах боломжгүй бол зээлдэгч нь төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор аюултай материал үйлдвэрлэх, тээвэрлэх, зохицуулах, хадгалах, ашиглах болон зайлуулах явцад агаар, ус ба/буюу хөрсөнд тэдгээр аюултай бодис/материал алдагдах нөхцлийг багасгах болон хяналт тавих зорилгоор зохих эрсдлийн удирдлагын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
23. Зээлдэгч нь амьд организм болон байгаль орчны тогтвортой байдалд ихээхэн хортой, био хуримтлал үүсгэх, озоны үе давхаргыг задлах боломжтойн улмаас олон улсын хоригт багтсан бөгөөд аажмаар хэрэглээнээс хасагдаж буй аюултай бодис, материалын үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнээс зайлсхийнэ.

Хортон шавжийн менежмент

24. Пестицидтэй харьцаж, эсвэл ашиглаж байгаа зээлдэгчид нь хортон шавжийн менежментийн үйл ажиллагаандаа хортон шавжийн нэгдсэн менежмент (IPM-integrated pest management) ба/буюу халдвар тараагчтай тэмцэх нэгдсэн менежмент (IVM-integrated vector management)-ийн арга зарчмыг боловсруулж хэрэгжүүлнэ. Зээлдэгчийн IPM болон IVM хөтөлбөр нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн хортон шавжаас үүдэлтэй хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс хортон шавжийн болон байгаль орчны мэдээллийг уламжлалт арга, биологийн болон генетик арга, мөн химийн аргачлал зэрэг одоогоор ашиглагдаж буй хортон шавжийг хянах аргуудын хамт ашиглах ажиллагааг зохицуулна. Хортон шавжийн менежментийн үйл ажиллагааны хүрээнд пестицид ашиглахаар бол зээлдэгч нь биологийн олон янз байдал болон хүний эрүүл мэнд, цаашлаад байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах ба пестицидийн тогтвортой хэрэглээг бий болгох, мөн ургац хамгаалах арга, технологитой уялдуулан пестицидийн эрсдэл, хэрэглээг ихээхэн багасгах тал дээр анхаарч ажиллана.
25. Пестицидийн тогтвортой хэрэглээ гэдэгт дараах арга хэмжээнүүд багтана. Үүнд:
- биологийн олон янз байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд пестицидийн үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол багасгах;
 - хамгийн аюултай бодисыг аюул багатай (химийн бус бодис зэрэг) хувилбараар орлуулах замаар хортой идэвхит бодисыг түвшинг бууруулах;
 - тоос хүртээгч шавж зэрэг зорилтот бус төрөл зүйл болон байгаль орчинд нөлөө багатай, зорилтот төрөл зүйлийн эсрэг үр дүнтэй болох нь тогтоогдсон, хоруу чанар багатай пестицидийг сонгож ашиглах;
 - пестицид бага хэрэглэдэг, эсвэл пестицид ашигладаггүй, IPM болон IVM стратегид түшиглэсэн газар тариаланг дэмжих; мөн
 - зорилтот хортон шавжийн байгалийн дайснуудад учрах хохирлыг багасгаж, хортон шавжийн тэсвэртэй байдлыг бий болгохоос урьдчилан сэргийлэх.
26. Зээлдэгч пестицидийг ОУСТ-ын дагуу зохицуулах, хадгалах, хэрэглэх, зайлуулах үүрэг хүлээнэ.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 4: Эрүүл мэнд, аюулгүй байдал ба хамгаалалт

Танилцуулга

1. Энэхүү ГШ нь төслийн ажилтан, ажилчид, төслийн нөлөөлөлд өртсөн олон нийт, хэрэглэгчдэд үүссэн төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын эрсдлийг нөлөөлөл, эрсдлийн хяналтын шатлалын³⁹ арга зарчмын дагуу зохицуулах нь чухал болохыг онцлон авч үзсэн. Ажилтан, ажилчдыг аюулгүй, эрүүл, хамгаалалттай орчноор хангаснаар зээлдэгч нь үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх зэрэг бодит ашиг тусыг бий болгож болно.
2. Төслийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, дэд бүтэц нь ажилтан, ажилчид болон олон нийтийн хувьд бэлтгэл ажил, барилга угсралт, ашиглалтад оруулах, ажиллуулах, засвар үйлчилгээ, татан буулгах буюу хаах, сэргээн босгох болон бараа, үйлчилгээг тээвэрлэхтэй холбоотой гэх мэт эрүүл мэнд, аюулгүй байдлын болон хамгаалалтын эрсдэлд өртөх магадлалыг ихэсгэж болзошгүй.
3. Зээлдэгч нь ажилтан, ажилчдаа эрүүл, аюулгүй нөхцлөөр хангах үндсэн үүрэгтэй ба ажилтан, ажилчдад эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаар мэдээлж, зааварлаж, сургаж, зөвлөж, хяналт тавина. Ажилтан, ажилчид ажил олгогчтойгоо идэвхтэй хамтран ажиллаж, өөрсдийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд санаа тавих үүрэгтэй.
4. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах нь эрх бүхий байгууллагын үүрэг болохыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ зээлдэгч нь төслөөс үүдэлтэй нөлөөлөлд өртсөн олон нийтэд тулгарсан эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын эрсдлийг удирдан зохицуулах үүрэгтэй.

Зорилт

5. Уг ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - төсөлтэй холбоотой аливаа эрсдэлд тохирсон эрүүл, аюулгүй, хамгаалалттай нөхцлийг бүрдүүлэх болон удирдлагын тогтолцоог бий болгох замаар ажилтан, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтыг дэмжих, хамгаалах; мөн
 - төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид төслийн ердийн болон тохиолдлын үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн олон нийт, хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг тодорхойлох, үнэлэх, зохицуулах.

Үйлчлэх хүрээ

6. ГШ нь Байгаль орчин, нийгмийн бодлогод заасанчлан ЕСБХБ-ны санхүүжүүлсэн бүхий л төсөлд үйлчилнэ. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээнийхээ

хүрээнд уг ГШ-ын холбогдох шаардлагуудыг тодорхойлж, тэдгээрийг төсөл хэрэгжих хугацаанд хэрхэн тусгаж, биелүүлэх талаар авч үзнэ. Ажилтан, ажилчид болон төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтэд учирч болзошгүй эрсдэл нь төслийн хөрөнгө дайчилгаа, барилга угсралт, ашиглалтад оруулах, хэрэгжилт, засвар үйлчилгээ, татан буулгалт буюу хаалт болон сэргээн босголтын аль үе шатанд байгаагаас хамааран өөр өөр байж болно. Энэхүү ГШ-ыг хангахад шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зээлдэгч нь ГШ 1-т заасны дагуу байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо (БОНУТо) ба төсөлд зориулсан байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНУТө)-ний салшгүй хэсэг болгон зохицуулна.

7. Бохирдол гаргасны улмаас хүний эрүүл мэндэд учруулах эрсдэл болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хянах талаар нарийвчилсан шаардлагыг ГШ.3-т оруулав.

Шаардлага

Эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын ерөнхий шаардлага

8. Зээлдэгч төслийн үйл ажиллагааны улмаас буюу түүнтэй холбоотойгоор, эсвэл төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад ажилтан, ажилчид ба төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтэд учирсан аливаа осол, гэмтэл болон өвчлөлийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах бөгөөд эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлийг зохицуулах чиглэлд урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ болон төлөвлөгөөг нөлөөллийг бууруулах шатлалын арга барил болон ОУСТ-тай үялдуулан боловсруулж, хэрэгжүүлнэ.
9. Зээлдэгч нь ажилтан, ажилчид, нөлөөлөлд өртсөн олон нийтэд холбогдох мэдээлэл, зааварчилгаа өгөх ба эрүүл мэнд, аюулгүй байдлын алдагдал, эрсдэл, хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, мөн төслийн явцад эрүүл мэнд, аюулгүй байдалд нь шаардлагатай яаралтай тусламжийн зохицуулалтын талаар сургалт явуулна.
10. Төсөлтэй холбоотой ажлын гүйцэтгэлийн үед ямар нэгэн өвчин, осол, гэмтэл гарсан эсвэл гарч болзошгүй тохиолдолд зээлдэгч болсон явдлыг судалж, баримтжуулж, үр дүнг нь шинжлэн дүгнэж, тэрхүү үйл явдал дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж хамтран ажиллана.

³⁹ Эрсдлийн хяналтын шатлал гэж: (i) эрсдлийг арилгах; (ii) аюултай нөхцөл, бодисыг аюулгүй буюу аюул багатай бодисоор орлуулах замаар эрсдлийг бууруулах; (iii) өртөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд эрсдлийг тусгаарлах; (iv) ажиллах хүч, олон нийтийг хамтдаа хамгаалдаг инженерийн хяналтыг нэвтрүүлэх; мөн (v) шаардлагатай бол ажилтан, ажилчид болон олон нийтийг эрсдэл, аюулгүй ажиллагааны тогтолцоо, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, тайлагнах шаардлага болон заавал гүйцэтгэх хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зааварчилгаа, сургалтаар хангах үйл ажиллагааг хэлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

11. Зээлдэгч нь ажилтан, ажилчдыг эрүүл, аюулгүй ажлын байраар хангах ба тодорхой салбар болон аюулын нарийвчилсан ангилалд анхнаасаа байдаг эрсдлийг харгалзан үзнэ. Зээлдэгч аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл, төслийн үе шат, хэмжээ, мөн чанарт тохирсон хамгаалалтын арга хэмжээг ЕХ-ны холбогдох Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н⁴⁰ стандарт ба ОУСТ-ын дагуу тодорхойлно. Зээлдэгч нь эрсдлийн түвшинд дүйцсэн үнэлгээ хийж, өөрийн БОНУТо-нд нэгтгэн хэрэгжүүлэхэд тохирох төслийн онцлогт нийцсэн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагааны төлөвлөгөө боловсруулна. Тэрхүү төлөвлөгөөний үр дүн болон холбогдох эрсдлийг хэмжих үнэлгээг тогтмол давтамжтайгаар хийж гүйцэтгэнэ.
12. Зээлдэгч нь эрсдлийн хяналтын шатлалын дагуу ХАБЭА хариуцсан ажилтны түслэмжтайгаар ХАБЭА-н арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх бөгөөд ажилтан, ажилчдаа хувийн хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангана. Зээлдэгч нь гэрээт ажилчид, гэрээгээр ажил гүйцэтгэгч нар болон төслийн газарт ажиллах буюу төслийн голлох чиг үүрэгт шууд хамаарах ажил үүргийг гүйцэтгэх бусад гуравдагч этгээдийг аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн ажиллахыг шаардана.
13. Зээлдэгч төслийн бүхий л ажил гүйцэтгэлийн явцад ажилтан, ажилчид нь тоног төхөөрөмжийг зохистой ашиглаж, аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг бүрэн дагаж хэрэгжүүлэх нөхцлийг хангахын тулд бүх ажилтан, ажилчдыг тасралтгүй, зохистой мэргэжлийн удирдлагаар хангана.
14. Зээлдэгч өөрийн ажилтан, ажилчдын эрүүл мэнд, сайн сайхан байдалд хяналт тавих ба ХАБЭА-н зохицуулалтын талаар тэдэнтэй зөвшилцөж, ажилтан, ажилчдыг аюул тулгарсан нөхцөл байдалд ажиллахаа зогсоох, ажлын байранд үүссэн аливаа аюултай нөхцөл байдал, үйлдлийн талаар мэдээлэхийг дэмжих болно. Үүнд: ослыг мөрдөн шалгах, эрсдлийг үнэлэх, хөдөлмөрийн аюулгүй тогтолцоог бүрдүүлэх болон ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сонгох зэрэг багтана.
15. Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, урт болон богино хугацааны эрүүл мэндийн нөхцөл шалтгаан зэрэг эмзэг асуудалтай ажилтан, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох тодорхой үйл ажиллагаатай холбоотой онцгой эрсдэлүүд байгаа бол, зээлдэгч эрсдлийн нарийвчилсан үнэлгээ явуулж, осол гэмтэл, өвчлөлөөс сэргийлэх зохицуулалт хийнэ.

Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал

16. Зээлдэгч төслийн нөлөөлөлд өртсөн байж болзошгүй олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд төслийн үлмаас үүссэн эрсдэл, сөрөг нөлөөллийг тодорхойлж үнэлэх ба эрсдэл, нөлөөллийн түвшинд тохирсон бөгөөд төслийн үе шат, цар хүрээ, шинж чанарт нийцсэн урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах ба хамгаалах арга хэмжээг боловсруулна. Зээлдэгч нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон төлөвлөгөөний талаар төслийн нөлөөлөлд өртсөн олон нийт болон холбогдох бусад оролцогч талуудтай зохих ёсоор харилцана. Эдгээр арга хэмжээ нь эрсдлийг хянах шатлал, ОУСТ-д нийцсэн байна.

17. Төслийн үйл ажиллагаанаас олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах нөлөөллийг бууруулах буюу түүнээс зайлсхийх арга хэмжээ авах нь холбогдох төрийн байгууллагын үүрэг байж болно. Энэ тохиолдолд зээлдэгч тэрхүү холбогдох төрийн байгууллагад мэдэгдэх, хамтран ажиллах үүрэг, хариуцлагаа тодорхой болгоно.

Жендэрт суурилсан хүчирхийлэл

18. Зээлдэгч төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийтэд учирч болзошгүй бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг ба хүчирхийлэл зэрэг жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдлийг үнэлнэ. Боломжтой бол зээлдэгч тэдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, үүний дотор тохиолдлыг мэдээлэх нууц суваг бүрдүүлж өгөх, дэмжлэг үзүүлэх зэрэг онцлог арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын нарийвчилсан шаардлагууд

Дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зураг төсөл болон аюулгүй ажиллагаа

19. Зээлдэгч нь гуравдагч этгээд болон төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах эрсдлийг харгалзан ОУСТ-д заасны дагуу төсөл боловсруулах, төслийн бүтээн байгуулалтын ажил, төслийг хэрэгжүүлэх, засвар үйлчилгээ болон төслийн гол бүрэлдэхүүн хэсэг буюу бүтцийн элементүүдийг татан буулгах зэрэг бүх үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлуудыг тусган авч үзнэ. Бүтцийн элементүүдийн зураг төсөл, бүтээн байгуулалтыг мэргэшсэн чадварлаг мэргэжилтнүүдээр гүйцэтгүүлнэ. Төслийн гол байгууламжуудыг мэргэшсэн, туршлагатай мэргэжилтнээр төлөвлүүлж гүйцэтгүүлнэ. Нийтийн зориулалттай шинээр баригдсан бүх барилга байгууламж ба тэдгээрийн шинэчлэлийг ашиглалтанд хүлээлгэн өгөхийн өмнө гуравдагч этгээдийн амь нас, галын аюулгүй ажиллагаанд хөндлөнгийн шалгалт хийх шаардлагатай.
20. Нийтийн зориулалтаар ашиглах байгууламжийн барилга угсралт болон томоохон засвар шинэчлэлийг бүх нийтэд хүртээмжтэй⁴¹ байх гэсэн зарчмын дагуу төлөвлөнө.
21. Далан, хаягдлын далан, үнсэн сан зэрэг бүтцийн элемент буюу бүрэлдэхүүн хэсгүүд нь өндөр эрсдэл бүхий газарт байрладаг ба тэдгээрийн эвдрэл, гэмтэл нь ажилтан, ажилчид болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй тохиолдолд зээлдэгч нь ижил төрлийн төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай, олонд танигдсан нэг буюу түүнээс дээш мэргэжилтнийг татан оролцуулж, зураг төсөл, барилга хариуцсан мэргэжилтнүүдээс тусдаа ажиллуулна. Тэд төсөл боловсруулах, төслийн бүтээн байгуулалт, хэрэгжилт, хүлээлгэн өгөх бүхий л шатанд аль болох эртнээс тэдгээр бүтцийн элемент буюу бүрэлдэхүүн хэсгүүдийн аюулгүй байдал болон бүтцийн нэгдмэл байдалд үнэлгээ хийнэ.

Аюултай материалын аюулгүй байдал

22. Зээлдэгч нь эрсдлийн хяналтын шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар ажилтан, ажилчид болон төслийн нөлөөлөлд автсан олон нийтийн төслөөс гарч болзошгүй аюултай материалд⁴² өртөх боломжийг

⁴⁰ Европын холбооны АБЭМАА (ОHS)-ны стандартад ажилтан, ажилчдыг хамгаалах зорилготой наад захын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг тогтоосон ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба Европын холбооны хууль тогтоомжид тусгагдсан шаардлагууд багтана.

⁴¹ Бүх нийтэд хүртээмжтэй гэж бүх насны болоод ямар ч чадвартай хүмүүс бүхий л тохиолдолд болон ямар ч нөхцөл байдалд аюулгүй бөгөөд чөлөөтэй нэвтрэх боломжтой байхыг хэлнэ.

⁴² Аюултай материал гэдэг нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж чадах нэг буюухэд хэдэн аюултай шинж чанартай бодисыг хэлдэг.

багасгах буюу урьдчилан сэргийлнэ. Ажилтан, ажилчид болон төслийн нөлөөлөлд өртсөн олон нийт аюулд орж болзошгүй тохиолдолд зээлдэгч нь аюул үүсгэж буй нөхцөл, эсвэл аюултай бодисыг өөрчлөх, орлуулах болон арилгах байдлаар тэдний аюулд өртөх байдлыг хянан зохицуулахад анхаарал хандуулна.

23. Төсөлд холбогдох одоо байгаа барилга байгууламж, эсвэл үйл ажиллагаанд аюултай материал ашиглах тохиолдолд зээлдэгч нь ажилтан, ажилчид ба төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтийг тэрхүү аюултай материалд өртөхөөс сэргийлэхийн тулд төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, хэрэгжүүлэх болон хаах үеэр зохих ёсоор анхаарал тавих болно. Ийм материалаас шалтгаалсан аюулаас зайлсхийх боломжгүй бол зээлдэгч нь ОУСТ-ын дагуу тухайн материалтай харьцах, ашиглах, хадгалах, тээвэрлэх, зайлуулахад шаардлагатай арга хэмжээ авна.
24. Зээлдэгч хог хаягдал гэх мэт аюултай материалыг аюулгүй, найдвартай тээвэрлэх чиглэлд зохих хүчин чармайлт гаргаж, төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтийг аюулд орохоос зайлсхийх болон эрсдлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Бүтээгдэхүүний аюулгүй байдал

25. Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл ба/буюу худалдаа эрхэлж буй төслийн хувьд зээлдэгч нь үйлдвэрлэлийн үйл явц, төлөвлөлтийг сайжруулах, бүтээгдэхүүний түгээлтэнд зориулсан хадгалалт, зохицуулалт, тээвэрлэлтийг хангалттай хэмжээнд шийдвэрлэх замаар бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана. Тухайн улс орон, бизнесийн салбарын бүтээгдэхүүний аюулгүй байдлын стандарт болон дүрэм журамд хамаарах аюулгүй байдлын ерөнхий шаардлага зэрэг ОУСТ-ыг дагаж мөрдөнө.
26. Төслийн үнэлгээний явцад зээлдэгч өөрийн бүтээгдэхүүнтэй холбоотой хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдлийг амьдралын мөчлөгийнх нь туршид тодорхойлж, үнэлнэ. Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахдаа эрсдлийн хяналтын шат дарааллыг дагаж мөрдөх ба хэрэглэгчдэд бүтээгдэхүүн тэдний эрүүл мэнд, аюулгүй байдалд ямар эрсдэл үүсгэж болзошгүй талаар хангалттай мэдээлэл хүргэнэ. Бүтээгдэхүүн нь эрүүл мэндэд ноцтой аюул занал учруулж болзошгүй нөхцөлд зээлдэгч түүнийг зах зээлээс эргүүлэн татах буюу устгах бодлого, журам баримтална.

Олон нийтийн үйлчилгээн дэх эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл

27. Төслийн үйл ажиллагааны хүрээнд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх тохиолдолд зээлдэгч тухайн үйлчилгээ нь ажилтан, ажилчид, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байхад анхаарсан чанарын удирдлагын зохих тогтолцоог хэрэгжүүлэх ба тухайн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллана.
28. Төсөл нь олон нийтэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулах тохиолдолд зээлдэгч тухайн үйлчилгээг аль болох бүх нийтэд хүртээмжтэй байлгах зарчмыг баримтална.
29. Төсөл эрүүл мэндийн үйлчилгээ ба/буюу антибиотикийн хэрэглээтэй холбоотой бол зээлдэгч антибиотикийн зохистой хэрэглээг дэмжих хяналтыг⁴³ хэрэгжүүлнэ.

Замын хөдөлгөөн болон замын аюулгүй байдал

30. Зээлдэгч төслийг хэрэгжүүлэх хугацаанд төслийн нөлөөлөлд өртсөн олон нийт болон ажилтан, ажилчдад учирч болзошгүй замын хөдөлгөөн, замын аюулгүй байдлын эрсдлийг тодорхойлох, үнэлэх, хяналт шинжилгээ хийх ба шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулна. Нийтийн эзэмшлийн зам болон бусад хэлбэрийн дэд бүтэц байрлах талбайд хөдөлгөөнт тоног төхөөрөмж ажиллуулж буй төслийн хувьд зээлдэгч нь эдгээр тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотойгоор олон нийтийн дунд осол, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
31. Зээлдэгч ЕХ-ны холбогдох зам, замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны удирдлагын стандартыг⁴⁴ харгалзан үзэж, моторт болон моторт бус тээврийн хэрэгсэл бүхий зам ашиглагчдад аль алинд нь зориулсан замын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлох бөгөөд төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд учирч болзошгүй замын аюулгүй байдлын нөлөөллийг бууруулах зорилгоор техникийн болон эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой, зардал багатай замын аюулгүй байдлын арга хэмжээг төслийн зураг төсөлд тусгаж өгнө. Шаардлагатай бол зээлдэгч төслийн үе шат бүрт замын аюулгүй байдлын аудит хийх ба аюулгүй байдалтай холбоотой сөрөг асуудал, хандлагыг тодорхойлж, шийдвэрлэхийн тулд осол, гэмтлийн тайлан мэдээг тогтмол хянана. Тээврийн хэрэгсэлтэй буюу тээврийн хэрэгслийн парк (эзэмшдэг буюу лизингээр авсан) ажиллуулж буй зээлдэгч нь зам ба замын хөдөлгөөний эрсдлийг удирдах ОУСТ-ын зохицуулалтыг⁴⁵ нэвтрүүлж, ажилтан, ажилчдын дунд жолоочийн болон тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын талаарх зохих сургалтыг зохион байгуулна. Зээлдэгч төслийн бүх тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хангана.

Байгалийн аюул

32. Зээлдэгч нь газар хөдлөлт, зуд, хөрсний нуралт, үер зэрэг байгалийн аюулаас үүдэлтэй болзошгүй эрсдлийг тодорхойлж, үнэлнэ. Энэ нь зээлдэгчээс уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлд төслийн өртөх эмзэг байдлыг үнэлж, төслийн загварт нэгтгэн оруулбал зохих уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох арга хэмжээг тодорхойлохыг шаардаж болно.
33. Зээлдэгч нь байгалийн аюул, газар ашиглалтын өөрчлөлтөөс үүдэлтэй, төслийн нөлөөтэйгөөр улам өссөн эрсдлийг багасгах буюу зайлсхийх арга хэмжээ авна.

Өвчлөлд өртөх

34. Эмзэг бүлгийнхний өвчлөлд өртөмхий байдал харилцан адилгүй, мэдрэмтгий чанар өндөр байдгийг харгалзан, ажилтан, ажилчид, олон нийтийн өвчлөлд өртөх магадлалыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлдэгч нь холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөний үндсэн дээр эрсдэл, нөлөөллийг бууруулах тохирсон арга хэмжээг боловсруулна. Зээлдэгч төслийн түр хугацааны болон/эсвэл байнгын ажилтан, ажилчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байж болзошгүй халдварт өвчний тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээ авна.

⁴³ Антибиотикийн зохистой хэрэглээг дэмжих хяналт нь ДЭМБ-ын тодорхойлсноор антибиотик зэрэг нянгийн эсрэг эм бэлдмэлийн зохистой хэрэглээг хөхиүлэн дэмждэг, өвчтөний биеийн байдлыг сайжруулж, нянгийн эсэргүүцлийг багасгаж, олон эмэнд тэсвэртэй организм буюу нянгаас үүдэлтэй халдварын тархалтыг бууруулдаг нэгдсэн зохицуулалттай хөтөлбөр юм.

⁴⁴ Европын холбооны Автозамын дэд бүтцийн аюулгүй ажиллагааны удирдлагын тухай 2008 оны 11-р сарын 19-ний өдрийн 2008/96/ЕС тоот захирамжийн зорилгод нийцэн байх.

⁴⁵ ISO 39001 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандарт гэх мэт олон улсын сайн туршлагын дагуу.

35. Төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтийн дунд өмнө нь тодорхой өвчин тархсан бол зээлдэгч төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд ажилтан, ажилчид болон нөлөөлөлд өртсөн олон нийтийн дунд цаашид тухайн өвчний тархалтыг бууруулах нөхцөл боломжийг тодорхойлох нь зүйтэй. Зээлдэгч төслийн түр хугацааны болон/эсвэл байнгын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байж болох жендэрт суурилсан эрсдэлээс сэргийлэх, халдварт өвчний тархалтыг багасгах, зайлсхийх арга хэмжээ авна.

Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээ

36. Зээлдэгч нь төсөлтэй холбоотой аливаа осол, гэмтэл, онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах бэлтгэлтэй байх шаардлагатай ба тэрхүү бэлтгэл нь төсөлтэй холбоотой үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл, үүсэж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах хэрэгцээ шаардлагад нийцсэн, холбогдох хууль дүрмийн шаардлага ба ОУСТ-тай үялдсан байвал зохино⁴⁶.

37. Зээлдэгч томоохон ослын аюулыг тодорхойлон үнэлж, түүнээс сэргийлэх буюу ажилтан, ажилчид ба төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтэд учрах эрсдэл, байгаль орчинд илрэх сөрөг нөлөөллийг хязгаарлахад шаардлагатай арга хэмжээг авна. Ингэхдээ хүмүүс болоод байгалийг зохистой бөгөөд үр дүнтэй хэлбэрээр хамгийн дээд түвшинд хамгаалахыг эрмэлзэнэ. Уг арга хэмжээг зээлдэгчийн БОНУТо-той үялдуулсан томоохон ослоос сэргийлэх/ онцгой байдлын бэлэн байдлыг хангах бодлого болон тохирох удирдлагын төлөвлөгөөнд тусган оруулна. Төлөвлөгөөнд зээлдэгч төслөөс үүссэн аюултай холбоотой онцгой байдлын үед ОУСТ-ын дагуу үр дүнтэй хариу арга хэмжээ авах чадавхтай болохыг батлах зорилгоор дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах байгууллагын бүтэц, үүрэг хариуцлага, дүрэм журам, харилцаа холбоо, сургалт, хөрөнгө эх үүсвэр болон бусад асуудлыг багтаасан байна.

38. Томоохон осол гарч болзошгүй эрсдэлтэй төслийн хувьд зээлдэгч нь холбогдох эрх бүхий байгууллага болоод төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтэд онцгой байдлын нөхцөлд үр дүнтэй хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангахад нь туслалцаа үзүүлж, хамтран ажиллана. Орон нутгийн засаг захиргаа болон хариу арга хэмжээ авах этгээдийн тухайн нөхцөл байдалд үр дүнтэй хариу арга хэмжээ авах чадавх сул буюу ямар ч бололцоогүй тохиолдолд, зээлдэгч нь төсөлтэй холбоотойгоор үүсэж болзошгүй онцгой байдалд авах бэлтгэл ба хариу арга хэмжээг сайжруулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэж, мөн үндэслэлтэйгээр урьдчилан таамаглаж болохуйц үйл явдалд шүүд болон шүүд бусаар хариу үйлдэл үзүүлэх чадавхыг илтгэх хангалттай баримт нотолгоо үзүүлнэ.

Хамгаалалт

39. Зээлдэгч нь ажилтан, ажилчид болон төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтэд тулгарах төслийн хамгаалалтын ажиллагаанаас үүдэлтэй аюулыг тодорхойлж, үнэлнэ. Эрсдэл илэрсэн тохиолдолд тэрхүү эрсдлийг удирдахын тулд ОУСТ-ын дагуу хамгаалалтын ажиллагааны удирдлагын зохицуулалтыг зохих хэмжээнд хэрэгжүүлнэ.

40. Зээлдэгч өөрийн боловсон хүчин болон эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын арга хэмжээг авах үүднээс ажилтан, ажилчин эсвэл гэрээт ажил гүйцэтгэгчдийг авч үлдсэн тохиолдолд төслийн талбайн доторх болон гаднах хүмүүст тэрхүү хамгаалалтын үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг үнэлнэ. Ийм зохицуулалт хийхдээ зээлдэгч нь тэнцвэртэй харьцааг хангах зарчим, ОУСТ-ыг баримтлахын зэрэгцээ тэдгээр боловсон хүчнийг ажилд авах, сахилга батын дүрмийг дагаж мөрдөх, сургалт, тоног төхөөрөмжөөр хангах, ажлын гүйцэтгэлийг нь хянах үнэлэхтэй холбоотой хууль тогтоомжийг удирдлага болгоно. Зээлдэгч аюул заналхийллийн шинж чанар, цар хүрээнээс хамаарч урьдчилан сэргийлэх, хамгаалахаас бусад ямар ч тохиолдолд хүч хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

41. Хэрэв хамгаалалтын үйлчилгээг холбогдох төрийн эрх бүхий байгууллагууд хариуцдаг бол зээлдэгч энэхүү ГШ-д нийцсэн үр дүнд хүрэхийн тулд холбогдох төрийн эрх бүхий байгууллагатай зөвшөөрөгдсөн хэмжээнд хамтран ажиллана. Зээлдэгч ийнхүү хамгаалалтын үйлчилгээг ашигласнаас үүдэн гарч болзошгүй эрсдлийг тодорхойлж, үнэлж, хамгаалалтын ажилтнууд нь дээрх 40-р зүйлд нийцсэн хэлбэрээр ажиллах зорилготой гэдгийг төрийн холбогдох байгууллагад мэдэгдэж, хамгаалалтын асуудалд онцгой анхаарал хандуулахын тулд холбогдох төрийн байгууллагыг зээлдэгчийн байгууламжийн хамгаалалтын арга хэмжээг олон нийтэд ил болгохыг дэмжинэ.

42. Зээлдэгч нь: (i) ажилтан, ажилчид буюу эсвэл хамгаалалтын үйлчилгээ авах зорилгоор хөлсөлсөн гэрээт ажилчид урьд өмнө гарсан хүчирхийлэлд холбогдоогүй гэдгийг шалгах зорилгоор зохих хэмжээний лавлаж судална; (ii) тэднийг хүч (шаардлагатай бол галт зэвсэг) хэрэглэх, мөн ажилтан ажилчид, төслийн нөлөөлөлд өртсөн олон нийттэй зохистой харьцах чиглэлд хангалттай сургана (эсвэл зохих ёсоор сургагдаж бэлтгэгдсэн эсэхийг тодорхойлно); мөн (iii) тэднээс холбогдох хууль тогтоомж, ГШ.2-т заасан болон зээлдэгчийн тодорхойлсон бусад ГШ-д заасан аливаа шаардлагуудын хүрээнд ажиллахыг шаардана.

43. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн олон нийт болон ажилтан, ажилчдын зүгээс хамгаалалтын үйл ажиллагааны зохицуулалт, хамгаалалтын ажилтнуудын үйлдлийн талаар санаа зовж байвал түүнийг илэрхийлэх боломжийг олгох гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгож, тогтмол ажиллагааг нь хангаж, тийнхүү гомдол барагдуулах механизм байгуулагдсан бөгөөд түүнийг энэхүү ГШ болон ГШ.10-ын дагуу ашиглах боломжтой талаар олон нийт, ажилтан, ажилчдад мэдээлнэ.

44. Зээлдэгч нь хамгаалалтын ажилтнуудын хууль бүс, зүй бүс үйлдлийн талаарх аливаа гомдлыг нягтлан шалгаж, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах (эсвэл зохих этгээдээс арга хэмжээ авахыг шаардах), шаардлагатай бол хууль бүс, зүй бүс үйлдлийн талаар төрийн байгууллага болон ЕСБХБ-нд мэдээлнэ.

⁴⁶ Европын Зөвлөлийн 96/82/EC (EU SEVESO III Directive) тоот захирамжийг шинэчилж, улмаар түүний оронд хүчин төгөлдөр болсон, аюултай бодистой холбоотой ослын аюулыг хянах тухай 2012.07.04-ний 2012/18/EU тоот захирамжид тодорхой тайлбарласан.

ЕСБХБ Гүйцэтгэлийн Шаардлага 5: Газар чөлөөлөлт, газар эзэмших, ашиглах эрхийн хязгаарлалт, албадан нүүлгэн суурьшуулалт

Танилцуулга

1. Энэхүү ГШ нь төслийн зориулалтаар газар чөлөөлөх⁴⁷, түүний дотор газар ашиглах⁴⁸ болон өмч хөрөнгө, байгалийн нөөцийг ашиглах боломжийг хязгаарлах, улмаар биетээр (нүүх, амьдарч буй газар болон орон байраа алдах) ба/буюу эдийн засгийн агуулгаар (газар, өмч хөрөнгөө алдах, эсвэл газар, өмч хөрөнгө, байгалийн нөөц ашиглах эрхийг хязгаарласны улмаас орлогын эх үүсвэр болон амьжиргааны бусад арга хэрэгслээ алдах⁴⁹) нүүлгэн шилжүүлсний улмаас үүсэж болох нөлөөллийг авч үзсэн. “Албадан нүүлгэн суурьшуулалт” гэсэн нэр томъёо нь дээр дурдсан нөлөөлөл болон түүнийг бууруулах, нөхөн олговор олгох үйл явцыг хамтад нь илэрхийлж байгаа юм. Хэдийгээр харилцан зөвшилцөх явцад хууль ёсны албадан нүүлгэн шилжүүлэлт нь хамгийн эцсийн арга хэмжээ байхаар тооцсон боловч нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт газар чөлөөлөлт, эсвэл газар, бусад өмч хөрөнгө болон байгалийн нөөцийг ашиглах эрхийн хязгаарлалтаас татгалзах эрхгүйгээс тухайн газраас нүүж буй тохиолдлыг албадан нүүлгэн суурьшуулалт гэж үзнэ.
2. Уг ГШ-ыг хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөө, ялангуяа хувийн өмчтэй байх, зохистой орон байртай⁵⁰ байх эрх болон амьдрах нөхцлөө тасралтгүй сайжруулах эрх зэргийг бүх нийтээр хүндэтгэх, хангах зарчмуудад⁵¹ нийцнэ.
3. Албадан нүүлгэн суурьшуулалтыг зохих ёсоор зохион байгуулахгүй бол энэ нь нөлөөлөлд өртсөн иргэд⁵² олон нийт урт хугацааны зовлон бэрхшээл, ядуурлыг амсах, тэднийг нүүлгэн суурьшуулсан газрын байгаль орчныг доройтуулж, нийгэм, эдийн засагт сөрөг нөлөөлөл үчруулах

эрсдэлтэй. Зээлдэгч нь газар чөлөөлөх эсвэл газар ашиглалт, бусад өмч хөрөнгө болон байгалийн нөөцийг ашиглах, хүртэх эрхийг хязгаарлахаас аль болох зайлсхийх, эсвэл бууруулахын зэрэгцээ байгаль орчин, нийгэм, санхүүгийн зардал, үр ашгийг тэнцвэржүүлэх, мөн жендэрийн нөлөө, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг тусгайлан анхаарсан хэрэгжих боломжтой төслийн загвар, газрын сонголтыг сайтар бодолцох шаардлагатай. Төслийн загварыг боловсруулах үед газар чөлөөлөлтөөс зайлсхийх боломжгүй бол нүүлгэн шилжүүлэлтийг аль болох багасгаж, нөлөөлөлд өртсөн иргэд болон суурьших газрын иргэдэд тохиолдож болох сөрөг нөлөөллийг бууруулах зохистой арга хэмжээг няхуур төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

Зорилт

4. Уг ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - албадан нүүлгэн суурьшуулалтаас аль болох зайлсхийх, хэрэв зайлсхийх боломжгүй бол нийгэм, эдийн засгийн хувьд илүү хэрэгжих боломжтой төслийн загварын хувилбар боловсруулах, хэрэгжүүлэх газрыг сонгох замаар албадан нүүлгэн суурьшуулалтыг багасгах;
 - албадан нүүлгэхээс зайлсхийх⁵³;
 - албадан нүүлгэн суурьшуулалтын улмаас нөлөөлөлд өртсөн хүнд зайлшгүй тохиолдох нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг дараах аргаар бууруулах: (i) алдсан өмч хөрөнгийг бүрэн орлуулах үнээр⁵⁴ тооцож нөхөн олговрыг цаг алдалгүй олгох; ба (ii) газар чөлөөлөх, газар, бусад өмч хөрөнгө болон байгалийн нөөцийг ашиглах эрхийг хязгаарлах, албадан нүүлгэн суурьшуулах арга хэмжээ авахдаа ГШ.10-ын

⁴⁷ “Газар чөлөөлөлт” гэдэг нь төслийн зориулалтаар газрыг шууд худалдан авах, газар, өмч хөрөнгийг албадан хураах, түр болон байнгын нэвтрэх эрхийг олж авах, тухайлбал сервитут, дайран өнгөрөх эрх, тусгай хамгаалалттай болон бусад газар нутагт нэвтрэх эрхийг хязгаарлах зэрэг аргыг ашиглан газартай болохыг хэлнэ. Газар чөлөөлөх гэж: (а) газар эзэмшигч нь ашиг орлого олох, эсвэл амьжиргааны зорилгоор тухайн газраас хараат эсэхээс үл хамааран сүл буюу ашиглагдаагүй байгаа газрыг чөлөөлөх; (б) хувь хүн эсвэл өрхийн амьдарч эсвэл ашиглаж байгаа нийтийн эзэмшлийн газрыг төр эргүүлэн авах; (в) төслийн нөлөөллийн улмаас газар усанд автах эсвэл ашиглах, нэвтрэх боломжгүй болох нөхцлийг хэлнэ. “Газар” гэдэгт газар тариалан, барилга байгууламж, бусад бүтээн байгуулалт, мөн дагалдах усны байгууламж зэрэг газар дээр ургасан, бий болсон, эсвэл түүнээс салгаж үл болох бүх зүйл хамаарна.

⁴⁸ “Газар ашиглах эрхийг хязгаарлах” гэдэг нь хөдөө аж ахуйн, оршин суух, арилжааны эсвэл бусад зориулалтаар газар ашиглахыг хязгаарлах, хориглох тухай төслийн хүрээнд шууд нэвтрүүлж, хүчин төгөлдөр хэрэгжүүлж байгаа зохицуулалтыг хэлнэ. Үүнд: хуулиар тогтоосон цэцэрлэгт хүрээлэн, тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх эрхийг хязгаарлах, нийтийн өмчийн бусад нөөцөд нэвтрэх эрхийг хязгаарлах, инженерийн шугам сүлжээний болон аюулгүйн бусад газар ашиглахыг хязгаарлах зэрэг байж болно.

⁴⁹ “Амьжиргаа” гэдэгт хувь хүн, гэр бүл, олон нийтийн амьдралаа тэтгэх зорилгоор ашигладаг бүх төрлийн арга хэрэгсэл, тухайлбал ажил хөдөлмөр эрхэлсний цалин хөлс, аж ахуй эрхэлснээр эсвэл бараа бүтээгдэхүүн, гар урлалын бүтээгдэхүүн борлуулж, эсвэл үйлчилгээ үзүүлж олсон мөнгөн орлого; газар, барилга байгууламжийн түрээсийн орлого; ургац хураалт, мал аж ахуй эрхэлсний орлого, газар тариалан эсвэл мал аж ахуйн үйлдвэрлэлд хувь нийлүүлсэн орлого (тухайлбал ургац хуваах янз бүрийн тохиролцоо); өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, эсвэл солилцоо бартерт ашигласан бүтээгдэхүүн; өөрийн хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүн; байгалийн эсвэл нийтийн нөөц, баялгаас бий болгосон хувийн эсвэл өрхийн хэрэгцээнд, эсвэл арилжаалахад зориулсан хүнс, материал, түлш, бараа бүтээгдэхүүн; тэтгэвэр болон төрөөс олгодог бүх төрлийн тэтгэмжийг хамруулна.

⁵⁰ “Зохистой орон байр” гэдэг нь хувь хүний нууц орон зайг хамгаалах, орон зайн хувьд хангалттай, биемах бодын хувьд ашиглахад түвэггүй, аюулгүй байдал, эзэмших эрх баталгаатай, бүтцийн хувьд тогтвортой, бат бөх эдэлгээ сайтай, гэрэлтүүлэг, халаалт, агааржуулалт, ус хангамж, ариун цэврийн байгууламж, хог хаягдлын удирдлага зэрэг үндсэн дэд бүтэц бүхий, хүрээлэн буй орчны чанар, эрүүл мэндийн хүчин зүйлсийн хувьд зохистой, ажил болон үндсэн байгууламжид тохирсон, хүрэхэд хялбар байршилд байх тухай ойлголт юм.

⁵¹ Нэр дурдвал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал ба Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон усын пакт.

⁵² “Нөлөөлөлд өртсөн этгээд” гэдэг нь төслийн зориулалтаар газар чөлөөлөх, газар, бусад өмч хөрөнгө эсвэл байгалийн баялаг ашиглах эрхийг хязгаарласны улмаас биетээр эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хуулийн этгээд, эсвэл хувь хүнийг хэлнэ.

⁵³ “Албадан нүүлгэх” нь хувь хүн, бүлэг болон олон нийтийг орон байр ба/буюу тэдний эзэмшиж буй эсвэл хамааралий байгаа газар эсвэл нийтийн өмчийн нөөц баялгаас бүрмөсөн эсвэл түр хугацаагаар албадан нүүлгэн шилжүүлэх үйлдэл эсвэл эс үйлдэхүйг хэлнэ. Дээрх үйлдлийн улмаас энэ ГШ-д тусгасан хууль эрх зүйн ба бусад хамгаалалтын зохих хэлбэр, хүртээмжтэй байдлыг хангаагүйгээс хувь хүн, бүлэг, хамт олны тодорхой орон байр, сүлж, байршилд оршин суух, ажиллах боломжийг үгүй хийх эсвэл хязгаарлах нөхцөл үүсдэг.

⁵⁴ “Орлуулах үнэ” гэдэг нь өмч хөрөнгийг орлуулахад хангалттай нөхөн олговор дээр өмч хөрөнгийг солихтой холбоотой зайлшгүй хэлцлийн зардлыг нэмж өгөх үнэлгээний арга юм. Хэвийн ажиллагаатай зах зээлтэй үед орлуулах үнэ нь хараат бус, чадварлаг, мэргэжлийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээн дээр хэлцлийн зардлыг нэмж тооцсон зах зээлийн үнэлгээ байна. Харин ийм зах зээл байхгүй бол орлуулах үнийг газар эсвэл орлого авчрах хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ, эсвэл бүтцийн барилга ба бусад үндсэн хөрөнгийг барихад шаардагдах орлуулах материал ба хөдөлмөрийн хорогдол тооцоогүй үнэ дээр хэлцлийн өртгийг нэмж тооцох гэх мэт өөр аргаар тодорхойлж болно. Биетээр нүүлгэн шилжүүлсний улмаас орон байраа алдсан бүх тохиолдолд орлуулах үнэ нь хамгийн багадаа чанар, аюулгүй байдлын наад захын шаардлагыг хангасан орон байр худалдан авах эсвэл барихад хангалттай байх ёстой.

шаардлагуудын дагуу бүтээлчээр зөвшилцөж, оролцоог хангаж, мэдээллийг нээлттэй байлгах;

- нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргаа, амьдралын стандартыг нүүлгэн шилжүүлснээс өмнөх түвшинтэй нь харьцуулахад сайжруулах, эсвэл ядаж байсан хэмжээнд нь сэргээх;
- нүүлгэн суурьшуулсан газарт эзэмших эрхийн баталгаатай⁵⁵ орон байр (зайлшгүй хэрэгцээт үйлчилгээ, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэцтэй)-аар хангаснаар биетээр нүүлгэн шилжүүлсэн иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах.

Үйлчлэх хүрээ

5. Тус ГШ-ын үйлчлэх хүрээг ГШ.1-т тодорхойлсон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр тогтооно.
6. ГШ нь дараах үйл ажиллагааны улмаас үүсэх бүрэн эсвэл хэсэгчлэн, бүрмөсөн эсвэл түр хугацаанд, биетээр эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэх үед үйлчилнэ:
 - албадан хураах болон бусад албадлагын журмаар авсан газрын эрх⁵⁶ ба/буюу өмч хөрөнгө;
 - тохиролцоо бүтэлгүйтсэн тохиолдолд албадан хураах буюу бусад албадлагын арга хэмжээг эхлүүлэх боломжтой бол хэлэлцэн тохирсны үндсэн дээр шилжүүлэн авсан газар эзэмших эрх ба/буюу өмч хөрөнгө;
 - тохиролцох, албадан хураах, албадан худалдан авах, эсвэл төрийн зохицуулалтын аргаар хязгаарлах эрх олж авснаас үл хамааран хүмүүс газар, өмч хөрөнгө, байгалийн баялгийг хүртэх боломж, амьжиргаагаа алдахад хүргэсэн хязгаарлалт;
 - хуульд зааснаар газар ашиглах албан ёсны, уламжлалт, хүлээн зөвшөөрсөн эрхгүй ч тасалбар болгох өдрөөс өмнө тухайн газарт оршин сууж байсан, эсвэл ашиглаж байсан иргэдийн нүүлгэлт;
 - газар, өмч хөрөнгийг нь ашиглах эсвэл хүрэх боломжгүй болгосон төслийн нөлөөллөөс үүдэлтэй иргэдийн нүүлгэн шилжүүлэлт.
7. Энэхүү ГШ нь ЕСБХБ оролцохоос өмнө төслийн зорилгоор эзэлдэгч эсвэл засгийн газраас хэрэгжүүлсэн биетээр эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэхэд мөн үйлчилнэ. Банк оролцохоос өмнө нүүлгэн шилжүүлэлт хийсэн тохиолдолд дараах асуудлуудыг тодорхойлох аудит хийнэ. Үүнд: (i) урьд өмнө гүйцэтгэсэн үйл ажиллагаа уг ГШ-д нийцсэн эсэх; (ii) уг ГШ-д нийцүүлэхийн тулд авах шаардлагатай байж болох засаж залруулах арга хэмжээ. Засаж залруулах арга хэмжээний төлөвлөгөө нь энэхүү ГШ-д нийцсэн бүх арга хэмжээг тодорхойлох бөгөөд төсөв, хэрэгжүүлэх зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг хариуцлагын хуваарилалт, хэрэгжүүлэх хуваарийг тусгасан хугацаатай төлөвлөгөө хэлбэртэй байна.

8. Тус ГШ нь дараах тохиолдлуудад үйлчлэхгүй. Үүнд:

- сайн дураар газрын эрхээ шилжүүлэх хэлцлийн (худалдагч нь худалдах үүрэг хүлээгээгүй, албан шахалт, айлган сүрдүүлэгт өртөөгүй, эсвэл авилга аваагүй, харин худалдан авагч нь хэлцэл бүтэлгүйтсэн тохиолдолд албадан хураах эсвэл албадлагын бусад журмыг хэрэглэх боломжгүй гэсэн зах зээлийн хэлцэл хийгдсэн) үр дүнд хийгдсэн нүүлгэн суурьшилт болон энэ төрлийн хэлцэл нь зөвхөн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий этгээдэд хамаатай. Гэхдээ тус ГШ нь тийнхүү сайн дураар газрын эрхээ шилжүүлсэн нь худалдагчаас бусад тухайн газарт оршин суудаг, ашигладаг, эсвэл үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн маргаантай газрыг эзэмших эрхээ нэхэмжилж буй албан ёсны бүс түрээслэгч, эсвэл газар ашиглах хууль ёсны эрхгүй бусад ашиглагч нарыг нүүлгэн шилжүүлэхэд хүргэж болзошгүй тохиолдолд үйлчилнэ;
- дүрвэгсэд, дотооддоо нүүлгэн шилжүүлсэн иргэд, байгалийн гамшиг, зөрчилдөөн, гэмт хэрэг эсвэл хүчирхийллийн хохирогчдыг нүүлгэн суурьшуулах.⁵⁷

Шаардлага

Ерөнхий зүйл

9. Эзэлдэгч нь ГШ.1-т тодорхойлсон байгаль орчин, нийгмийн үнэлгээний эхний шатанд төслийн улмаас биетээр ба/буюу эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсэх эсэхийг тодорхойлж, төсөлд цаашид нэмэлт газар болон бусад нөөцийн хэрэгцээ гарах магадлалыг үнэлнэ.
10. Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл үүсэхээр бол үнэлгээний явцад нүүлгэн шилжүүлэх иргэдийн нийгэм эдийн засгийн суурь нөхцөл байдал болон төслийн зүгээс тэдэнд учруулж болох эрсдэл, нөлөөллийг тодорхойлно. Үнэлгээний цар хүрээ нь нөлөөллийн далайц, магадлал, ноцтой байдлыг тодорхойлж чадахаас гадна нөлөөлөлд өртсөн иргэд болон гол оролцогч талуудын санал бодлыг тусгасан байна.
11. Үнэлгээгээр төслийн зүгээс иргэд ба/буюу олон нийтийг биетээр болон эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотойгоор материаллаг болон бусад нөлөөлөл үзүүлж болохыг тодорхойлсон бол эзэлдэгч нүүлгэн шилжүүлсэн иргэдэд учирсан нөлөөллийг шатлалын арга зарчмын дагуу бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх зорилгоор нүүлгэн суурьшуулалтын төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад туслах нүүлгэн суурьшуулалтын мэргэжилтэн(-үүд)-ийг авч ажиллуулна. Эзэлдэгчийн боловсруулах нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний баримт бичгийн үндсэн чанар, агуулгыг байгаль орчин, нийгмийн үнэлгээний хэсэг болгож Банк тодорхойлно. Нүүлгэн суурьшуулалтын

⁵⁵ “Эзэмших эрхийн баталгаа” гэж нүүлгэн шилжүүлсэн хувь хүн эсвэл иргэд тухайн шилжин суурьшсан газартаа хууль ёсоор оршин суух эрхтэй болсноор албадан нүүлгэн шилжүүлэх эрсдлээс хамгаалагдах, тэдний эзэмших эрх нь нийгэм, соёлын хувьд зохистойгоор олгогдсон байхыг хэлнэ.

⁵⁶ “Газрын эрх” гэж үндэсний хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрсөн бүрэн болон бүрмөсөн өмчлөх эрхийг хэлнэ. Энэ нь бүртгэгдсэн эсвэл зан заншлын дагуу тогтсон; урт болон богино хугацааны түрээс, нийтийн өмчид хамаарах ой, бэлчээр, усны нөөц гэх мэт байгалийн нөөцийг албан эсвэл албан бусаар ашиглах, түрээслэх болон ургац хуваах зэрэг албан болон албан бүс гэрээнээс эсвэл зан заншлын хэм хэмжээнээс үүссэн байнгын эсвэл түр хугацааны үзүфруктын (ашиглалт) эрх; зан заншлын хэм хэмжээ болон хуулиар бий болсон дайран өнгөрөх эрх; мөн хууль эсвэл зан заншлын хэм хэмжээгээр тогтоосон ашиглах, нэвтрэх эрхийн хязгаарлалууд зэргийг багтаасан ойлголт болно.

⁵⁷ Төслийн нүүлгэн шилжүүлэлтээс өмнө зөрчилдөөний улмаас нүүлгэн шилжүүлэх нөхцөл бий болсон тохиолдолд албадан нүүлгэн суурьшуулах үйл явцыг Дотоодын Нүүлгэн Шилжүүлэлтэнд Баримтлах Зарчмууд (Хүний Эрхийн Дээд Комисс)-ын дагуу явуулна.

баримт бичигт биетээр эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэлтээс хэрхэн зайлсхийсэн эсвэл бууруулсныг харуулсан төслийн загварын хувилбар, төслийн талбайд хийсэн дүн шинжилгээ багтана. Төлөвлөгөөний хамрах хүрээ, нарийвчлал нь төслийн мөн чанар, цар хэмжээ, нүүлгэн шилжүүлэлтийн боломжит нөлөөлөл, оролцогч талуудын ашиг сонирхлын түвшинтэй уялдсан байна.

Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх буюу багасгах

12. Зээлдэгч биетээр ба/буюу эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх эсвэл түүнийг хамгийн бага түвшинд байлгах нийгэм, эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой төслийн загвар, төслийн талбайг авч үзнэ. ГШ.1-т тусгасан нөлөөллийг бууруулах шатлалын арга барилын дагуу зайлсхийх нь хамгийн оновчтой арга болно. Ялангуяа нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг иргэдийг биетээр болон эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх нь маш чухал. Гэвч ийнхүү зайлсхийх нь нийгмийн эрүүл мэнд эсвэл аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байвал энэ нь тийм ч оновчтой арга биш байж болох юм. Түүнчлэн дахин суурьшуулах нь айл өрх, олон нийтийг орон байрны болон нийгмийн эрүүл мэндийн нөхцөл сайжрах, оршин суух эрх нь баталгаажих, эсвэл орон нутгийн амьжиргааны түвшин дээшлэх зэрэг хөгжлийн шүүд боломжоор хангах нөхцөл байж болох юм.

Албадан нүүлгэхээс зайлсхийх

13. Зээлдэгч албадан нүүлгэх арга хэмжээ авах ёсгүй. Төрд хамаарах өмчийг эргүүлэн авах, албадан хураах, албадан чөлөөлөх эрхийг зээлдэгчийн зүгээс үндэсний хууль тогтоомжийн шаардлага, энэхүү ГШ-ын заалтуудыг баримтлан зохих үйл явцын үндсэн зарчмуудад (зохих мэдэгдлийг урьдчилан хүргүүлэх, гомдол гаргах, давж заалдах зохистой боломжийг олгох, шаардлагагүй, зүй бус эсвэл хэт их хүч ашиглахаас зайлсхийх) нийцүүлэн авч хэрэгжүүлсэн бол албадан нүүлгэсэн гэж үзэхгүй.

Хэлэлцэн тохирсны үндсэн дээр эрх шилжүүлэх

14. Зээлдэгч нь худалдагчийн зөвшөөрөлгүйгээр тухайн газар руу нэвтрэх хууль зүйн бүрэн боломжтой боловч газрын эрхийг хэлэлцэн тохирсны үндсэн дээр олж авахыг эрмэлзэнэ. Хэлэлцэн тохирсны үндсэн дээр эрхийг шилжүүлэх нь албадан хураахаас зайлсхийх, мөн энэхүү ажиллагааг албажуулахын тулд захиргаанаас болон шүүхээс хамааран цаг алдахыг хамгийн бага түвшинд байлгахад туслахаас гадна албадан хураасны улмаас иргэдэд учрах нөлөөллийг бууруулах боломж олгодог. Нөлөөлөлд өртсөн иргэд, эсвэл олон нийтэд шударга, зохистой нөхөн олговор олгох замаар хэлэлцэн тохирсны үндсэн дээр эрхийг шилжүүлэх боломжтой.

Эмзэг бүлэгт анхаарах

15. Зээлдэгч ГШ.1-ийн дагуу эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, шийдвэрлэх ёстой. Ингэхдээ дараах асуудлуудыг онцгойлон авч үзнэ. Үүнд:
- (i) нийгэм, эдийн засгийн судалгаатай зэрэгцүүлэн төслийн бүс дэх эмзэг байдлын хүчин зүйлсийг тодорхойлох шинжилгээг холбогдох талууд, түүний дотор нөлөөлөлд өртсөн иргэдтэй хамтран хийх;
 - (ii) эмзэг байдлын судалгааны үр дүнд үндэслэн эмзэг бүлгийг тодорхойлох;
 - (iii) эмзэг бүлгийн иргэдтэй тусгайлан зөвшилцөх;
 - (iv) эмзэг бүлгийн иргэдийн өөр өөр хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламжийн арга хэмжээг

төлөвлөх, нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний баримт бичигт тусгах, тэдгээрт шаардагдах санхүүжилтийг газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах нийт төсөвт тусгаж, хэрэгжилтийг хангах.

Жендэрийн асуудлыг тусгах

16. Биетээр эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэх үйл явц нь жендэрийн онцлог хэмжүүртэй учраас түүнийг суурь судалгаа, нөлөөллийг үнэлэх, бууруулах, хяналт шинжилгээ хийх үед зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай. Нүүлгэн суурьшуулахтай холбоотой зөвшилцөх үүлзалтанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог зохистойгоор хангах, тухайлбал үүлзалтыг цагийг оновчтой сонгох, унаа, хүүхэд асрах зэрэг асуудлыг зохицуулах арга хэмжээг тусгах, шаардлагатай бол зөвхөн эмэгтэйчүүдийн дунд үүлзалтыг зохион байгуулах боломжийг тусгасан байна. Төслийн зүгээс газар чөлөөлөх, газар эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах болон албадан нүүлгэн суурьшуулалтын нөлөөлөл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст харилцан адилгүй тусдагийг ойлгох хэрэгтэй. Нөлөөллийн далайцаас хамаарч доорх зүйлсийг багтааж ойлгоно. Үүнд:
- (i) эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн амьжиргааны эх үүсвэр (албан бус үүсвэрийг оролцуулсан)-ийн ялгааг тодорхойлох өрхийн дотоод шинжилгээ хийх;
 - (ii) эмэгтэйчүүдийн газрын эрх, үг эрхээ ашиглаж буй байдал, тэр дундаа нийтийн эзэмшлийн газар болон бусад өмч хөрөнгийг хамтран өмчлөх, ашиглах эрхийг шинжлэн судлах;
 - (iii) нүүлгэн суурьшуулалтын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжид үзүүлж байгаа нөлөөллийг судлах.
17. Нөхөн олговор авах эрх, түүнийг олгох үйл явц дараах жендэрийн асуудлуудыг харгалзсан байна. Үүнд: (i) эмэгтэйчүүдийн бүтээлч үйл болон гэрийн ажил (ii) нөхөн олговрыг бэлнээр олгох шударга хэлбэр (iii) нүүлгэн шилжүүлсэн өмч хөрөнгөөс өмчлөх хувь хэмжээ. Зээлдэгч нөхөн олговрыг олгох олон янзын арга ба/буюу загварыг авч үзэх бөгөөд ялангуяа эмэгтэйчүүд албан ёсны санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх, банкны данс эзэмших боломж хомс улс, бүс нутгийн хувьд онцгойлон анхаарах шаардлагатай. Үндэсний хууль тогтоомж, өмчлөлийн тогтолцоо нь эмэгтэйчүүдийн өмч хөрөнгөтэй байх эсвэл солилцох эрхийг хүлээн зөвшөөрдөггүй тохиолдолд эмэгтэйчүүдийн эзэмших эрхийг аль болох хангах заалтыг тусгана.
18. Зөвшилцөх явц нь нүүлгэн суурьшуулалтын төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн бүх хүрээнд эмэгтэйчүүдийн санаа бодлыг тусгаж, ашиг сонирхлыг нь хангасан байх ёстой. Нөхөн олговор олгох механизмын талаарх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн санал бодол, бэлэн мөнгөөр бус, харин газар эсвэл өмч хөрөнгө болон байгалийн нөөцийг ашиглах боломжоор орлуулж авахыг илүүд үзэх эсэхийг судалж, баримтжуулна.

19. Амьжиргааг дээшлүүлэх буюу дахин сэргээхэд⁵⁸ дэмжлэг үзүүлэх, тухайлбал хөдөө аж ахуйн үйл ажиллагааг сайжруулах, үр чадварын сургалт, зээлд хамрагдах, бизнес эрхлэх, ажил хийх боломжийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд эрэлт хэрэгцээнд нь нийцүүлэн адил тэгш олгоно.

Нийгэм-эдийн засгийн судалгаа

20. Төслийн зүгээс биетээр эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авч болзошгүй нөхцөлд зээлдэгч нөлөөлөлд өртсөн иргэдийн суурь нөхцөл байдлыг тодорхойлох нийгэм-эдийн засгийн судалгаа хийнэ. Судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан ашиглаж, цаашид нөлөөлөлд өртсөн иргэдийн нөхцөл байдалд нийгэм, эдийн засгийн хяналт шинжилгээ хийхэд чиглэсэн байна. Нийгэм-эдийн засгийн суурь судалгаагаар дараах зүйлийг тодорхойлно. Үүнд:

- нөлөөлөлд өртсөн иргэд, хүмүүсийн нийгэм, эдийн засгийн ерөнхий дүр зураг болон нас, хүйсээр нь ангилсан мэдээллийг бүрдүүлэх;
- нөлөөлөлд өртсөн амьжиргааны эх үүсвэр, тэр нь нөлөөлөлд өртсөн иргэдийн нийт амьжиргаанд хэр их ач холбогдолтойг тогтоох;
- нөлөөлөлд өртсөн газар дахь газар эзэмшлийн дэглэмийг тодорхойлох;
- газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах үйл явцад нөлөөлж болзошгүй жендэрийн асуудлыг тогтоох;
- эмзэг байдлын холбогдох хүчин зүйлсийг тодорхойлж, эмзэг бүлгийн иргэдийн жагсаалтыг гаргах.

Тооллого, нөлөөлөлд өртсөн өмч хөрөнгийн жагсаалт болон тасалбар болгох өдөр

21. Зээлдэгч дараах зорилгоор нөлөөлөлд өртсөн иргэдийн тооллого явуулна. Үүнд (i) төслийн зүгээс нөлөөлөлд өртсөн иргэдийг тогтоох; (ii) нөхөн олговор, туслалцаа авах шаардлага хангах иргэдийг тодорхойлох. Тооллого явуулахдаа тооллогын үед төслийн газарт байгаагүй боловч улирлын шинжтэй нөөц ашигладаг иргэдийг оруулан тооцно.
22. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн өмч хөрөнгө, газар, байгууламж, ургац, олон нийтийн тав тухыг хангах тохижилт, байгалийн нөөц зэргийг багтаасан жагсаалтыг⁵⁹ цаашдын үнэлгээний суурийг тогтоох зорилгоор гаргана.
23. Зээлдэгч шалгуурыг хангасан⁶⁰ байх тасалбар болгох өдрийг: (i) холбогдох хуульд заасны дагуу; (ii) тооллогын буюу жагсаалтын хамгийн эцсийн өдөр (энэ хоёрын аль сүүлийнх нь)-ийн аль нэгээр нь тогтооно. Зээлдэгч нөлөөлөлд өртсөн иргэдэд тасалбар болгох өдрийг мэдэгдэнэ. Тасалбар болгох өдрийн тухай мэдээллийг сайтар баримтжуулж, нутгийн хэлээр, төслийн газарт тодорхой давтамжтайгаар бичмэл болон бичмэл бүс хэлбэрээр (аль зохистой байдлаар) түгээнэ. Үүнд тасалбар

болгосон өдрөөс хойш төслийн бүс нутагт суурьшихаар ирсэн хүнийг гаргана гэсэн сэрэмжлүүлэг мэдээ багтана. Зээлдэгч төслийн бүс нутагт тасалбар болгосон өдрөөс хойш дайрч орсон, боломж хайсан суурьшигчдад нөхөн олговор олгох, эсвэл туслалцаа үзүүлэх үүрэггүй.

24. Шаардлагыг хангасан байх тасалбар болгох өдөр дараах тохиолдолд хүчин төгөлдөр байна: (i) үндэсний хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд; эсвэл (ii) тооллого эсвэл жагсаалт гарсан өдрөөс хойш тогтсон хугацаанд. Тасалбар болгосон өдрөөс зээлдэгчийн нөлөөлөлд өртсөн газарт нөхөн олговор олгох өдрийг хүртэл их хугацаа өнгөрөөл тооллого, жагсаалт, түүнээс үүдсэн үнэлгээг шинэчлэх шаардлагатай.

Нөлөөлөлд өртсөн газар болон өмч хөрөнгийн үнэлгээ

25. Үнэлгээ нь бүрэн орлуулах үнээр тооцогдсон байх ба мэргэшсэн үнэлгээчин хийж гүйцэтгэнэ. Орлуулах үнийг тодорхойлох үнэлгээний аргыг баримтжуулж, холбогдох нүүлгэн суурьшуулалтын баримт бичигт тусгасан байна. Нөхөн олговрыг зардлыг бүрэн барагдуулах хэмжээнд тогтоохын тулд инфляци өндөртэй төслийн бүс нутагт, эсвэл нөхөн олговрын хэмжээг тооцсон хугацаа болон бодитоор олгох хугацааны хооронд зөрүү их байгаа тохиолдолд төлөвлөсөн нөхөн олговрын хэмжээг шинэчлэх шаардлага гарч болно.

Эрх үүсэх шалгуурын дагуу ангилах

26. Нөлөөлөлд өртсөн иргэдийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:
- (i) газрын эрх (үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн зан заншлын хэм хэмжээний болон уламжлалт эрх) эсвэл өмч хөрөнгөтэй холбоотой хууль ёсны эрхтэй иргэд;
 - (ii) тооллогын үед газар, эсвэл өмч хөрөнгөтэй холбоотой хууль ёсны эрхгүй боловч үндэсний хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдсөн буюу хүлээн зөвшөөрч болох газар, өмч хөрөнгийг нэхэмжлэх эрхтэй иргэд; эсвэл
 - (iii) оршин сууж, ашиглаж буй газар, эсвэл өмч хөрөнгөтэй холбоотой хууль ёсны эрхгүй, эсвэл нэхэмжлэх эрхгүй иргэд.

Нөлөөлөлд өртсөн иргэдэд олгох нөхөн олговор болон тэтгэмж

27. Газар чөлөөлөх, эсвэл газар, өмч хөрөнгө болон байгалийн нөөцийг ашиглах, нэвтрэх эрхийг хязгаарлахаас зайлсхийх боломжгүй тохиолдолд (бүрмөсөн эсвэл түр хугацаагаар эсэхээс үл хамааран) зээлдэгч энэ ГШ-ын заалтуудын дагуу нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах, эсвэл наад зах нь өмнөхөөс дордуулахгүй байх зорилгоор нөхөн олговрыг⁶¹ бүрэн орлуулах үнээр тооцон олгож, бусад шаардлагатай туслалцааг үзүүлнэ.

⁵⁸ “Амьжиргааг сайжруулах эсвэл дахин сэргээх” гэдэг нь нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргааг сайжруулах, эсвэл наад зах нь нүүлгэн шилжүүлэхээс өмнөх байдалд хүртэл сэргээх зорилготой тусгай тэтгэмж эсвэл үйл ажиллагааг хэлнэ.

⁵⁹ “Жагсаалт” нь нөлөөлөлд өртсөн иргэдийн эдэлж байгаа, эсвэл эдэлж байгаа гэж мэдэгдэж буй бүх эрх, тухайлбал, зан заншил, эсвэл практикт суурилсан эрх, амьжиргааны зорилгоор нэвтрэх, ашиглах зэрэг хоёрдогч эрх, нийтлэг эрхийг багтаасан, зөвшилцөх, шударга, ил тод зарчмаар бэлтгэсэн нарийвчилсан бүртгэлийг багтаасан байна.

⁶⁰ Шилжин нүүсэн хүний тодорхойлолт, тасалбар болгосон өдөр г.м. нөхөн олговор, шилжин суурьшихад зориулсан тусламж авах болзол хангасныг тогтоох шалгуур багтана.

⁶¹ “Нөхөн олговор” нь газар, бусад өмч хөрөнгө, байгалийн нөөцийг ашиглах, эсвэл түүнд нэвтрэх эрхээ төслийн нөлөөллөөр алдсан этгээдэд бэлэн мөнгөөр эсвэл эд материалаар олгох төлбөр юм.

28. Дээр дурдсан шалгуурын ангиллаас үл хамааран зээлдэгч нь биетээр нүүлгэн шилжүүлсэн бүх иргэдэд шилжин суурьшихад зориулсан тусламж⁶², харин эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлсэн иргэдэд амьжиргааг сайжруулах, эсвэл нөхөн сэргээх тусламж үзүүлнэ. Мөн зээлдэгч нь 26-д заасан гурван ангилал тус бүрээр нөхөн олговор олгох дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- | | |
|---------------|--|
| Ангилал (i) | Иргэдийн хууль ёсоор өмчилдөг үл хөдлөх эд хөрөнгө ⁶³ болон бусад өмч хөрөнгийг бүрэн орлуулах үнээр нөхөн олговор (эд материалаар эсвэл бэлэн мөнгөөр) олгох |
| Ангилал (ii) | Нөлөөлөлд өртсөн хүмүүст газар ашиглах, эзэмших эрхийн нэхэмжлэлээ хүлээн зөвшөөрүүлэхэд нь хууль зүйн туслалцаа үзүүлэх, улмаар иргэдэд хууль ёсны үл хөдлөх эд хөрөнгө болон бусад өмч хөрөнгийг бүрэн орлуулах үнээр нөхөн олговор олгох, мөн эрхээ баталгаажуулах явцтай холбоотой зардлыг барагдуулах |
| Ангилал (iii) | Газар дээрх байгууламж, эсвэл бүтээн байгуулалт (үр тариа болон мод), орлогын эх үүсвэр болон амьжиргааны бусад арга хэрэгслээ алдсан нөхцөлд нөхөн олговор олгох. |

29. Газар, үндсэн хөрөнгийн ангилалд олгох нөхөн олговрын стандартыг ил тод болгож, тууштай хэрэгжүүлнэ. Тохиролцох стратеги баримталж байгаа үед нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлж болно. Ямар ч тохиолдолд нөхөн олговор тооцоолох тодорхой үндэслэлийг баримтжүүлж, нөхөн олговрыг ил тод зарчмаар хуваарилан олгоно.
30. Нөхөн олговрыг нүүлгэн шилжүүлэлт хийгдэх, эсвэл газар, өмч хөрөнгөд нэвтрэх эрхийг хязгаарлахаас өмнө олгоно. Эзгүй байгаа өмчлөгчтэй холбоо барихаар хэд хэдэн удаа оролдсон боловч бүтэлгүйтсэн, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд шударгаар тогтоосон нөхөн олговрын саналыг хүлээн авахаас татгалзсан, эсвэл газар, өмч хөрөнгийн өмчлөх эрхийн маргаантай нэхэмжлэлийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа сүнжрах төлөвтэй бол зээлдэгч нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний нөхөн олговрын санхүүжилтийг банкны хүүтэй дансанд байршуулж, хуулийн дагуу төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлж болно. Өмчлөх эрхийн асуудал шийдвэрлэгдмэгц шаардлага хангасан иргэдэд нөхөн олговрыг шууд олгоно.
31. Нүүлгэн шилжүүлсэн иргэдийн амьжиргаа газраас шууд хамааралтай⁶⁴ эсвэл газрыг хамтран эзэмшдэг бол нөлөөлөлд өртсөн иргэд хүлээн авах боломжгүй, эсвэл хэрэгжихгүй гэдэг нь батлагдсанаас бусад тохиолдолд зээлдэгч газарт түшиглэсэн нөхөн олговор олгоно.

32. Алдагдсан газар эсвэл өмч хөрөнгийг мөнгөн бус хэлбэрээр буюу эд материалаар нөхөн олгохын оронд бүрэн орлуулах үнээр нөхөн олговрыг бэлэн мөнгөөр олгох нь дараах тохиолдолд тохиромжтой байж болох юм. Үүнд: (i) амьжиргаа нь газраас хамааралтай бус; (ii) амьжиргаа нь газраас хамааралтай боловч төсөлд авсан газар нь нийт өртсөн хөрөнгийн багахан хэсэг бөгөөд үлдсэн газар нь эдийн засгийн хувьд ашиглах боломжтой; эсвэл (iii) газар, орон сууц болон хөдөлмөрийн идэвхтэй зах зээлтэй, нүүлгэн шилжүүлсэн иргэд тэдгээр зах зээлийг ашигладаг, газар, орон сууцны нийлүүлэлт сайтай байх.
33. Нөлөөлөлд өртсөн иргэд энэ ГШ-ын шаардлагыг хангасан нөхөн олговрын саналаас татгалзсанаас албадан хураах, эсвэл хуулийн бусад процедурыг эхлүүлсэн бол, зээлдэгч уг ГШ-д нийцсэн үр дүнд хүрэхийн тулд, өөрөөр хэлбэл бүрэн орлуулах үнээр нөхөн олговор олгох, шилжин суурьшихад зориулсан тусламж, амьжиргаа сайжруулах, эсвэл нөхөн сэргээх туслалцаа үзүүлэхээр холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх болно.
34. Нутгийн уугуул иргэд нөлөөлөлд өртсөн тохиолдолд зээлдэгч энэ ГШ болон ГШ.7-д тусгасан холбогдох заалтыг хангах шаардлагатай.

Сайн дураар газар хандивлах

35. Зарим тохиолдолд төсөлд ашиглах газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг сайн дурын үндсэн дээр бүрэн нөхөн төлбөр шаардахгүйгээр хандивлахыг санал болгож болно. Банкнаас урьдчилан зөвшөөрөл авах ёстой энэхүү саналыг зээлдэгч дараах шаардлагыг бүрэн хангасан гэдгийг нотлон харуулсан нөхцөлд зөвшөөрөх боломжтой. Үүнд:
- боломжит хандивлагч эсвэл хандивлагчид төслийн тухай болон тэдэнд олгогдож буй сонголтын талаар зохих ёсоор мэдээлэл авсан, зөвлөлдсөн;
 - боломжит хандивлагч эсвэл хандивлагчид өөрийн хүсэлтээ бичгээр батлан илэрхийлсэн;
 - албадлага, айлган сүрдүүлэг, авилгаас ангид;
 - хандивлах газрын хэмжээ нь хандивлагчийн одоогийн амьжиргааны түвшинг дордуулахгүй; газар хандивласнаар амьжиргаанд үлдэгдэл нөлөөлөл үзүүлэхгүй;
 - айл өрхийг шилжүүлэн байршуулаагүй;
 - хандивлагчид нь төслийн үр шимийг шууд хүртэнэ гэж тооцоолсон;
 - олон нийтийн эсвэл хамтын эзэмшлийн газрын хувьд тухайн газрыг ашиглаж, эсвэл оршин сууж буй иргэдийн зөвшөөрлийг авсан тохиолдолд хандивлаж болно;
 - зээлдэгч бүх зөвшилцөл, хүрсэн тохиролцооны тухай мэдээллийн бүртгэлийг ил тод, нээлттэй байдлаар хөтөлж хадгална.

⁶² “Шилжин суурьшихад зориулсан тусламж” нь нөхөн олговроос гадна нүүлгэн шилжүүлсэн иргэдийн шинэ орон байранд төвхнөх, ахуй амьдралаа дахин сэргээх хичээл зүтгэлийг дэмжих техникийн болон санхүүгийн нэмэлт тусламжийг хэлнэ.

⁶³ “Үл хөдлөх эд хөрөнгө” нь газраас салгаж үл болох мод туслах байгууламж зэрэг үндсэн хөрөнгө болон барилга, газар, эсвэл хоёуланг багтаасан ойлголт юм.

⁶⁴ “Амьжиргаа газраас шууд хамааралтай” гэдэг нь газар тариалан, мал аж ахуй эрхлэх болон байгалийн нөөцийг ашиглах, хураах үйл ажиллагааг хэлнэ.

Нийтийн байгууламж, нийтийн аж ахуйн үйлчилгээ, олон нийтийн тав тухыг хангах тохижилт алдагдах

36. Төслийн улмаас нийтийн байгууламж, нийтийн ахуйн үйлчилгээ, олон нийтийн тав тухыг хангах тохижилт алдагдсан эсвэл нэвтрэх боломжгүй болсон бол зээлдэгч нөлөөлөлд өртсөн олон нийт⁶⁵, төрийн холбогдох байгууллагатай зөвшилцож, зохих хувилбарыг тохиролцон сонгосны үндсэн дээр илүү сайн эсвэл ижил түвшний үйлчилгээгээр орлуулах арга хэмжээ авна.

Оролцогч талуудын оролцоо

37. Зээлдэгч нь ГШ.10-т заасан зарчим, үйл явцын дагуу нүүлгэн суурьшилтыг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт, суурьших газрын иргэдтэй⁶⁶ бүтээлчээр зөвлөлдөх бөгөөд ингэхдээ доорх мэдээллийг нийтэд ил болгоно. Үүнд:
- төслийн загварын хувилбаруудыг авч үзэх шатанд холбогдох мэдээллийг ил тод болгох, нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийттэй бүтээлчээр зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулна;
 - нүүлгэн суурьшуулах болон амьжиргааг сайжруулах, эсвэл нөхөн сэргээх арга хэмжээнд нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт сонголт хийх боломж, хувилбаруудыг багтаасан байна;
 - газар чөлөөлөлт болон нүүлгэн суурьшуулалт, үүний дотор амьжиргааг сайжруулах, эсвэл нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээний явцад бүтээлчээр зөвлөлдөх үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай;
 - ГШ.7-гийн дагуу нүүлгэн шилжүүлсэн нутгийн уугуул иргэдтэй зөвлөлдөх арга хэмжээнд нэмэлт шаардлагууд үйлчилнэ;
 - төлөвлөлтийн үе шатанд нөлөөлөлд өртсөн холбогдох бүх бүлэг болон оролцогч талууд, тэр дундаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн иргэдтэй хийсэн зөвлөлдөх үйл явцыг уг ГШ-ийн дагуу нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөнд баримтжуулсан байна;
 - хэрэгжилт ба хяналт үнэлгээний үе шатуудад хийгдсэн зөвлөлдөх үйл явцыг баримтжуулсан байна.
38. Зөвлөлдөх арга хэмжээг боловсруулахад зээлдэгч нь эмзэг бүлгийн иргэд зэрэг бүх бүлгүүд өөрсдийн нөхөн олговор авах эрх, эрх, боломж, үр ашгийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байхад анхаарах ёстой.
39. Зээлдэгч нь зөвлөлдөх болон оролцоог хангах хүчин чармайлтаа нөлөөлөлд өртсөн иргэдэд өргөнөөр түгээх зориулалттай энгийн, хэрэгжиж болохуйц, үнэн зөв, соёлын хувьд зохистой бичиг баримтаар хангах ёстой.

Гомдол барагдуулах механизм

40. Зээлдэгч нь гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг газар чөлөөлөх болон нүүлгэн суурьшуулах үйл явцад аль болох эрт бий болгох ёстой бөгөөд оройтлоо гэхэд тооллого хийгдэхээс өмнө шилжин нүүсэн иргэд (эсвэл бусад иргэд)-ийн зүгээс хөндсөн нөхөн олговор, нүүлгэх эсвэл амьжиргааг сэргээх арга хэмжээтэй холбоотой тодорхой асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэхийн тулд бий болгосон байна. Тус гомдол барагдуулах механизм нь ГШ.10-т багтсан гомдлын менежментийн зорилт ба зарчмуудтай нийцсэн байна. Үүнд маргааныг үнэн шударгаар шийдвэрлэхэд чиглэсэн сөрөг нэхэмжлэлийн механизмыг багтаасан байх ёстой. Гомдол барагдуулах механизмын үр дүн (хүлээн авсан, шийдвэрлэсэн, хүлээгдэж буй гомдлын тоог багтаасан)-г хяналт үнэлгээний тайланд тусгана.

Төлөвлөлт ба хэрэгжилт

41. Байгаль орчин, нийгмийн үнэлгээнд тодорхойлсон эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэхийн тулд зээлдэгч төслийн эрсдэл, нөлөөлөлд дүйцэхүйц нүүлгэн суурьшилтын төлөвлөгөөг дараах байдлаар боловсруулах ёстой:
- (i) бага хэмжээний газар чөлөөлөх эсвэл ашиглах эрхийг багаар хязгаарласнаар амьжиргаанд ноцтой нөлөө үзүүлэхгүй төслийн хувьд тус төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн иргэд нөхөн олговор авах эрх үүсэхэд тавигдах шалгууруудыг тодорхойлж, нөхөн олговрын журам ба стандартыг тогтоож, зөвлөлдөх, хяналт шинжилгээ болон гомдол барагдуулах зохицуулалтыг багтаана;
 - (ii) биетээр нүүлгэн шилжүүлэлт шаардагдах төслүүдийн хувьд тус төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн иргэдийг нүүлгэхтэй холбоотой нэмэлт арга хэмжээнүүдийг тусгана;
 - (iii) амьжиргаа эсвэл орлого олох боломжид ноцтой нөлөөлөл үзүүлэх эдийн засгийн агуулгаарх нүүлгэн шилжүүлэлт шаардагдах төслийн хувьд тус төлөвлөгөө нь амьжиргааг сайжруулах, нөхөн сэргээх нэмэлт арга хэмжээнүүдийг тусгана;
 - (iv) хуулиар тогтоосон хүрээлэн эсвэл тусгай хамгаалалттай газар нутаг, эсвэл орон нутгийн иргэдийн амьжиргаа хамаардаг байж болох нийтийн өмчийн бусад нөөцөд нэвтрэх эрхийг хязгаарлахуйц, газар ашиглалтад өөрчлөлт оруулах магадлалтай төслийн хувьд уг төлөвлөгөөнд газар ашиглалтын зохистой хязгаарлалтыг тодорхойлох оролцоонд суурилсан үйл явцыг бий болгож, тэрхүү хязгаарлалтын улмаас амьжиргаанд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгана.

⁶⁵ “Нөлөөлөлд өртсөн иргэд” гэж ГШ.1-т заасан төслийн нөлөөлөлд өртөж, биетээр эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэлтэд орсон иргэдийг хэлнэ. Нөлөөлөлд өртсөн иргэд гэдэгт суурьших газрын иргэд мөн орно.

⁶⁶ “Суурьших газрын иргэд” гэж төслийн зүгээс биетээр нүүлгэсэн иргэдийг нүүлгэн суурьшуулах газрын эргэн тойронд байгаа, эсвэл тэр газарт байгаа олон нийтийг хэлнэ.

42. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх үед газар чөлөөлөлттэй холбоотой нөлөөллийн шинж чанар ба хэмжээг тодорхойлох боломжтой бол нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөө боловсруулах бөгөөд үг төлөвлөгөөг Банкинд хүргүүлнэ. Энэхүү төлөвлөгөө нь дараах асуудлуудын тухайд сүүлийн үеийн, баталгаат мэдээлэлд үндэслэсэн байх ёстой. Үүнд: i) санал болгож буй төсөл ба төслөөс нүүлгэн шилжүүлсэн иргэд болон бусад ноцтой сөрөг нөлөөлөлд өртсөн бүлгүүдэд үзүүлж болох нөлөөлөл; ii) хохирлын ангилал ба нөлөөлөлд өртсөн иргэдийн бүлэг тус бүрээр нөхөн олговор (бэлэн мөнгөөр эсвэл мөнгөн бус хэлбэрээр) авах эрхийг тодорхойлсон эрхийн матрикс; iii) тогтоогдсон бүх нөлөөллийг бууруулахад чиглэсэн тохиромжтой, хэрэгжих боломжтой арга хэмжээнүүд; iv) нүүлгэн суурьшуулалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн болон институцийн зохицуулалт; v) нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдтэй уялдсан нүүлгэн суурьшуулалтад тусгайлан хуваарилсан төсөв.
43. Тодорхой нөхцөлд болон Банкнаас зөвшөөрөл авах ёстой тохиолдолд хэрэв бүрэн нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөг боловсруулахад төслийн хөгжлийн үе шаттай холбоотойгоор саад болж буй нь тогтоогдсон тодорхой зайлшгүй шалтгаан байвал нүүлгэн суурьшуулалтын ерөнхий хүрээг нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөө боловсруулах чиглэлд хийх эхний алхам гэж хүлээн авч болно. Газар чөлөөлөхтэй холбоотой нөлөөллийн шинж чанар эсвэл цар хэмжээ нь төсөл боловсруулалтын үе шатаас хамааран тодорхойгүй, энэ шалтгааны улмаас нөлөөлөлд өртсөн иргэд ба өмч хөрөнгийн нарийвчилсан тооллого хийх боломжгүй нөхцөлд нүүлгэн суурьшуулалтын ерөнхий хүрээг зээлдэгч боловсруулна. Нүүлгэн суурьшуулалтын ерөнхий хүрээний зорилго нь нүүлгэн суурьшуулалтын зарчмууд болон зохион байгуулалтын зохицуулалтуудыг тодорхой болгох явдал юм. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг нарийвчлан тодорхойлсны дараа болзошгүй эрсдэл, нөлөөлөлд дүйцсэн нүүлгэн суурьшуулалтын нарийвчилсан төлөвлөгөөг нүүлгэн суурьшуулалтын ерөнхий хүрээнд үндэслэн энэхүү ГШ-ын шаардлагуудын дагуу бэлтгэнэ.
44. ГШ.1-ийн дагуу нүүлгэн суурьшуулалтын төлөвлөлтийн баримт бичгүүдийг байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоонд нэгтгэх ёстой. “А” ангиллын төслүүдийн хувьд эдгээр баримт бичгүүдийг ГШ.1-ийн дагуу БОННУ-ний нэг хэсэг болгож мэдүүлэх шаардлагатай зэрэгцээ ГШ.10-т заасан үнэлгээ, оролцооны үйл явц, хугацааны дагуу ил тод болгоно. Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн хэмжээ ноцтой байх тохиолдолд Банкны зүгээс “Б” ангиллын төслүүдийн нүүлгэн суурьшуулалтын төлөвлөлтийн баримт бичгүүдийг олон нийтэд ил болгохыг шаардаж болно. Олон нийтэд ил болгох зориулалттай нүүлгэн суурьшуулалтын төлөвлөлтийн баримт бичгүүдээс хувь хүмүүст холбогдох болон нөхөн олговрын төсвийн нууц мэдээллийг хасна.

Байгууллагын чадавх ба үүрэг амлалт

45. Зээлдэгч нь газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагаанд ГШ.1-ийн холбогдох шаардлагыг дагах ёстой бөгөөд энэхүү ГШ-ын дагуу газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага, эрхийг тодорхойлсон зохион байгуулалтын бүтцийг бий болгож, хөгжүүлж, бэхжүүлэх ёстой. Зээлдэгч нь газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх тодорхой үүрэг хариуцлага, эрх мэдэл бүхий удирдах түвшний төлөөлөл(-үүд) багтсан тодорхой ажилтныг томилно. Зээлдэгч нь

газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах арга хэмжээг үр дүнтэй, тасалдалгүйгээр авч хэрэгжүүлэхэд хангалттай дэмжлэг үзүүлж, хүний нөөц ба санхүүгийн эх үүсвэрээр тогтмол хангана.

Засгийн газрын газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн төслүүд

46. Хэдий тухайн төсөл нь хувийн хэвшлийн хэрэгжүүлэх төсөл боловч газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтанд засгийн газар үүрэг, оролцоотой байж болно. Энэ тохиолдолд зээлдэгч нь: (i) энэхүү ГШ-ыг биелүүлэх арга зам, хэрэгслийг олохын тулд холбогдох засгийн газрын байгууллагыг төсөл боловсруулах үйл явцад эртнээс оролцуулах; (ii) газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээний үйл ажиллагаанд идэвхтэй үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэх; (iii) энэхүү ГШ-ын зорилтуудтай нийцэх үр дүнд хүрэхийн тулд холбогдох засгийн газрын байгууллагатай зөвшөөрөгдөх хэмжээнд хамтран ажиллах. Түүнчлэн засгийн газрын чадавх хязгаарлагдмал тохиолдолд зээлдэгч нь газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтын үйл явцтай холбоотой засгийн газрын хүчин чармайлтыг дэмжин ажиллана.
47. Зээлдэгч нь нэг талаас дотоодын хууль тогтоомж болон засгийн газрын практик, нөгөө талаас энэхүү ГШ-ын заалтуудын (жишээ нь: нөхөн олговрын хэмжээ, албан бус эзэмшигчдийн нөхөн олговор авах шалгуур, эсвэл зөвлөлдөх болон мэдээллийг ил тод болгох тухай) хоорондох зөрүүг тодорхойлох үүрэгтэй. Зөрүүг тодорхойлсны дараа зээлдэгч нь засгийн газар, Банкны зөвшөөрсөн арга зарчмаар зөрүүг арилгах үүрэг хүлээнэ.
48. Зээлдэгч нь энэхүү ГШ-ын шаардлагуудыг хангахын тулд шаардлагатай бол холбогдох засгийн газрын байгууллагын гаргасан баримт бичгүүд дээр нэмэлтээр нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөө эсвэл нүүлгэн суурьшуулалтын ерөнхий хүрээг тодорхойлсон баримт бичиг боловсруулна. Зээлдэгч нь энэхүү төлөвлөгөөнд: (i) холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын дагуу нүүлгэн шилжүүлсэн иргэдийн нөхөн олговор авах эрхийн тодорхойлолт; (ii) тэдгээр эрх болон энэхүү ГШ-ын шаардлагуудын хоорондох зөрүүг арилгах арга санал болгож буй арга хэмжээнүүд; (iii) энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд засгийн газрын байгууллага ба/буюу зээлдэгчийн санхүүгийн болон хэрэгжүүлэлтийн үүрэг, хариуцлагыг тусгана.

Хяналт шинжилгээ ба үнэлгээ

49. Зээлдэгч нь нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх журмыг тогтоох ба хэрэв шаардлагатай бол хэрэгжүүлэлтийн үед энэхүү ГШ-ын зорилтуудыг биелүүлэхийн тулд засаж залруулах арга хэмжээг авах ёстой. Газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах, амьжиргааг сайжруулах, нөхөн сэргээх үйл явцын хяналт шинжилгээг ГШ.1-ийн дагуу гүйцэтгэх ба нөлөөлөлд өртсөн иргэд зэрэг гол оролцогч талуудын оролцоог хангана.

50. Хяналт шинжилгээний үйл ажиллагааны цар хүрээ нь тухайн төслийн эрсдэл, нөлөөлөлтэй дүйцсэн байна. Нүүлгэн шилжүүлэлтийн ноцтой нөлөөлөл бүхий бүх төслүүдийн хувьд зээлдэгч нь нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх болон шаардлагатай бол засаж залруулах арга хэмжээг төлөвлөх, энэхүү ГШ-д нийцүүлэх талаар зөвлөгөө өгөх, дотоод хяналт үнэлгээний тайланг тогтмол гаргах туршлагатай нүүлгэн суурьшуулалтын мэргэжилтнүүдийг ажиллуулна. Хяналт үнэлгээний тайланд нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөнд заасан гүйцэтгэлийн гол шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг харуулах ба ГШ.1-ийн хүрээнд шаардагдах байгаль орчин, нийгмийн хяналт үнэлгээний тогтмол тайлангийн нэг хэсэг болгон Банкинд хүргүүлнэ.
51. Хэдий газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагааг засгийн газар гэх мэт гуравдагч этгээд хэрэгжүүлсэн ч хяналт үнэлгээний тайланг бэлтгэж Банкинд хүргүүлэх үүргийг зээлдэгч хүлээнэ.
52. Зээлдэгч бүх үйл ажиллагаа дуусгавар болсны дараа газар чөлөөлөлт, нүүлгэн суурьшуулалтын хэрэгжилтийн тайланг⁶⁷ Банкинд хүргүүлж батлуулах замаар нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг баталгаажуулна.
53. Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн хэмжээ ноцтой байх тохиолдолд Банк дотоод хяналт үнэлгээнээс гадна доорх хоёр шаардлагын аль нэгийг, эсвэл хоёуланг нь тавина. Үүнд:
- Банктай зөвшилцөн, нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөнд тодорхойлох ажлын удирдамжийн дагуу, түүнд заасан давтамжтайгаар тогтмол хийгдэх хөндлөнгийн нийцлийн үнэлгээ⁶⁸; ба/буюу
 - энэхүү ГШ-ын шаардлагууд ба нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний заалтууд, ялангуяа орон байр, амьжиргааг сайжруулах эсвэл орлуулахтай холбоотой шаардлагууд биелсэн болохыг тодорхойлохын тулд газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагаанд хийлгэх хөндлөнгийн гүйцэтгэлийн аудит⁶⁹. Нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөнд гүйцэтгэлийн аудитын хугацаа, хамрах хүрээ, амжилтыг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой тусгана. Амьжиргааг сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд хэрэгжиж дуусаад, үр дүнг нь хэмжих боломжтой болсны дараа гүйцэтгэлийн аудитыг нүүлгэн суурьшуулалтын туршлагатай мэргэжилтнүүдээр хийлгэнэ. Илэрсэн зөрчил байвал түүнийг засаж залруулах арга хэмжээг гүйцэтгэлийн аудитын тайланд тусгах ба хэрэв шаардлагатай бол засаж залруулах арга хэмжээний төлөвлөгөөг оруулна.
54. Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн хэмжээ ноцтой байх тохиолдолд зээлдэгчид хөндлөнгийн хяналт үнэлгээний тайлангууд (нийцлийн үнэлгээний тайлан ба гүйцэтгэлийн аудитын тайлан)-ыг нийтэд ил болгох шаардлага тавигдаж болно.
- Биет нүүлгэн шилжүүлэлт болон шилжин суурьшихад зориулсан тусламж*
55. Төслийн загварыг боловсруулахад биет нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх аргагүй бол зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн иргэдийн тооноос үл хамааран, наад зах нь энэхүү ГШ-ын холбогдох шаардлагуудыг багтаасан нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөө боловсруулна. Тус төлөвлөгөө нь нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай бол хөгжлийн боломжуудыг тодорхойлоход чиглэсэн байна. Үүнд нүүлгэн суурьшуулах төсөв болон хэрэгжүүлэх хуваарийг багтаахаас гадна нөлөөлөлд өртсөн бүх ангилалд хамаарах иргэд (суурьших газрын иргэд, олон нийт багтана)-ийн эрхийг тусгасан байна. Төлөвлөгөөнд биет нүүлгэн шилжүүлэлт ба амьжиргааг дэмжих арга хэмжээнүүдийн үр дүнг хэрэгжилтийн үед хянах болон хэрэгжилт дууссаны дараа үнэлэх зохицуулалтуудыг оруулна. Жендэрийн асуудал болон эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээнд онцгойлон анхаарал хандуулна. Зээлдэгч нь газрын эрх шилжүүлэн авах, нүүлгэхтэй холбоотой нөхөн олговор болон бусад тусламжийг олгох талаарх бүх хэлцлийг баримтжуулна.
56. Зээлдэгч нь нүүлгэн шилжүүлсэн иргэдэд эзэмших баталгаатай ижил буюу илүү өндөр үнэлгээтэй, ижил эсвэл илүү сайн шинж чанартай, байршлын хувьд давуу талтай орлуулах хөрөнгө олгох, эсвэл орлуулах хөрөнгөөс сонголт хийх боломжгүй, эсвэл хэрэв нөлөөлөлд өртсөн иргэд хүлээн зөвшөөрөөгүй бол бүрэн орлуулах үнэ бүхий нөхөн олговрыг бэлэн мөнгөөр олгох сонголтуудыг санал болгох ёстой. Орлуулах байгууламж (үүнд орон байр багтана) ба/буюу бэлэн мөнгөний нөхөн олговрыг нүүлгэхээс өмнө авах боломжтой байх ёстой. Нүүлгэн шилжүүлсэн иргэдэд зориулсан нүүлгэн суурьшуулалтын суурингууд нь хамгийн наад захын хэрэгцээг хангасан орон байр, ядаж нүүлгэн шилжүүлэлтээс өмнө байсантай тэнцэхүйц амьдрах орчин, үйлчилгээ авах боломжтой байхаас гадна амьжиргааг сайжруулах эсвэл нөхөн сэргээх тогтвортой, зардал багатай боломжуудыг санал болгоно. Шинэ орон байранд нүүж орох болон тохижуулахтай холбоотой зардлыг зээлдэгч хариуцна.
57. Зээлдэгч нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн мөчлөг, хичээл сургалтын хуваарь зэрэгт үзүүлж болзошгүй нөлөөлөл болон бусад хүчин зүйлсийг харгалзан үзэж, зөвлөлдсөний дараа биетээр нүүлгэн шилжүүлэх иргэдэд нүүлгэх цагийг хангалттай хугацааны өмнө мэдэгдэх ёстой.

⁶⁷ “Газар чөлөөлөлт болон нүүлгэн суурьшуулалтын хэрэгжилтийн тайлан” гэж газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах, амьжиргааг нөхөн сэргээх үйл ажиллагаанууд хэрэгжиж дууссаны дараа гарсан тайланг хэлэх ба үүнд: төслийн нөлөөллийн хураангуй (биет болон эдийн засгийн агуулгаарх нүүлгэн шилжүүлэлт), нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний зарчмууд; нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, багасгахад гаргасан хүчин чармайлтын тайлбар; зөвлөлдөх арга хэмжээ, түүний үр дүнгийн хураангуй, үүнд эдгээр арга хэмжээ нь нөхөн олговор авах эрх олгох, газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах болоод амьжиргааг нөхөн сэргээх үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн талаар; нөхөн олговрыг олгох үйл явцын тайлбар; тулгарсан аливаа асуудал болон хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлбар; хүлээн авсан гомдол болон хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлбар, үүнд ирсэн бүх гомдлын болоод тайлан хүргүүлэх үед шүүх дээр байсан хэргийн жагсаалт; газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах болон амьжиргааг нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхэд дайчилсан хөрөнгө, нөөцийн тайлбар.

⁶⁸ “Хөндлөнгийн нийцлийн үнэлгээ” гэдэгт энэхүү ГШ-ын шаардлагууд ба нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний заалтууд хангагдсан эсэхийг тодорхойлохын тулд газар чөлөөлөлт ба нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагаануудад тэдгээрийн төлөвлөлт ба хэрэгжилтийн үед хийх хөндлөнгийн үнэлгээ хамаарна. Аливаа гарсан зөрүү буюу зөрчлийг засаж залруулах зөвлөмжүүд үүнд багтана.

⁶⁹ “Гүйцэтгэлийн аудит” гэдэгт энэхүү ГШ-ын шаардлагууд ба нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөний заалтуудын биелэлт (ялангуяа амьжиргааг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбоотой) -ийг тодорхойлохын тулд нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаанууд хэрэгжсэний дараа газар чөлөөлөх болон нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаанд хийх хөндлөнгийн гүйцэтгэлийн аудит хамаарна.

58. Зээлдэгч нь нүүлгэн суурьшуулалтын үйл явцын нөлөөлөлд өртөж болзошгүй суурьших газрын иргэдэд учирч болох сөрөг нөлөөллийг тодорхойлж, үнэлнэ. Суурьших газрын иргэдтэй зөвшилцсөн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөнд тусгана.
59. Нүүлгэн суурьшуулах суурингуудыг барих, нөлөөлөлд өртсөн барилга байгууламж, орон байр болон бусад бүтцийг сэргээн босгох ажлыг зээлдэгч гүйцэтгэж байгаа бол бүх Гүйцэтгэлийн Шаардлагууд үйлчилнэ.
60. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн иргэдийн бүлэг түс бүрийн хэрэгцээнд тохирсон, шилжин суурьшихад зориулсан тусламжийг үзүүлэх ба ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээнд онцгойлон анхаарал хандуулна.

Эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэх болон амьжиргааг сайжруулах эсвэл нөхөн сэргээх

61. Төсөл нь амьжиргаа эсвэл орлогын эх үүсвэрт нөлөө үзүүлэхээр бол зээлдэгч нөлөөлөлд өртсөн иргэдийн орлого, амьжиргааг сайжруулах эсвэл наад зах нь нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөх шаардлагатай. Уг төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн иргэд ба/буюу олон нийтийн эрхийг тогтоож, жендэрийн асуудал болон эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээнд онцгойлон анхаарал хандуулж, тэрхүү хэрэгцээг ил тод, түүштай, шударга байдлаар хангахад анхаарна. Төлөвлөгөөнд амьжиргааг дэмжих арга хэмжээний үр дүнг хэрэгжилтийн үед хянах, хэрэгжилт дууссаны дараа үнэлэх зохицуулалтуудыг оруулна. Гүйцэтгэлийн аудитаар нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт эрх нь үүссэн бүх тусламжийг авсан, амьжиргаагаа нөхөн сэргээх хангалттай боломжоор хангагдсан гэж дүгнэвэл эдийн засгийн агуулгаарх нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөлөл буурсан гэж үзнэ.
62. Газар чөлөөлөх эсвэл газар ашиглах хязгаарлалтын улмаас орлого болон амьжиргаанд үүссэн шууд бус үр дагавар, нөлөөллийг ГШ.1-ийн шаардлагуудын дагуу БОННУ-ний үйл явцын нэг хэсэг болгож тодорхойлно. Ийм нөлөөлөлтэй холбоотой нөхөн олговор болон амьжиргааг нөхөн сэргээх арга хэмжээг энэхүү ГШ-ын зарчмуудын дагуу хэрэгжүүлнэ.
63. Нөлөөллийн төрлөөс хамаарч амьжиргааг сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлс багтана. Үүнд:
- газар чөлөөлөлт, газар ашиглалтын хязгаарлалт нь бизнесүүдэд нөлөөлсөн⁷⁰ бол өртсөн бизнесийн эзэд эсвэл бизнес эрхлэгчдэд олгох нөхөн төлбөрт: (i) өөр

газар үйл ажиллагаагаа сэргээн явуулах зардал; (ii) шилжилтийн үед⁷¹ алдагдсан цэвэр орлого; (iii) үйлдвэр, машин, тоног төхөөрөмжийг шилжүүлэх, дахин суурилуулах зардал багтана;

- үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн буюу хүлээн зөвшөөрөгдөх газар эзэмших хууль ёсны эрхтэй иргэд төслийн нөлөөлөлд өртсөн тохиолдолд орлуулах газар эсвэл ижил юм уу илүү үнэлгээтэй хөрөнгө, эсвэл хэрэв боломжтой бол бүрэн орлуулах үнээр тооцсон нөхөн олговрыг бэлэн мөнгөөр олгоно;
- эдийн засгийн агуулгаарх нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн, хууль ёсоор газар эзэмшдэггүй иргэдэд газраас бусад алдагдсан хөрөнгө (жишээ нь: үр тариа, усжуулалтын дэд бүтэц болон газарт хийгдсэн бусад сайжруулалт)-ийн орлуулах өртгийг нөхөн олгоно. Түүнчлэн зээлдэгч тэдгээр иргэдэд газрын нөхөн төлбөрийн оронд амьжиргаагаа өөр газар дахин бий болгох хангалттай боломжийг олгох туслалцаа үзүүлнэ;
- нийтээр ашигладаг байгалийн нөөц нөлөөлөлд өртсөн тохиолдолд олон нийтийн ашиглах боломжтой үлдсэн нөөцийн бүтээмжийг нэмэгдүүлэх санаачлага, алдагдсан нөөцийн өөр эх үүсвэрийг ашиглах боломжгүй болсны төлөө мөнгөн ба мөнгөн бус нөхөн төлбөр олгоно;
- иргэдийн орлого олох чадавх, үйлдвэрлэлийн түвшин ба амьдралын түвшинг дор хаяж нөхөн сэргээх, боломжтой бол сайжруулах зорилтот нэмэлт туслалцаа үзүүлэх болон боломжоор хангах. Төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэлтийн улмаас түр алдагдал хүлээж буй эсвэл хаагдахдаа тулсан бизнесүүдийн хувьд тухайн бизнесийн эзэн болоод цалин, ажлын байраа алдаж буй ажилтнуудын аль аль нь энэхүү туслалцааг авах эрхтэй;
- эдийн засгийн агуулгаарх нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдэд шилжилтийн үед шаардлагатай бол дэмжлэг үзүүлэх, ингэхдээ тэдний орлого олох чадавх, үйлдвэрлэлийн түвшин болон амьдралын түвшинг сэргээхэд шаардагдах цаг хугацааг бодитой тооцоолсны үндсэн дээр зохицуулах;
- нүүлгэн шилжүүлсэн иргэд, олон нийтэд төслөөс бий болох зохих үр ашгаас хүртэх боломж олгох.

⁷⁰ “Бизнесүүд” гэдэгт дэлгүүр, зоогийн газар, үйлчилгээ, үйлдвэрлэлийн болон бусад аж ахуйн нэгжүүд багтах бөгөөд хэмжээ, түсгэй зөвшөөрөлтэй эсжээс үл хамаарна.

⁷¹ “Шилжилтийн үе” гэдэгт нүүлгэн шилжүүлэлт явагдснаас нөлөөлөлд өртсөн амьжиргааг сэргээх хүртэл хоорондох хугацаа хамаарна.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6: Биологийн олон янз байдлын хадгалалт, байгалийн амьд нөөцийн тогтвортой удирдлага

Танилцуулга

1. Энэхүү ГШ-д биологийн олон янз байдлыг⁷² хадгалах, байгалийн амьд нөөцийг⁷³ тогтвортой удирдах нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын үндэс суурь болохыг онцлон авч үзлээ.
2. Уг ГШ нь амьдрах орчин⁷⁴, биологийн олон янз байдал, экотогтолцооны үйлчилгээний⁷⁵ экологийн үндсэн үүрэг чиглэлийг хадгалахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. Бүх экотогтолцоо нь амьд организмын нарийн төвөгтэй байдлыг тэтгэн тэжээх ба төрөл зүйлийн баялаг шинж, элбэг дэлбэг байдал, ач холбогдол нь харилцан адилгүй.
3. Биологийн олон янз байдлыг хадгалах, амьд нөөцийг тогтвортой захиран зарцуулах зорилго нь биологийн олон янз байдал ба байгалийн амьд нөөцийн эдийн засгийн, нийгмийн болон соёлын олон талын үнэ цэнийг хамгийн оновчтой байдлаар ашиглах боломжтой үялдсан, тэнцвэртэй байх ёстой.

Зорилт

4. Энэхүү ГШ-ын зорилго нь:
 - урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах замаар биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах;
 - биологийн олон янз байдалд цэвэр алдагдалд оруулахгүй байх, аль болох цэвэр эерэг нөлөө авчрах зорилгоор төслийн загвар төлөвлөлт болон хэрэгжилтийн явцад нөлөөллийг бууруулах шатлалын арга барилыг нэвтрүүлэх;
 - экотогтолцооны үйлчилгээг тогтмолжуулах; болон
 - байгалийн амьд нөөцийг тогтвортой удирдах болон ашиглах чиглэлд ОУСТ-ыг хөхиүлэн дэмжих.

Үйлчлэх хүрээ

5. Энэхүү ГШ нь Байгаль орчин, нийгмийн бодлогод заасанчлан ЕСБХБ-ны санхүүжүүлсэн бүхий л төсөлд үйлчилнэ. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээнийхээ хүрээнд уг ГШ-ын холбогдох шаардлагуудыг тодорхойлж, тэдгээрийг төслийн хэрэгжилтийн хугацаанд хэрхэн тусгаж, биелүүлэх талаар авч үзнэ. Уг ГШ-д багтсан шаардлагуудыг хангахад шаардагдах арга хэмжээг авахдаа зээлдэгч төслийг энэхүү ГШ-ыг тогтсон хугацаанд багтаан хангахад зохион байгуулахын тулд ерөнхий Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо (БОНУТО) ба төслийн онцлогт тохируулан боловсруулсан Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНУТө)-ний дагуу зохицуулна. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон удирдлагын шаардлагыг ГШ.1-т тусгав.

6. Тус ГШ нь төслийн нөлөөлөлд өртсөн олон нийт, түүний дотор уугуул иргэдийн биологийн олон янз байдал, экотогтолцооны үйлчилгээ ба/буюу байгалийн амьд нөөцийг ашиглах боломж нь төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр алдагдаж, улмаар амьжиргаанд нь сөргөөр нөлөөлж болох нөхцөлд үйлчилнэ. Нөлөөлөлд өртсөн олон нийт, уугуул иргэдийн биологийн олон янз байдлыг хадгалах, амьд нөөцийг тогтвортой удирдахад гүйцэтгэх боломжтой эерэг үүрэг оролцоог мөн энэхүү ГШ-д авч үзсэн болно.

Шаардлага

Биологийн олон янз байдлын хадгалалт

Эрсдэл, нөлөөллийн үнэлгээ

7. Үнэлгээг гүйцэтгэх явцад төслийн суурь нөхцөл байдлыг үүсэж болзошгүй эрсдэл, нөлөөллийн цар хэмжээнд нийцэн уялдах байдлаар тодорхойлно. Суурь судалгаагаар амьдрах орчны болзошгүй алдагдал, доройтол, хуваагдал, харь амьтан, шавжийн түрэмгийлэл, нөөцийн хэт их ашиглалт, амьтдын нүүдлийн зам, гидрологийн өөрчлөлт, экотогтолцооны тэжээгдэл, бохирдол, мөн уур амьсгалын өөрчлөлт болон дасан зохицохтой холбоотой нөлөөлөл зэрэг биологийн олон янз байдал ба экотогтолцооны үйлчилгээнд тулгарах эрсдэлүүдийг авч үзнэ. Биологийн олон янз байдлын суурь судалгаа, нөлөөллийн үнэлгээг төлөвлөх, гүйцэтгэхдээ зээлдэгч холбогдох сайн түршлагын зааврыг баримталж, суурин болоод хээрийн судалгааны аргуудыг ашиглаж, мэргэжилтнүүдтэй зөвшилцөнө. Төслөөс үүсэж болзошгүй нөлөөллийн цар хүрээг илүү тодорхой болгох зорилгоор нэмэлт судалгаа хийх шаардлагатай тохиолдолд зээлдэгч нь төслийн холбогдолтой залруулах боломжгүй сөрөг нөлөөлөл учруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн өмнө нэмэлт судалгаа ба/буюу хяналт үнэлгээ хийнэ.
8. Үнэлгээгээр дамжуулан зээлдэгч нь төслийн хэрэгжилтийн эхэн үеэс төслөөс биологийн олон янз байдалд үзүүлж болох эрсдэл, нөлөөлөл, боломжийг тодорхойлон дүгнэнэ. Үнэлгээгээр нөлөөллийн үүсэх магадлал, эрчим, хамрах хүрээнд үндэслэн нөлөөллийг тодорхойлж, түүнд өртсөн байж болзошгүй олон нийт, шаардлагатай бол бусад талуудын санал бодлыг тусгасан байхад хангалттай. Мөн үнэлгээ нь шууд, шууд бус болон хуримтлагдах нөлөөллийг авч үзнэ, төслийн хүрээнд авах нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүн, хэрэгжих үндэслэлд үнэлэлт дүгнэлт өгнө. Үнэлгээгээр газар нутгийн түвшинд үүсэж болзошгүй нөлөөлөл, улирлын хязгаарлалт ба/буюу эмзэг байдал, түүнчлэн эдгээр экотогтолцооны экологийн цогц байдалд үзүүлэх нөлөөллийг тухайн газар нь тусгай хамгаалалттай эсэх, мөн эвдрэл, доройтлын зэргээс нь үл хамааран авч үзэх болно.

⁷² Тус ГШ-д биологийн олон янз байдал гэж Биологийн олон янз байдлын тухай конвенцод «хуурай газар, далай тэнгисийн болон бусад усны экотогтолцоо, экологийн цогцолбор, өөр бусад бүхий л эх үүсвэрийн амьд организмын төрлүүд ба энэхүү ойлголт нь зүйлийн хүрэн дэх төрөл зүйлүүд ба экотогтолцооны хоорондын төрөл зүйлийг өөртөө агуулна» хэмээн тодорхойлсныг хэлнэ.

⁷³ «Байгалийн амьд нөөц» гэж «зэрлэгээр болон гаршуулсан байдлаар хүний болоод амьтны хэрэглээнд зориулан үржүүлсэн ургамал, амьтан. Үүнд, ой мод, био түлш, нэг наст болоод олон наст ургамал, мал аж ахуй зэрэг хөдөө аж ахуйн холбогдолтой бүхий л төрөл зүйл; байгалийн болоод үржүүлгийн загас, түүний дотор далай, цэвэр усны сээр нуруут, сээр нуруугүй амьтад орно.

⁷⁴ Амьдрах орчин гэж хуурай газар, ус, эсвэл далай тэнгисийн хэсэг, эсвэл амьд организмын идээшин амьдрах агаарын орчин, тэдний амьгүй орчинтой зохицон амьдрах нөхцлийг хэлнэ.

⁷⁵ Экотогтолцооны үйлчилгээ гэдэг нь хүмүүс, тэр дундаа бизнесүүдийн экотогтолцооноос хүртдэг ашиг тус юм. Экотогтолцооны үйлчилгээг дөрвөн төрөлд хуваадаг. Үүнд: (i) хүмүүсийн экотогтолцооноос хүртэх бүтээгдэхүүн болох хангах үйлчилгээ; (ii) хүмүүсийн экотогтолцооны үйл явцын зохицуулалтаас хүртэх үр өгөөж болох зохицуулах үйлчилгээ; (iii) хүмүүсийн экотогтолцооноос хүртэх материаллаг бус ашиг тус болох соёлын үйлчилгээ; (iv) бусад үйлчилгээг хадгалж байдаг байгалийн үйл явц болох туслах үйлчилгээ орно.

9. ОУСТ-ын дагуу үнэлгээнд дараах асуудлуудыг авч үзнэ. Үүнд: (i) төслөөс экотогтолцооны үйлчилгээнд үзүүлж болзошгүй, уур амьсгалын гэх мэт өөрчлөлтийн улмаас хурцдаж болох нөлөөлөл; (ii) нөлөөлөлд өртсөн байж болзошгүй олон нийт ба/буюу уугуул иргэдийн экотогтолцооны үйлчилгээ ашиглалт, түүнээс хараат байдал; мөн (iii) төслийн экотогтолцооны үйлчилгээнээс хамаарах байдал. Төсөл экотогтолцооны үйлчилгээнд нөлөөтэй болох нь тогтоогдвол, эсвэл зээлдэгч шууд удирдан хянадаг буюу ихээхэн нөлөөтэй бол, сөрөг нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ авах шаардлагатай. Хэрэв зайлсхийх боломжгүй бол багасгах ба/буюу биологийн олон янз байдал, экотогтолцооны үйлчилгээг нөхөн сэргээх арга хэмжээ авна.
10. Нутгийн уугуул иргэд, орон нутгийн олон нийтэд сөрөг нөлөөтэй байж болзошгүй төслүүдийн хувьд зээлдэгч нь байгалийн амьд нөөцийг ашигласнаас гарах үр шимийг шударга, эрх тэгш хүртэх боломжийг олгоно. Ингэхдээ: (i) ГШ.5-д заасан эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийг шийдвэрлэх тухай шаардлага; (ii) ГШ.7-д заасан нутгийн уугуул иргэдэд учруулах эрсдэл, нөлөөллийг зохицуулах тухай онцгой шаардлага; болон (iii) ГШ.10-т заасан талуудыг оролцуулах шаардлагыг хангасан байвал зохино.

Биологийн олон янз байдлын хадгалалт, хамгаалалт
Биологийн тэргүүлэх чухал төрөл зүйл болон аюулд өртсөн амьдрах орчин

11. Үнэлгээгээр төслийн зүгээс биологийн олон янз байдалд нөлөөлөл үзүүлэх нь тогтоогдвол, зээлдэгч нөлөөллийг бууруулах шатлалын арга барил болон ОУСТ-д тулгуурлан эрсдлийг зохицуулна. Зээлдэгч урьдчилан сэргийлэх аргыг ашиглаж, төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд авч буй нөлөөллийг бууруулах ба зохицуулах арга хэмжээ нь өөрчлөгдөж буй нөхцөл байдал, төслийн хяналт шинжилгээний үр дүнд тохирсон байх дасан зохицох удирдлагын арга туршлагыг нэвтрүүлнэ.
12. Дээр зааснаас үл хамааран, төслийн нөлөөлөлд өртсөн зарим нутаг дэвсгэрт «биологийн чухал төрөл зүйл»⁷⁶ оршдог байж болох ба үүнд: (i) аюулд өртсөн амьдрах орчин; (ii) эмзэг төрөл зүйл; (iii) өргөн хүрээний оролцогч талууд, эсвэл Засгийн газраас тогтоосон биологийн чухал төрөл зүйлүүд; мөн (iv) энэ хэсэгт тодорхойлсон биологийн тэргүүлэх чухал төрөл зүйлийг хадгалахад шаардлагатай экотогтолцооны бүтэц, үйл ажиллагааг тус тус багтаана.
13. Үнэлгээгээр төсөл нь биологийн тэргүүлэх чухал төрөл зүйлд томоохон хэмжээний, сөрөг бөгөөд бууруулах боломжгүй нөлөөлөл үзүүлэх нь тогтоогдвол, зээлдэгч доор дурдсан нөхцөл байдлаас бусад тохиолдолд төслийн холбогдолтой аливаа үйл ажиллагаа явуулахгүй. Үүнд:

- бүс нутгийн хэмжээнд биологийн олон янз байдлын үнэ цэн багатай амьдрах орчинд төслийг боловсруулах өөр боломжит хувилбар байхгүй;
- ГШ.10-ын дагуу оролцогч талуудтай зөвшилцсөн;
- биологийн чухал төрөл зүйлүүдийг хүлээн зөвшөөрч, холбогдох байгаль орчны хууль тогтоомжийн дагуу тухайн төслийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгосон; мөн
- биологийн чухал төрөл зүйлүүд болон тэдгээрийг урт хугацаанд хадгалалт хамгаалалтын хэмжигдэхүйц үр дүнд хүрэхэд нь дэмжлэг болдог амьдрах орчин, экологийн үйл ажиллагааг цэвэр алдагдалд⁷⁷ оруулахгүй, аль болох үр ашигтай байлгах нөхцлийг хангах зорилгоор нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээг нөлөөллийг бууруулах шатлалын арга барилын дагуу хэрэгжүүлсэн.

14. Биологийн олон янз байдлын хамгийн эмзэг төрөл зүйлийг чухал амьдрах орчин гэж тодорхойлсон бөгөөд үүнд дараах зүйлсийг авч үзнэ: (i) дээд зэргээр аюулд өртсөн буюу өвөрмөц экотогтолцоо; (ii) устаж болзошгүй⁷⁸, эсвэл устаж байгаа төрөл зүйлийн хувьд нэн чухал амьдрах орчин; (iii) зөвхөн тодорхой нутаг дэвсгэрт нутагладаг, эсвэл газар зүйн хувьд хязгаарлагдмал төрөл зүйлд нэн чухал амьдрах орчин; (iv) дэлхий дахинд ач холбогдол бүхий нүүдлийн, эсвэл сүрэлэн амьдардаг төрөл зүйлд нэн чухал амьдрах орчин; болон (v) эволюцийн гол үйл явцтай холбоотой нутаг орно.

15. Устах аюулд буй төрөл зүйлийг экологийн бүрэн бүтэн байдал, биологийн төрөл зүйлийн үнэ цэнийг алдагдуулах хэмжээнд хүртэл хуваах, хувиргах, доройтуулахыг хориглоно. Тиймээс устах аюулд өртсөн төрөл зүйлийн хувьд чухал амьдрах орчинд дараах нөхцлийг хангаагүй бол зээлдэгч төслийн үйл ажиллагаа явуулахгүй. Үүнд:

- бүс нутагт биологийн олон янз байдлын хувьд ач холбогдол арай багатай амьдрах орчинд төсөл хэрэгжүүлж болох өөр боломжит хувилбар байхгүй;
- ГШ.10-ын дагуу оролцогч талуудтай зөвшилцсөн;
- биологийн чухал төрөл зүйлүүдийг хүлээн зөвшөөрч, холбогдох байгаль орчны хууль тогтоомжийн дагуу тухайн төслийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн;
- энэ шаардлагын 14-т зааснаар чухал амьдрах орчныг багтаасан байгальд устах аюулд өртсөн гэх ангилалд хамаарах биологийн төрөл зүйлд хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл⁷⁹ үзүүлэхгүй;

⁷⁶ Биологийн чухал төрөл зүйл гэдэг нь биологийн олон янз байдлын нэг хэсэг бөгөөд эмзэг хэдий ч устаж буй ангиллаас доогуур ангилалд багтах (14-р заалтад тодорхойлсон) төрөл зүйл юм.

⁷⁷ “Цэвэр алдагдалгүй” гэдэг нь эдгээр нөлөөллөөс зайлсхийх, багасгах, газар дээр нь нөхөн сэргээх, эцэст нь газарзүйн зохих масштаб дээр томоохон үлдэгдэл нөлөөлөл бий болсон бол түүнийг нөхөх зорилгоор авсан арга хэмжээний үр дүнд бий болсон орлогоор төсөлтэй холбоотой биологийн олон янз байдлын алдагдлыг тэнцвэржүүлэх цэгийг хэлнэ.

⁷⁸ Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN)-ны Ховордсон төрөл зүйлийн Улаан дансанд жагсаасан төрөл зүйлүүд орно. Устаж байгаа төрөл зүйлүүдийг (i) IUCN-ны аргачлалыг ашигладаг улс орнуудад, үндэсний, бүс нутгийн хэмжээнд устаж байгаа эсвэл устаж болзошгүй хэмээн тодорхойлогдсон төрөл зүйлийн хувьд холбогдох туршлага бүхий мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр төсөл тус бүрээр тодорхойлно, (ii) хэрэв тухайн улсын ашигладаг ангилал IUCN-ны ангилалтай тохирохгүй байх тохиолдолд (зарим улс орнуудад “хамгаалагдсан”, эсвэл “хязгаарлагдсан” зэрэг ерөнхий ангиллыг ашиглах нь бий) тухайн ангиллыг ямар үндэслэлээр гаргасан болохыг үнэлж тодорхойлно. Энэ тохиолдолд үг үнэлгээнд үндэслэн устаж байгаа төрөл зүйлийг тодорхойлно.

⁷⁹ Хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл гэдэг нь төслийн шууд болон шууд бус нөлөөлөл нь чухал амьдрах орчны тодорхойлолтын эхлэлийг тавигч аливаа биологийн олон янз байдлын үнэ цэнийг судлах талбарын тууштай байдалдааюул учруулна гэсэн үг юм.

- төслийг түүний нөлөөлөлд автсан, аюулд өртсөн амьдрах орчинд цэвэр үр шим⁸⁰ өгөхүйцээр төлөвлөн боловсруулсан;
 - төсөл нь тодорхой хугацааны туршид⁸¹ тухайн төслийн үр дүнд устаж болзошгүй болон устаж байгаа төрөл зүйлийн тоо толгойн цэвэр хорогдолд⁸² хүргэх зорилго агуулаагүй; мөн
 - аюулд өртсөн амьдрах орчин, биологийн төрөл зүйлийн нөхцөл байдлыг үнэлэх зорилготой биологийн олон янз байдлын хяналт шинжилгээ, үнэлгээний хүчтэй бөгөөд тохирсон загвартай урт хугацаат хөтөлбөрийг зээлдэгчийн хэрэгжүүлэх дасан зохицох удирдлагын хөтөлбөрт суулгаж өгсөн.
16. Зээлдэгч эдгээр шаардлагыг хангаж чадах тохиолдолд төслийн нөлөөллийг бууруулах стратегийг Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө, эсвэл Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөнд⁸³ зохих байдлаар тусгана.
17. Төслийн нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээг тодорхойлох үе шатанд чухал амьдрах орчны үнэлгээний шаардлагыг тогтоох ба шаардлагатай бол түүнийг суурь судалгааны төгсгөлд өөрчилж шинэчилнэ. Үнэлгээгээр төслийн үйл ажиллагаа нь чухал амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтойг тогтоосон бол зээлдэгч чухал амьдрах орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг хөндлөнгийн шинжээчдээр хийлгэнэ.
18. Биологийн олон янз байдлыг цэвэр алдагдалд оруулахгүй, аль болох үр ашиг өгнө гэж тооцоолж буй хэмжигдэхүйц, нэмэлт бөгөөд урт хугацааны байгаль хамгааллын үр дүнд⁸⁴ хүрэхэд эцсийн арга хэрэгсэл болгон биологийн олон янз байдлын нөхөн олговрыг төлөвлөн хэрэгжүүлж болно. Биологийн олон янз байдлын нөхөн олговрыг төлөвлөхдөө “ижил буюу илүү давуу байх” зарчмыг⁸⁵ баримталж, Банкны ГШ болон ОУСТ-тай үялдуулан хэрэгжүүлнэ. Зээлдэгч нь зохих боловсон хүчний нөөцийг дайчилж, нөхөн олговор олгох урт хугацааны техникийн ба санхүүгийн боломжтой гэдгээ харуулах шаардлагатай.
19. Биологийн чухал төрөл зүйл болон устах аюултай амьдрах орчинд зориулсан биологийн олон янз байдлын нөхөн олговрыг санал болгож буй тохиолдолд зээлдэгч төслөөс биологийн олон янз байдалд үзүүлэх их хэмжээний үлдэгдэл нөлөөлөл зохих ёсоор буурна гэдгийг батлан харуулах биологийн олон янз байдлын нөхөн олговрын стратеги буюу биологийн олон янз байдлын нөхөн олговрын удирдлагын төлөвлөгөө боловсруулна. Энэ тохиолдолд зээлдэгч биологийн олон янз байдлын нөхөн олговрын зураг төсөл ба хэрэгжилтийн талаар мэдлэг туршлагатай хөндлөнгийн мэргэжилтнүүдийг ажиллуулна.
20. Биологийн чухал төрөл зүйлүүд ба/буюу чухал амьдрах орчны бүх үлдэгдэл сөрөг нөлөөлөлд нөхөн олговор олгох боломжгүй. Ийм тохиолдолд зээлдэгч тэр мэт нөхөн олговроос зайлсхийх болон энэхүү ГШ-ын заалтуудыг хангах үүднээс төслөө дахин боловсруулах хэрэгтэй.

Хуулиар хамгаалагдсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн биологийн олон янз байдлын үнэ цэн бүхий газар нутаг

21. Хуулиар хамгаалагдсан⁸⁶ ба/буюу олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн⁸⁷, эсвэл тухайн улс орны Засгийн газраас хамгаалахаар санал болгосон газар нутагт үйл ажиллагаа явуулах, эсвэл тийм газарт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төсөл хэрэгжүүлэх тохиолдолд зээлдэгч төслийн холбогдолтой нөлөөллийг тодорхойлон үнэлж, тус газар нутгийн бүрэн бүтэн байдал, хамгаалах зорилго ба/буюу биологийн олон янз байдлын ач холбогдлыг алдагдуулахгүйгээр нөлөөллийг шат дараатай бууруулна.
22. Хэрэв үнэлгээгээр тухайн төсөл нь хуулиар хамгаалагдсан, эсвэл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, биологийн олон янз байдлын үнэ цэн бүхий газар нутгийн биологийн чухал ба/буюу устаж байгаа төрөл зүйл, хамгаалж буй зорилго болон тухайн газрын бүрэн бүтэн байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй нь тогтоогдвол, зээлдэгч тэрхүү нөлөөллөөс зайлсхийх хэрэгтэй. Түүнчлэн, зээлдэгч нь:
- төлөвлөж буй аливаа бүтээн байгуулалт нь хуулиар зөвшөөрөгдсөн болохыг нотлох, энэ нь үндэсний

⁸⁰ Цэвэр эерэг нөлөөлөл гэдэг нь устаж байгаа төрөл зүйлд чухал амьдрах орчин хэмээн тодорхойлсон тухайн газар нутгийн биологийн олон янз байдлын үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлсэн хамгааллын арга хэмжээний нэмэлт үр дүн юм. Цэвэр эерэг нөлөөллийг биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар бий болгож болно. Түүнчлэн, зээлдэгч энэхүү ГШ-ын 16-д заасан шаардлагыг дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ явуулалгүй хангаж чадах тохиолдолд, амьдрах орчныг сайжруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах зорилгоор тухайн газар нутагт аливаа хөтөлбөр хэрэгжүүлэх замаар цэвэр эерэг нөлөөллийг бий болгож болно.

⁸¹ Тухайн тохиолдол бүрт хөндлөнгийн мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр устаж байгаа, мөн устаж болзошгүй төрөл зүйлд төслийн зүгээс “цэвэр сөрөг нөлөө үзүүлээгүй” болохыг батлах хугацаа.

⁸² Цэвэр сөрөг нөлөөлөл гэдэг нь урт хугацаанд дэлхий дахинаа болон бүс нутаг, тухайн улс орны түвшинд төрөл зүйлийн оршин тогтнох боломжийг алдагдуулах хэмжээнд тоо толгой нь хорогдохыг хэлнэ. Цэвэр сөрөг нөлөөллийн цар хэмжээг (дэлхий дахинаа, бүс нутагт, улс үндэсний хэмжээнд) IUCN-ны Ховордсон төрөл зүйлийн Улаан номд орсон жагсаалт, эсвэл бүс нутаг, улс орны жагсаалтад тухайн төрөл зүйл багтсан эсэхдээр тулгуурлан тогтооно. Цэвэр сөрөг нөлөөллийн хэмжээг үндэсний болон бүсийн тоо толгойн тооцрон дээр суурилан гаргана.

⁸³ Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (БОЯБХУАТ) нь биологийн голлох чухал төрөл зүйл, эсвэл чухал амьдрах орчинд цэвэр алдагдалд оруулахгүй байх/цэвэр үр ашиг бий болгох үүднээс үлдэгдэл нөлөөллийг бууруулах зорилго/зорилтууд, удирдлагын арга хэмжээ болон төлөвлөсөн үе шатуудыг агуулна. Тэдгээр зорилго/зорилтууд нь бодитой, хэмжиж болохуйц зорилтот үр дүнгүүд байвал зохино. Зорилт нэг бүрийн хүрээнд цуврал арга хэмжээнүүдийг тодорхойлж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд буюу хяналт шинжилгээний зорилтууд, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацааг тусгана. БОЯБХУАТ-г холбогдох талууд, түүний дотор Засгийн газар, хөндлөнгийн мэргэжилтнүүд, орон нутгийн ба олон улсын байгаль хамгаалах байгууллага, төслийн нөлөөлөлд өртсөн олон нийттэй зөвшилцөн боловсруулна.

⁸⁴ Биологийн олон янз байдлыг хамгаалах хэмжигдэхүйц үр дүнг газар дээр нь (олзлогдсон эсвэл хадгалах газарт биш, харин байгалийн нөхцөлд) болон зохих газарзүйн масштабаар (жишээ нь, орон нутаг, үндэсний эсвэл бүс нутгийн түвшинд) харуулах болно.

⁸⁵ “Ижил буюу илүү давуу байх” гэсэн зарчим нь ихэнх тохиолдолд биологийн олон янз байдлын нөхөн төлбөрийг төслийн нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлын ижил үнэ цэнийг хадгалахаар төлөвлөх ёстой гэсэн үг юм. Гэхдээ тодорхой нөхцөлд байдлаар төслийн нөлөөлөлд өртөх биологийн олон янз байдлын нутаг дэвсгэр нь үндэсний болон орон нутгийн хувьд чухал биш байж болох бөгөөд тухайн нутагт байгаль хамгаалах, тогтвортой ашиглахад илүү чухал ач холбогдолтой, аюулд өртсөн буюу хамгаалалт эсвэл үр дүнтэй менежмент шаардлагатай, ижил төстэй үнэт зүйл бүхий биологийн олон янз байдлын бусад төрөл зүйлс байж болно. Ийм нөхцөлд “илүү үнээр худалдан авах” (өөрөөр хэлбэл нөхөн төлбөр нь төслийн нөлөөлөлд өртсөнөөс илүү чухал ач холбогдол бүхий биологийн олон янз байдлыг нөхөх зорилготой) арга хэмжээг багтаасан “орлуулах (out-of-kind)” нөхөн тооцоог авч үзэх нь зохилтой.

⁸⁶ Энэхүү ГШ-д «Хамгаалалттай газар»-ын тухай IUCN-ны тодорхойлолтыг захираж болгов.

⁸⁷ ЮНЕСКО-ийн Дэлхийн байгалийн өвийн газар, ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандлын нөөц газар, Олон улсын ач холбогдол бүхий намгархаг газрын Рамсарын жагсаалт зэрэг олон улсын гэрээ, конвенцэд тодорхойлсон газар нутаг.

хуульд шаардсаны дагуу тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт төслөөс үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдсэнийг илтгэнэ;

- тийм газар нутагт Засгийн газрын зөвшөөрсөн удирдлагын төлөвлөгөөний дагуу ажиллах;
- ГШ.10-ын дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, эрх бүхий байгууллага, орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудтай санал болгож байгаа төслийн талаар зөвшилцөх; ба
- шаардлагатай бол тусгай хамгаалалттай газрыг хадгалан хамгаалах зорилтыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх.

Түрэмгий харь амьтан, шавж

23. Зээлдэгч биологийн олон янз байдалд үлэмж сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй харь амьтан, шавжийг тохиолдлоор эсвэл санаатайгаар алдах, нутагшуулахаас зайлсхийнэ. Тухайлбал:

- зээлдэгч нь холбогдох хууль, журмын дагуу зориудаар энэ төрлийн арга хэмжээг аваагүй л бол аливаа харь амьтан, шавжийг тэдний өмнө нь байгаагүй нутаг дэвсгэрт санаатайгаар тараан нутагшуулахыг хориглоно. Ямар ч нөхцөлд эзлэн түрэмгийлэх хандлагатай харь амьтан, шавжийг шинэ газар нутагшуулах ёсгүй;
- зээлдэгч харь амьтан, шавжийг⁸⁸ санамсаргүй тээвэрлэсэн, алдсан тохиолдолд үүсэх эрсдэл, нөлөөлөл болон нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлно; мөн
- төлөвлөсөн төсөл хэрэгжих үлс орон, бүс нутагт харь амьтан, шавж хэдийнээ нутагшсан тохиолдолд зээлдэгч тэдгээрийг шинэ нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй байх чиглэлд холбогдох арга хэмжээг хариуцлагатайгаар авна.

Байгалийн амьд нөөцийн тогтвортой удирдлага

24. Газар тариалан, мал аж ахуй, байгалийн болон таримал ойн аж ахуй, усны амьтан ургамал өсгөн үржүүлэх, загасны аж ахуй, эрчим хүч, био түлшний биомасс үйлдвэрлэх, ашиглах зэрэг байгалийн амьд нөөцийн анхан шатны үйлдвэрлэлийг хамарсан төслүүд нь энэхүү ГШ-ын холбогдох бүх шаардлагууд болон доорх шаардлагуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

- Зээлдэгч нь байгалийн амьд нөөцийг ашиглахдаа үндэсний хууль, тогтоомжид тусгагдсан шаардлага, ОУСТ, ЕХ-ны байгаль орчны стандартыг төслийн түвшинд баримтална.
- Шаардлагатай бол зээлдэгч нь олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, дараах шалгуурыг хангасан стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлнэ. Үүнд: (i) олон тооны оролцогч талуудтай зөвшилцөх замаар боловсруулсан байх; мөн (ii) магадлан итгэмжлэл нь эдгээр стандартын

дагуу зохих итгэмжлэгдсэн байгууллагын хөндлөнгийн баталгаажуулалт буюу аттестатчилалд хамрагдсан байх шаардлага орно. Дагаж мөрдөх стандарт ба/буюу аттестатчилах тогтолцоо байхгүй тохиолдолд, зээлдэгч тухайн салбарын онцлогт нийцсэн тогтвортой удирдлагын арга зарчмыг нэвтрүүлэх үүрэг хүлээнэ.

- Зээлдэгч газар дээр суурилсан хөдөө аж ахуйн бизнесийн төслүүдээ биологийн чухал төрөл зүйлүүд болон/эсвэл чухал амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийг нь багасгахын тулд боломжтой бол ойгүй газар, эсвэл байгалийн төлөв байдлаасаа аль хэдийн өөрчлөгдсөн газарт байршуулна.
- Эзлэн түрэмгийлэх шинжтэй амьтан, шавжийг үйлдвэрлэлийн орчноос гадагш алдах/тараахаас сэргийлэх зохистой хяналт тавихгүйгээр үйлдвэрлэх ба/буюу ашиглахыг хориглоно.
- Загасны аж ахуйн⁸⁹ буюу усны амьтан ургамал өсгөн үржүүлэх төслийн тухайд зээлдэгч нь уугуул бүс амьтдын усны орчинруу зугтан орох эрсдлийг үнэлж, багасгах болно. Мөн зээлдэгч уугуул орчинд аливаа өвчин, шимэгчдийг дамжуулан тараах эрсдлийг үнэлж, бууруулна.
- Зээлдэгч нь мах, дайвар бүтээгдэхүүн (жишээ нь сүү, өндөг, ноос)-ний зориулалтаар мал амьтны үржүүлэг, тээвэрлэлт, нядалгааны үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд мал аж ахуйн арга ажиллагаандаа үндэсний хууль тогтоомжийн холбогдох шаардлага, ЕХ-ны мал амьтны халамжийн стандарт болон ОУСТ-ийн аль илүү хатуу шаардлагатайг нь дагаж баримтална.
- Нянгийн тэсвэржилт (НТ)⁹⁰-ийг багасгахын тулд зээлдэгч нь антибиотикийг ЕХ-ны байгаль орчны стандартын дагуу зөвхөн эрүүл хүнс үйлдвэрлэдэг мал амьтдад л хэрэглэнэ.
- ЕХ-ны гишүүн улсуудад генетикийн хувьд өөрчлөгдсөн организм (ГХӨО)-ыг холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хэрэглэх, байгальд нутагшуулахыг хориглодог. ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулж буй бусад улс оронд ГХӨО-ыг ЕХ-ны байгаль орчны тодорхой стандартын дагуу эрсдлийн үнэлгээ хийлгүйгээр ашиглах, байгальд нутагшуулах боломжгүй.

Ханган нийлүүлэлтийн сүлжээ

25. ГШ.1-т тусгасан хангийн нийлүүлэлтийн сүлжээний үнэлгээний үйл явцын хүрээнд зээлдэгч нь гол ханган нийлүүлэгчдийн⁹¹ зүгээс биологийн олон янз байдалд учруулсан эрсдэл, нөлөөллийг тодорхойлж, үнэлнэ.

⁸⁸ Бараа ба үйлчилгээний олон улсын усан тээвэрлэлтийн хувьд энэхүү ПШ-д Усан онгоцны усан тохируулагч дайвар болон тунадасны хяналт ба менежментийн тухай олон улсын конвенц (BWM)-ыг удирдлага болгоно. Тийм тээвэрлэлт шаардагдах төсөлд ЕСБХБ-ны санхүүжилт хүсч байгаа зээлдэгч тус конвенцын хүрээнд тогтоосон үүрэг хариуцлагыг биелүүлэх ёстой.

⁸⁹ Загасны аж ахуйн үйл ажиллагаа нь зөвхөн агнуураар хязгаарлагдахгүй. Өөр өөр төрөл зүйл, популяцийг ялангуяа нуур зэрэг хаагдмал орчинд нэвтрүүлж, тоо толгойг нь өсгөснөөр шинэ сүрэг нь одоогийн орон нутгийн эндемик/байгалийн загасны төрөл зүйлийг устгах буюу шахан гаргах ёсгүй.

⁹⁰ Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-ын тодорхойлсноор нянгийн эсрэг бодис нь халдвар, ялангуяа бактерийн гаралтай халдварыг эмчлэхэд ашиглагддаг эм юм. Тэдгээр эм нь хүн болон мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтныг халамжлахад зайлшгүй шаардлагатай. Ийм эмийн хэт их буюу зохисгүй хэрэглээ нь антибиотик эмчилгээнд хариу үзүүлэхгүй тэсвэртэй бактери үүсэхэд хүргэдэг. Үүнийг ихэвчлэн нянгийн тэсвэржилт буюу НТ гэж нэрлэдэг.

⁹¹ Гол ханган нийлүүлэгчид болон төслийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн тодорхойлолтыг ГШ.1-ийн зүүлт тайлбар #22-оос харна уу.

26. Хэрэв энэхүү эрсдлийн үнэлгээгээр биологийн чухал төрөл зүйл болон/эсвэл чухал амьдрах орчин нь зээлдэгчийн гол ханган нийлүүлэгчдийн сөрөг нөлөөлөлд өртсөн байж болзошгүйг тодорхойлсон, эсвэл төслийн үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, материалын ханган нийлүүлэлтийн сүлжээний доод шатанд ийм эрсдэл мэдээлэгдсэн тохиолдолд зээлдэгч нь ЕСБХБ-тай тохиролцсон хугацаанд багтаан ОУСТ-ийн дагуу тухайн үүссэн нөхцөл байдлыг арилгах арга хэмжээг авна.
27. Хэрэв зээлдэгч нь биологийн чухал төрөл зүйл ба/буюу чухал амьдрах орчин нь ихээхэн хувирах, доройтох эрсдэлтэй газар нутгаас гарал үүсэлтэй хоол хүнс, гуалин, эслэг гэх мэт байгалийн амьд нөөцийн бараа бүтээгдэхүүн худалдан авбал, байгаль орчин, нийгмийн үнэлгээнийхээ хүрээнд өөрийн гол ханган нийлүүлэгчдийн шалган баталгаажуулах тогтолцоо, арга дадлыг үнэлнэ. Зээлдэгч бүтээгдэхүүн худалдан авахдаа боломжтой бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой удирдлагын зарчим, стандартын дагуу үйлдвэрлэгдсэн байгалийн амьд нөөцийг худалдан авахыг илүүд үзнэ.
28. Зээлдэгч нь хамгийн багадаа дараах зорилтуудыг хангах бодлого, журам, шалган баталгаажуулах дадлыг бий болгоно. Тухайлбал:
- нийлүүлэлтийн гарал үүсэл ба үүссэн газрын амьдрах орчны төрөл хэлбэрийг тодорхойлох;
 - биологийн чухал төрөл зүйл, чухал амьдрах орчин ба/буюу тусгай хамгаалалттай газар нутгийг ихээхэн хувиргаж, доройтуулахад хувь нэмэр оруулж буй ханган нийлүүлэгчдээс худалдан авалт хийхээс зайлсхийх; болон
 - зээлдэгчийн гол ханган нийлүүлэгчдийн байнгын хяналт үнэлгээгээр хангах.
29. Зээлдэгч эдгээр эрсдлийг бүрэн шийдвэрлэж чадах эсэх нь түүний гол ханган нийлүүлэгчдэдээ ямар хэмжээнд нөлөөлж, хяналтандаа байлгах арга хамаарна.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 7: Нутгийн уугуул иргэд

Танилцуулга

1. Энэхүү ГШ нь нутгийн уугуул иргэд бол үндэсний нийгмийн тогтолцоонд давамгайлалч бүлгүүдээс ялгагдах өөрийн гэсэн онцлог хэв шинж болон амьжиргаатай нийгмийн бүлэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тэд хүн амын дундах хамгийн их орхигдсон, эмзэг бүлэгт хамаардаг байж болно. Тэдний эдийн засаг, нийгэм, эрх зүйн байдал нь газар нутаг, нөөцийг (байгалийн болон соёлын аль алиных нь) хүртэх эрх, ашиг сонирхлоо хамгаалах чадамжийг хязгаарлаж болох юм. Энэ нь тэдний эдийн засаг, оюун санааны хувьд тэрхүү газар нутаг, нөөц баялгаас хараат байдалтай нь хавсарснаар тэднийг төслийн аливаа сөрөг нөлөөлөлд нэн өртөмтгий болгож болзошгүй. Уг ГШ нь нутгийн уугуул иргэд өвөрмөц мэдлэг, чадвартай, тогтвортой хөгжлийн боломжит түншүүд бөгөөд төсөлтэй холбоотой үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, үр шимийг нь хүртдэг гэдгийг мөн хүлээн зөвшөөрч байна.
2. Тус ГШ нь нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалахад засгийн газар голлох үүрэг гүйцэтгэнэ гэдгийг хүлээн зөвшөөрч байна. ГШ нь төслийн зүгээс нутгийн уугуул иргэдэд нөлөөлөл үзүүлэх боломжийг үнэлэх, нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдтэй бүтээлчээр зөвлөлдөх, мөн уг ГШ-д заасан тодорхой нөхцөл байдлын хүрээнд нутгийн уугуул иргэдээс чөлөөтэй, урьдчилсан бөгөөд таниулсан зөвшөөрөл (ЧУТЗ) авах зэрэг зээлдэгчийн хүлээсэн үүргийг тодорхойлсон. Мөн энэхүү ГШ нь зээлдэгч төслийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгах, бууруулах, нөхөн төлбөр олгох, төслийн үр шимийг хуваалцах арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх чиглэлд нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдтэй хамтран ажиллах үүрэгтэйг онцолсон.

Зорилт

3. Энэхүү ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - төслүүд нутгийн уугуул иргэдийн нэр төр, эрх, хүсэл эрмэлзэл, соёл, зан заншлын хэм хэмжээ болон амьжиргааг бүх талаар хүндэтгэх нөхцлийг хангах;
 - нутгийн уугуул иргэдийн амьдрал, амьжиргаанд төслийн үзүүлэх эрсдэл, сөрөг нөлөөллийг⁹² урьдчилан таамаглах, түүнээс зайлсхийх, эсвэл зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг багасгах, бууруулах, нөхөн төлбөр олгох;
 - хүртээмжтэй, соёлын хувьд зохистой, эргэтэй, эмэгтэй уугуул иргэдийг тэгш хамруулсан байдлаар тогтвортой хөгжлийн үр шим, боломжийг нутгийн уугуул иргэд хүртэхийг хөхиүлэн дэмжих;

- төсөл хэрэгжих бүхий л хугацаанд төслийн нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдтэй байнгын харилцаа тогтоож, хадгалж үлдэх;
- төслийн үйл ажиллагаа, эсвэл нутгийн уугуул иргэдэд эерэг, сөрөг ямар ч байдлаар нөлөөлж болох нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд нутгийн уугуул иргэдийн бүтээлч оролцоог хангах; мөн
- нутгийн уугуул иргэдтэй сайн санааны хэлэлцээр хийж, энэхүү ГШ-д тодорхойлсон тухайлсан нөхцөл байдалд тэдний ЧУТЗ-ийг авах.

Үйлчлэх хүрээ

4. Уг ГШ-д “нутгийн уугуул иргэд” гэсэн нэр томъёог аливаа улс үндэсний нийгэм дэх хүн амын зонхилох бүлгүүдээс ялгагдах дараах бүх онцлог шинж чанарыг⁹³ агуулсан нийгэм болоод соёлын бүлгийг илэрхийлэхэд техникийн утгаар хэрэглэсэн болно. Үүнд:
 - өөрсдийгөө яс үндэс, эсвэл соёлын хувьд бусдаас ялгаатай уугуул бүлэг хэмээн тодорхойлдог, үүнийг бусад нь хүлээн зөвшөөрсөн;
 - төсөл хэрэгжих нутаг дэвсгэр дэх газар зүйн хувьд ялгаатай амьдрах орчин, уламжлалт газар нутаг, эсвэл өвөг дээдсээс уламжилж ирсэн нутаг, тухайн амьдрах орчин, газар нутагт⁹⁴ байгаа байгалийн нөөц баялгаас нийтээрээ хамааралтай байдаг;
 - уламжлан ирсэн соёл, эдийн засаг, нийгэм эсвэл улс төрийн институц, хууль тогтоомж нь зонхилж буй нийгэм, соёлоос ялгаатай байдаг; мөн
 - тухайн улс орон эсвэл бүс нутгийн албан ёсны хэл, нутгийн аялгаас өөр ялгаатай хэл, нутгийн аялгаар ярьдаг гэсэн шинж чанарууд багтана.
5. Нүүдлийн эсвэл бэлчээрийн аж ахуйд тулгуурласан амьдралын хэв маягтай, холимог эсвэл хот суурин газарт амьдардаг ба/буюу зөвхөн улирлын шинжтэй уламжлалт нутагтаа очдог бүлэг эсвэл бүлгийн гишүүд ч мөн хүчээр нутаг таслагдахад хүрч болно. Тэдний одоогийн амьдралын хэв маяг, хүчээр нутаг таслагдсан байдлын аль нь ч уг ГШ-ын үйлчлэлд багтах боломжийг алдагдуулахгүй.
6. Энэхүү ГШ-ын заалтуудыг биелүүлэхэд зайлшгүй шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэхэд уг ГШ болон ГШ.1, 5, 8 ба 10-ыг боломжийн хэрээр удирдлага болгох ёстой.

⁹² Сөрөг нөлөөлөл гэдэгт төслийн үйл ажиллагааны улмаас өмч хөрөнгө эсвэл нөөцөө алдах, газар ашиглах эсвэл уламжлалт амьдралын хэв маягийг илтгэсэн үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарласны улмаас үүсэж буй нөлөөлөл багтаж болох бөгөөд гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.

⁹³ Илүү өргөн хүрээний нийгэм, эдийн засагт нэгдэх замаар, зарим тохиолдолд засгийн газрын бодлогын үр дүнд зарим бүлэг, эсвэл олон нийтийн хувьд зарим нэг онцлог шинж чанар нь суларсан эсвэл бага илэрсэн байж болно.

⁹⁴ Нутгаасаа хүчээр таслагдсанаас “төсөл хэрэгжих нутаг дэвсгэр дэх газарзүйн хувьд ялгаатай амьдрах орчин, эсвэл өвөг дээдсээс уламжилж ирсэн газар нутгаас хамаарах хамтын хамаарал”-аа алдсан бүлэг хүмүүст энэхүү ГШ-ын заалтууд хэвээр үйлчилнэ. “Хүчээр таслагдах” гэдэг нь зөрчил мөргөлдөөн, засгийн газрын нүүлгэн суурьшуулах хөтөлбөр, газар нутгаас нь салгах, байгалийн гамшигт өртөх, эсвэл тухайн нутаг дэвсгэрийг хот суурин газарт нэгтгэх болсны улмаас газарзүйн хувьд ялгаатай амьдрах орчин, эсвэл өвөг дээдсийнхөө газар нутагт амьдрах хамтын хамаарлаа алдахыг хэлнэ. Тус ГШ-ийн хувьд “хот суурин газар” гэдэгт хот буюу томоохон суурин газрыг ойлгох ба энэ нь дараах бүх шинжийг агуулна (аль нэг шинжээр дангаар нь хот сууриныг тодорхойлохгүй). Үүнд: (i) үндэсний хууль тогтоомжийн дагуу хот суурин газарт тооцогдсон, (ii) хүн амын нягтрал өндөр, (iii) хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай харьцуулахад хөдөө аж ахуйн бүс эдийн засгийн үйл ажиллагаа давамгайлсан шинж чанарууд орно.

Шаардлага

Үнэлгээ

7. Зээлдэгч нь аль болох төслийн мөчлөгийн эхэнд, гэхдээ байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явцаас хоцролгүйгээр уг ГШ-ийг дагаж мөрдөх хүрээг тодорхойлно. Зээлдэгчийн байгууллагад зохих нөөц, үр чадвар байхгүй бол тухайн бүлэг энэхүү ГШ-ын 4-б дугаар заалтад тусгасан шалгуурыг хангах эсэхийг тогтоохын тулд түршлагатай, бие даасан нийгмийн мэргэжилтнүүдийн зөвлөгөөг авна.
8. Нутгийн уугуул иргэдэд нөлөөлөх төлөвтэй төслийн хувьд зээлдэгч нь уугуул иргэдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийнэ. Зээлдэгч юуны өмнө сөрөг нөлөөллөөс зайлсхийхийг урьтал болгох бөгөөд хэрэв энэ нь боломжгүй бол болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах ба/буюу багасгах төлөвлөгөөг боловсруулж, нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдэд үр шим хүртээх боломжуудыг тодорхойлно.
9. Төсөл эхлээгүй байгаа тохиолдолд зээлдэгч нь бодит, бие даасан судалгаа явуулж, төслийн шүүд эсвэл шүүд бүс нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн уугуул иргэдийн бүлгийг тодорхойлох, нөлөөлөлд өртсөн уугуул иргэдтэй зөвлөлдөх замаар төслийн зүгээс тэдэнд учирч болзошгүй нөлөөллийг үнэлж, төслийн талаарх тэдний үзэл бодлыг сонсоно. Энэ үнэлгээ нь нутгийн уугуул иргэдийн хүрээлэн буй орчин, амьдралын хэв маягт гарах өөрчлөлтөд өртөх тодорхой эмзэг байдлыг авч үзнэ.
10. Төслийн барилгын ажил, төсөлтэй холбоотой үйл ажиллагаа, эсвэл хэрэгжилт эхэлсэн тохиолдолд зээлдэгч нь төслийн нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн санал бодлыг авч, түүн дээр үндэслэн ажилласан гэдгийг нотлох холбогдох бүх мэдээлэл, баримт бичгийг бүрдүүлж өгнө. Тэдгээр баримт бичигт зээлдэгчийн өнгөрсөн хугацаанд буюу өнөөдрийг хүртэл уугуул иргэдийн тухайд хийсэн ажлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл болон эрх бүхий байгууллагуудад өмнө нь хүргүүлсэн баримт бичгийн бүртгэл багтана.
11. Хэрэв энэхүү ГШ-ын шаардлагуудыг хангаагүй бол зээлдэгч уг ГШ-ын 7-10 дахь заалтуудад тусгасан үнэлгээг хийнэ. Үнэлгээ нь: (i) нутгийн уугуул иргэдийн амь, амьжиргаанд өнөөг хүртэл үзүүлж ирсэн үр нөлөөг үнэлж; (ii) энэхүү стандартын шаардлагаас зөрүүтэй байгаа аливаа дутагдлыг илрүүлж; мөн (iii) энэхүү ГШ-ын төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд авах шаардлагатай байж болох засаж залруулах арга хэмжээг тодорхойлно. Дараа нь зээлдэгч үйл ажиллагааны төлөвлөгөөгөө ЕСБХБ-тай хэлэлцэн тохиролцоно.

Бүтээлчээр зөвлөлдөх болон ЧУТЗ

Бүтээлчээр зөвлөлдөх

12. Зээлдэгч төслийг төлөвлөх хугацаандаа аль болох эртнээс нутгийн уугуул иргэдийн дундах нөлөөлөлд өртсөн бүлгүүдтэй байнгын харилцаа холбоо тогтоож, ГШ.10-т заасан ёсоор, төслийн зүгээс нутгийн уугуул иргэдэд учруулж буй эрсдэл, боломжит нөлөөллийн цар хүрээтэй уялдуулсан байдлаар бүтээлчээр зөвлөлдөх арга хэмжээ авна. Түүнчлэн, зөвлөлдөх явцад дараах асуудалд анхаарна. Үүнд:
 - нутгийн уугуул иргэдийн төлөөллийн байгууллага (жишээ нь: ахмадын зөвлөл, эсвэл тосгоны зөвлөл гэх мэт), уугуул иргэдийн байгууллага болон уугуул иргэдийн дундах нөлөөлөлд өртсөн бүлгийн гишүүдийг оролцуулах;

- аливаа холбогдох заншлын хууль, хэм хэмжээг ойлгож, хүндэтгэх;
- нутгийн уугуул иргэдийн хамтаар шийдвэр гаргах үйл явцад хангалттай хугацаа олгох;
- төслийн үйл ажиллагаа, эсвэл нутгийн уугуул иргэдэд эерэг, эсвэл сөргөөр нөлөөлж болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд тэднийг үр дүнтэй оролцуулах; болон
- дараах асуудлуудыг харгалзан олон нийтийн дундах ялгаатай, өөр өөр байдлыг хүлээн зөвшөөрөх, үүнд:
 - o нутгийн уугуул иргэд холимог олон нийт дүнд, уугуул бүс хүмүүстэй хамт амьдарч байж болно; мөн
 - o нутгийн уугуул иргэд олон ургалч үзэл бодолтой, зөвлөлдөх болон оролцоог хангахад бүх насны иргэд, хүйсийн төлөөллийг тэгш хамруулсан, нийгмээс тусгаарлагдсан бүлгүүдийг татан оролцуулсан байх шаардлагатай.

ЧУТЗ

13. ЧУТЗ-ийн тухайд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт байдаггүй. Гэсэн хэдий ч энэхүү ГШ-ийн зорилгын үүднээс зөвшөөрөл гэдэг нь төслийн нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн зүгээс тэдэнд нөлөөлөл үзүүлж буй санал болгосон төслийн үйл ажиллагааг хамтдаа дэмжихийг хэлнэ. ЧУТЗ нь дээр дурдсан бүтээлчээр зөвлөлдөх үйл явц дээр тулгуурлан, түүнийг өргөжүүлэн тэлдэг бөгөөд зээлдэгч болон нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн хоорондох сайн санааны хэлэлцээрээр дамжин бий болдог. Тэрхүү хэлэлцээрийн үр дүнд нутгийн уугуул иргэд соёлын уламжлал, зан заншил, дадлын дагуу шийдвэрт хүрдэг. ЧУТЗ нь бүгд санал нэгтэй байхыг шаарддаггүй бөгөөд нутгийн уугуул иргэдийн доторх эсвэл дундах хувь хүмүүс эсвэл бүлгүүд илт санал зөрөлдөж байсан ч ЧУТЗ-д хүрч болдог.
14. Нөлөөлөлд өртсөн уугуул иргэдийн ЧУТЗ нь дараах тохиолдолд шаардлагатай байдаг. Үүнд: (i) төсөл нь тэдний уламжлалт газар нутаг, эсвэл нөөц баялгад нөлөөлөхөөр бол; (ii) тэднийг уламжлагдан ирсэн эсвэл заншлын дагуу амьдарч буй газар нутгаас нь нүүлгэн шилжүүлэхээр бол; эсвэл (iii) тэдний соёлын нөөцөд нөлөөлөх, эсвэл ашиглахыг санал болгож байгаа бол.
15. Эдгээр тохиолдолд зээлдэгч нь сайн санааны хэлэлцээр хийх болон ЧУТЗ-ийн үйл явцыг хэрэгжүүлж, баримтжуулахад туслалцаа үзүүлэх чадварлаг, түршлагатай, бие даасан мэргэжилтнүүдийг ажиллуулна.

Уламжлагдан ирсэн газар нутаг, нөөц баялгад үзүүлэх нөлөөлөл

16. Нутгийн уугуул иргэд ихэвчлэн өөрсдийн амьдарч буй эрт үеэс уламжлагдан ирсэн газар нутаг, ой мод, ус, ан амьтан болон бусад байгалийн нөөцтэй нягт хэлхээ холбоотой байдаг. Энэхүү хэлхээ холбоо нь тэдний амь амьжиргаа, соёл, зан үйл, эсвэл сүсэг бишрэлтэй холбоотой ба ихэнх зэрэгцээ уугуул иргэдийн бусдаас ялгарах өвөрмөц нэгдмэл шинж хийгээд олон нийтийг тодорхойлох боломжтой. Тиймээс хэрэв төсөл ийм хэлхээ холбоонд нөлөөлж байвал түүнийг тусгайлан авч үзэх шаардлагатай. Хэдийгээр үндэсний хууль, тогтоомжийн дагуу ийм газар нутгийг уугуул иргэд хууль ёсоор өмчлөх эрхгүй байдаг ч тэд уг газрыг улирлын буюу мөчлөгийн чанартайгаар ашиглаж байдгийг нотлон баримтжуулах боломжтой.

17. Хэрэв зээлдэгч нь өөрийн төслийг нутгийн уугуул иргэдийн уламжлагдан ашиглаж ирсэн газар нутагт хэрэгжүүлэхээр санал болгох юм уу эсвэл тухайн газрын байгалийн нөөц баялгийг арилжааны зорилгоор боловсруулан ашигласнаар уугуул иргэдийн амь амьжиргаа болон тэдний нэгдмэл шинж чанар, онцлогийг илэрхийлдэг соёл, ёслолын ба сүсэг бишрэлийн ёс жаягт сөргөөр нөлөөлж болзошгүй бол зээлдэгч тэднээс ЧУТЗ-ийг нь авна. Цаашилбал, зээлдэгч дараах арга хэмжээг авна. Үүнд:

- нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн олон нийттэй хамтран тэдний газар, нөөц баялгийн ашиглалтыг мэргэжилтнүүдээр баримтжуулах, ингэхдээ бусад нутгийн уугуул иргэдийн газар ашиглах эрхэд хохирол учруулахгүй байхад анхаарах; үнэлгээ нь жендэрийн тэгш оролцоог хангасан байхаас гадна нөөц баялгийг захиран зарцуулахад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг тусгайлан авч үзсэн байна;
- төслийн хэрэгцээнд нутгийн уугуул иргэдийн ашиглаж, оршин сууж байгаа ба/буюу эзэмшиж буй газрыг ашиглахаас зайлсхийх, эсвэл ашиглах талбайн хэмжээг нь аль болохоор багасгах талаар авсан арга хэмжээгээ баримтжуулах;
- нутгийн уугуул иргэдэд үндэсний хууль тогтоомжид заасан газар ашиглах эрх, тэр дундаа заншлын хэм хэмжээний дагуух газрын эрх, эсвэл газар ашиглах эрхийг албажүүлсан аливаа хууль, тогтоомж байгаа тохиолдолд энэ талаар мэдээлэх;
- нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдэд дотроо тохиролцоонд хүрэх хангалттай хугацаа өгөх, ингэхдээ зээлдэгчийн зүгээс өөрийн санааг шууд эсвэл шууд бусаар тулгахгүй;
- уугуул иргэдийг байгалийн нөөцийг үргэлжлүүлэн ашиглах боломжоор хангах, эсвэл тэрхүү байгалийн нөөцийг дүйцүүлэн орлуулах, ийм боломжгүй тохиолдолд шийдвэрлэх эцсийн хувилбар болгон байгалийн нөөцийг ашиглах эрхээ алдсаны нөхөн олговрыг олгох; болон
- нөлөөлөлд өртсөн уугуул иргэдийг зээлдэгчийн ашиглаж буй газрыг ашиглах, дамжин өнгөрөх боломжоор хангах, энэ тохиолдолд аюулгүй байдал, эрүүл ахуй, хамгаалалтын асуудлуудад анхаарах.

Нутгийн уугуул иргэдийг уламжлан ашиглаж ирсэн буюу заншсан газар нутгаас нь нүүлгэн шилжүүлэх

18. Зээлдэгч нутгийн уугуул иргэдийг хамтаараа уламжлал эсвэл зан заншлын хэм хэмжээний дагуу ашиглаж ирсэн газар нутгаас нь нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнээс зайлсхийх боломжит хувилбаруудыг төсөл боловсруулахдаа авч үзнэ. Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх боломжгүй бол зээлдэгч нь өөрийн ашиглах газрын хэмжээг багасгаж, нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдээс чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангаж таниулсны үндсэн дээр зөвшөөрөл авалгүйгээр нүүлгэн шилжүүлэлт явуулахгүй байх хэрэгтэй. Нутгийн уугуул иргэдийг нүүлгэн шилжүүлэх аливаа арга хэмжээ нь ГШ.5-д заасан шаардлагыг хангасан байна. Түүнчлэн, нутгийн уугуул иргэдийн уламжлан өмчилж, ашиглаж ирсэн газар нь тэдний зөвшөөрөл (ЧУТЗ)-гүйгээр төслийн үйл

ажиллагаа явуулсны улмаас хураагдсан, булаагдсан, эзлэгдсэн, ашиглагдсан, эсвэл эвдэрч гэмтсэн тохиолдолд тэдгээр уугуул иргэд зээлдэгчээс газар, нутаг дэвсгэр, байгалийн нөөцөө алдсаны төлөө шударга, тэгш нөхөн олговор авах эрхтэй.

19. Боломжтой бол, хэрэв нутгийн уугуул иргэдийг нүүлгэн шилжүүлэх шалтгаан байхгүй болсон тохиолдолд тийнхүү шилжин нүүсэн уугуул иргэд өмнө нь үе уламжлан амьдарч, заншсан газартаа эргэж ирэх боломжтой байвал зохино. Энэ тохиолдолд тухайн газрыг бүрэн нөхөн сэргээсэн байх ёстой.

Соёлын өв

20. Хэрэв төсөл нь уугуул иргэдийн өвөрмөц онцлог шинж байдал болон/эсвэл соёл, ёслолын болон оюун санааны шинж чанарт чухал ач холбогдолтой соёлын өвд ихээхэн нөлөөлж болзошгүй тохиолдолд ийм нөлөөллөөс зайлсхийхэд нэн тэргүүнд анхаарна. Их хэмжээний нөлөөллөөс зайлсхийх боломжгүй тохиолдолд зээлдэгч нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн ЧУТЗ-ийг авч, ГШ.8-ын шаардлагуудыг хангана.
21. Хэрэв төсөл нь нутгийн уугуул иргэдийн соёлын нөөц баялаг, мэдлэг, инновац эсвэл дадал туршлагыг арилжааны зорилгоор ашиглахыг санал болгож байгаа бол зээлдэгч нь нутгийн уугуул иргэдэд: (i) энэхүү ГШ-ын хүрээнд тэдэнд олгогдсон эрх, (ii) санал болгосон арилжааны үйл ажиллагааны цар хүрээ ба шинж чанар, (iii) энэхүү үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй үр дагаврын тухай мэдээлж, (iv) тэднээс ЧУТЗ-ийг нь авна. Зээлдэгч нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн мэдлэг, инновац, дадал туршлагыг ёс заншил болон уламжлалд нь нийцсэн хэлбэрээр ашиг орлого олох үйл ажиллагаанд ашигласнаас олсон үр шимийг шударга, тэнцүү хуваахыг хөхиүлэн дэмжсэн механизмыг бүрдүүлж хэрэгжүүлнэ.

Нөхөн олговор болон үр шимийг хуваалцах

22. Зээлдэгч нь орон нутгийн иргэдтэй тохиролцсоны дагуу төслийн нөлөөлөлд өртсөн уугуул иргэдийн аж амьдрал төсөлтэй холбоотой үйл ажиллагааны улмаас алдагдал, хохирол амссан бол шударгаар нөхөн олговор олгоно. Нөхөн олговрын хэмжээг тооцоолохдоо зээлдэгч ГШ.5-ын заалтуудыг мөрдөх ба уламжлалт амьжиргаа⁹⁵, тухайлбал нүүдэлчин/бэлчээрийн аж ахуйд тулгуурласан хэв маяг, мөн уугуул иргэдийн гэр бүлийн амьдралд төслийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөөллийг харгалзан үзнэ. Ингэхдээ эмэгтэйчүүдийн цалин хөлс болон цалингүй амь зуулгын ажлыг тусгайлан анхаарна. Нөхөн олговрыг тодорхойлохдоо уугуул иргэдийн төлөөлөл болон холбогдох мэргэжилтнүүдтэй зөвшилцөж, хамтран ажиллана. Зээлдэгч нь орон нутгийн болон бүсийн эрх бүхий төрийн байгууллагад нөхөн олговор олгох тохиолдолд мөн энэхүү заалт үйлчилнэ.

⁹⁵ "Уламжлалт амь амьжиргаа"-ны мөн чанарыг уян хатан байдлаар тайлбарлах ёстой (тухайлбал, угсаатны аялал жуулчлал, хүнс боловсруулах зэрэг орчин үед нийцүүлсэн байдлыг багтаан авч үзэх).

23. Нөхөн олговор ба/буюу нөөцийг шилжүүлэх харилцан хүлээн зөвшөөрөгдсөн, хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжих боломжтой механизмудыг бүрдүүлнэ. Газар ба нөөц баялгийг хамтад нь өмчилж байгаа тохиолдолд эдгээрийг хамтын зарчмаар олгож болно. Зээлдэгч нь нөхөн олговрыг шаардлага хангасан бүх гишүүдэд үр дүнтэй хуваарилах, эсвэл бүлгийн бүх гишүүдэд ашигтай байдлаар хамтдаа ашиглах бололцоог хангасан зохистой удирдлага, засаглалын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
24. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн уугуул иргэдэд соёлын хувьд зохистой хөгжлийн үр өгөөжийг хүртэх боломжийг олгоно. Ийм боломжууд нь тэдний амьжиргааны түвшин, амьдралын чанарыг зохих ёсоор дээшлүүлэх, уугуул иргэдийн хамааралтай байж болох байгалийн баялгийн үрт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилго болон төслийн нөлөөллийн зэрэгтэй тохирсон байх ёстой. Хөгжлийн тэтгэмжийг цаг тухайд нь олгоно.
25. Зээлдэгчийн санал болгож буй сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, нөхөн олговор олгох, мөн төслөөс хүртэх үр шимийг тодорхойлон хуваалцах арга хэмжээнүүдийг уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөө (УИХТ) гэх мэт тодорхой хэрэгжүүлэх хугацаа заасан төлөвлөгөө, эсвэл нутгийн уугуул иргэдийн асуудлыг тусад нь бүлэг болгон багтаасан илүү өргөн хүрээний орон нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Төлөвлөгөөг төслийн нөлөөлөлд өртсөн уугуул иргэдтэй зөвлөлдөн боловсруулна. Мөн зээлдэгч уг төлөвлөгөөг боловсруулах техникийн зохих мэдлэгтэй, чадварлаг мэргэжилтнүүдийг авч ажилуулна. УИХТ нь хүйс ба өөр өөр үеийн хүмүүсийн хувьд ялгаатай төслийн нөлөөллийг системтэйгээр үнэлж, олон нийтийн дундах янз бүрийн бүлгүүдэд үзүүлэх нөлөөллийг арилгах арга хэмжээг багтаасан байна. УИХТ-ний хамрах хүрээ болон нарийвчлал нь тухайн төсөл, төслийн мөн чанар, төслийн үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран өөр өөр байна.
26. Нутгийн уугуул иргэдэд төслөөс бий болох үр шимээс хүртэх боломж олгоогүй, тухайлбал үндэс угсаанаас хамааран ажил эрхлэх боломжийг нь хассан бол төслийн үйл ажиллагаанд дараах засаж залруулах арга хэмжээг тусгана. Үүнд: (i) нутгийн уугуул иргэдийн байгууллага, хувь хүмүүст хөдөлмөрийн, нийгмийн, санхүүгийн болон бизнесийн хууль тогтоомжоор баталгаажсан эрх, мөн тэдний ашиглаж болох тусламж эрэх механизмын тухай мэдээлэх; (ii) зохих үр дүнтэй мэдээлэл түгээх, сургалт явуулах болон зээл, ажил эрхлэлт, бизнесийн үйлчилгээ, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, мөн төслөөс бий болгосон эсвэл дэмжсэн бусад үр шим, баялгаас хүртэхэд тулгарч буй саад, бэрхшээлийг арилгах арга хэмжээ авах; мөн (iii) нутгийн уугуул ажилтан, ажилчид, бизнес эрхлэгчид болон үр шим хүртэгсдэд тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд бусад ижил төстэй салбар, ангилал, нөхцөл байдалд байгаа хувь хүмүүст олгодогтой ижил хамгаалалтыг олгох, ингэхдээ бараа бүтээгдэхүүний болон хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн асуудал болон угсаатны сегментчлэл, түүнчлэн хэл зүйн хүчин зүйлсийг харгалзан үзэх.

Гомдол барагдуулах механизм

27. Зээлдэгч нь ГШ.10-т дурдсан ёсоор төсөлд зориулан бий болгосон гомдол барагдуулах механизм нь уугуул иргэдэд соёлын хувьд зохистой, хүртээмжтэй байхад анхаарах ба шүүхэд хандах, маргаан шийдвэрлэх уламжлалт механизм байгаа эсэхийг харгалзан үзнэ. Энэ нь бичмэл журамд найдах бус, амаар мэдээлэх сувгуудыг түлхүү ашиглахад хүргэж болзошгүй.

Бусад анхаарах асуудлууд

28. Төслийг хэрэгжүүлэх явцад зээлдэгч нь уугуул иргэд болон зээлдэгчийн хооронд үүссэн бөгөөд төслийн гомдол барагдуулах механизмд хандсан ч шийдэгдээгүй байгаа аливаа зөрчил маргааны талаар ЕСБХБ-нд нэн даруй мэдэгдэх болно.
29. Төсөлтэй холбоотойгоор нутгийн уугуул иргэдэд учирсан эрсдэл, нөлөөллийг удирдахад төр тодорхой үүрэг гүйцэтгэдэг бол зээлдэгч нь уг ГШ-ийн зорилтуудад нийцсэн үр дүнд хүрэхийн тулд аль болох тухайн хариуцсан төрийн байгууллагатай тэдний зөвшөөрсөн хэмжээнд хамтран ажиллана. Түүнчлэн төрийн чадавх хязгаарлагдмал бол зээлдэгч үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах явцад идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 8: Соёлын өв

Танилцуулга

1. Энэхүү ГШ нь одоо болон ирээдүй хойч үедээ соёлын өвийг хадгалан үлдээхийн ач холбогдлыг чухалчлан авч үзсэн болно. ГШ-ын зорилго нь соёлын өвийг хамгаалах, мөн зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагааныхаа явцад соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх, бууруулах арга хэмжээг удирдан чиглүүлэх явдал юм. Зээлдэгч нь соёлын өвийн удирдлага, тогтвортой ашиглалтыг хангаж ажиллахдаа хянамгай хандах ёстой.
2. Соёлын биет болон биет бус өв нь нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал өв хөрөнгө бөгөөд соёлын өвөрмөц онцлог, уламжлалыг (үүнд, уламжлалт үр чадвар, мэдлэг, итгэл үнэмшил ба/буюу нутгийн аялга, хэл яриа зэрэг орно) таслалгүй тээн авч явахад чухал үүрэг гүйцэтгэдэг.
3. Соёлын өвийг хадгалах, хамгаалах зорилгыг биелүүлэхдээ энэхүү ГШ нь холбогдох олон улсын конвенц, бусад баримт бичгийг мөрдлөг болгоно. Түүнчлэн, төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй соёлын өвд хамаатай хууль, журам болон тухайн хүлээн авагч улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг бүх талууд хүндэтгэх хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд, соёлын өвийн эсвэл эртний эд зүйлсийн тухай хууль, төлөвлөлт буюу барилгын зөвшөөрлийн тухай хууль, дархан цаазтай газар болон тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, мөн барьж байгуулсан өвийн түүх, соёлын барилга байгууламжийн талаарх бусад хууль, журам, нутгийн уугуул иргэдийн соёлыг хамгаалахтай холбоотой хуулиуд орно. Нутгийн уугуул иргэдийг хамгаалах тухай дэлгэрэнгүй шаардлагуудыг ГШ.7-д тусгав.

Зорилт

4. Тус ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг дэмжих;
 - төслөөс үүдэлтэй сөрөг нөлөөллөөс соёлын өвийг хамгаалахдаа нөлөөллийг бууруулах шатлалын арга барилыг ашиглах;
 - бизнесийн үйл ажиллагаанд соёлын өвийг ашигласнаас олох үр ашгийг тэнцүү хуваах явдлыг хөхиүлэн дэмжих; болон
 - хэрэв соёлын өвийн томоохон элементүүд тодорхойлогдсон бол, соёлын өвийг ойлгох, үнэлэх, сайжруулахыг хөхиүлэн дэмжих, мөн орон нутгийн иргэдийн хүртэх нийгэм, эдийн засгийн боломжит үр өгөөжийг нэмэгдүүлэх.

Үйлчлэх хүрээ

5. Энэхүү ГШ нь Байгаль орчин, нийгмийн бодлогод заасанчлан ЕСБХБ-ны санхүүжүүлсэн бүхий л төсөлд үйлчилнэ. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээ гүйцэтгэх явцдаа уг ГШ-ын холбогдох шаардлагуудыг тодорхойлон тэдгээрийг зээлдэгчийн ерөнхий БОНУТО ба/буюу төслийн БОНУТ-ний салшгүй хэсэг болохын хувьд хэрхэн биелүүлэх талаар тусгана. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон удирдлагын шаардлагуудыг ГШ.1-т тусгасан болно. Түүнчлэн, хэрэв төсөл өмнө нь тодорхойлогдоогүй байсан соёлын өв (биет болон биет бус)-д нөлөөлөл үзүүлсэн эсвэл үзүүлж болзошгүй бол зээлдэгч төслийг хэрэгжүүлэхдээ энэхүү ГШ-ыг мөрдлөг болгоно.

6. Тус ГШ-ын зорилгоор соёлын өв гэдгийг хүмүүсийн хувьд хувьсан өөрчлөгдөж буй үнэт зүйл, итгэл үнэмшил, мэдлэг, уламжлалын тусгал ба илэрхийлэл хэмээн өмчлөлөөс хамааралгүйгээр тодорхойлсон өнгөрсөн үеэс өвлөгдөж ирсэн нөөц баялаг гэж тодорхойлов. Энэ нь орон нутгийн, бүсийн болон үндэсний түвшинд эсвэл олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд танигдсан биет болон биет бус соёлын өвөөс бүрдэнэ. Үүнд:
 - соёлын биет өвд хөдлөх болон үл хөдлөх объектууд, дурсгалт газар, бүтэц байгууламжийн бүлэг, түүнчлэн тэдгээртэй холбоотой соёлын болон ариун дагшин газрууд, мөн археологийн, угсаатны, палеонтологийн, түүхийн, архитектурын, шашны, гоо зүйн болон соёлын бусад үнэ цэн бүхий байгалийн онцлог хэв шинж, өвөрмөц тогтцууд орно;
 - соёлын биет бус өв гэдэгт нэг үе удмаас дараах үе удамд шилжин ирдэг, нутгийн иргэд, бүлгүүд болон зарим тохиолдолд хувь хүмүүс өөрсдийн соёлын өвийн нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрдөг дадал туршлага, төлөөлөл, илэрхийлэл, мэдлэг, үр чадварыг оруулан ойлгоно.
7. Төслийг боловсруулах явцад соёлын өвийн үнэ цэн эсвэл ач холбогдлыг илэрхийлсэн газар нутаг, эд зүйлс эсвэл соёлын уламжлал нь шууд болон шууд бусаар нөлөөлөлд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрснөөр төсөл нь дараах тохиолдлуудад энэхүү ГШ-ыг биелүүлнэ. Үүнд:
 - хэрэв том талбайг хамарсан газар малтлага, барилга байгууламж буулгах, хөрс сэндийлэх, үс зайлуулах, усаар дүүргэх болон физик орчинд оруулах бусад өөрчлөлтүүд багтаж байвал;
 - үйл ажиллагаа явуулж байгаа үлс орны хүлээн зөвшөөрсөн соёлын өвийн талбай дотор, эсвэл түүний ойролцоо байрлаж байгаа бол; ба/буюу
 - хүмүүс, тэр дундаа нутгийн уугуул иргэдийн биет бус соёлын өвд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй бол гэсэн тохиолдлууд тус тус орно.
8. Тус ГШ-ын заалтууд нь тухайн соёлын өв хуулиар хамгаалагдсан эсвэл өмнө нь хөндөгдөж байсан эсэхээс үл хамааран үйлчилнэ. Соёлын биет бус өвийн тухайд зөвхөн төслийн биет бүрэлдэхүүн хэсэг нь тэрхүү соёлын өвд материаллаг нөлөөлөл үзүүлэхээр бол, эсвэл төсөл нь тэрхүү соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглахыг зорьж байвал энэхүү ГШ-ийн заалтууд үйлчилнэ.

Шаардлага

Нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөх

9. Зээлдэгч төсөлтэй холбоотойгоор дараах зорилгоор бүх гол оролцогч талуудтай бүтээлчээр зөвлөлдөж, мэдээллээр хангана. Үүнд: (а) нөлөөлөлд өртөж болзошгүй соёлын өвийг тодорхойлох; (б) соёлын өв нь орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудад ямар ач холбогдолтойг ойлгох; (в) нөлөөлөл, эрсдлийг үнэлэх; (г) нөлөөллийг бууруулах шатлалын арга барилыг нэвтрүүлэх; мөн (д) олон нийтийн үр шим хүртэх боломжийг тодорхойлох. Оролцогч талуудыг тогтоох, бүтээлчээр зөвлөлдөхөд ГШ.10-ыг дагаж мөрдөх ба тогтоогдсон соёлын өвийг хамгаалагч болон гол ашиглагчдыг

оролцуулна. Ингэхдээ эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн иргэдийг хамруулах ёстой.

10. Зээлдэгч нь гол нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт болон бусад оролцогч талуудтай зөвшилцөх замаар соёлын өвтэй холбоотой мэдээллийг нийтэд задруулах нь тухайн соёлын өвийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг алдагдуулах эсэхийг тодорхойлно. Ийм нөхцөлд зээлдэгч соёлын өвийн талаарх мэдээллийг нууцлах бөгөөд нууц мэдээллийг олон нийтэд ил болгохоос татгалзаж болно.

Эрсдэл, нөлөөллийн үнэлгээ

11. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний эхний үе шатанд зээлдэгч төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй аливаа соёлын өв, тохиолдлын олдвор тааралдах магадлалыг тооцоолох үнэлгээ хийнэ. Ингэхдээ зээлдэгч холбогдох эрх бүхий байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудтай зөвлөлдөнө.
12. Үнэлгээгээр төслийн суурь мэдээлэл болон соёлын өвд үзүүлж болзошгүй эрсдэл, нөлөөллийг тодорхойлно. Үнэлгээний цар хүрээ нь нөлөөллийн далайц, магадлал, эрчим зэргийг тодорхойлох, мөн холбогдох гол оролцогч талуудын саналыг харгалзан үзэхэд хангалттай байх болно. Зээлдэгч соёлын өвд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөллийг бууруулах шатлалын арга барил болон ОУСТ-ын дагуу боловсруулж хэрэгжүүлнэ. Үнэлгээгээр төсөл нь соёлын өвд материаллаг эрсдэл, нөлөөлөл үзүүлж болохыг тогтоосон тохиолдолд зээлдэгч нь соёлын өвийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулахад тусалцаа авах зорилгоор боломжтой бол соёлын өвийн шинжээч(ид)-ийг ажиллуулна.
13. Зээлдэгч төсөлд хамаарах соёлын өвийн хээрийн судалгаа, баримтжуулалт, хамгаалалтын үйл ажиллагаанд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга туршлагыг нэвтрүүлэх бөгөөд гэрээгээр ажил гүйцэтгэгчид болон бусад гуравдагч этгээдүүд ч мөн тэрхүү арга туршлагыг нэвтрүүлсэн байна.

Тохиолдлын олдворын журам

14. Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх явцад соёлын биет өв гэж тодорхойлогдсон тохиолдлын олдвор санаандгүй олдсон үед авах арга хэмжээг зохицуулах дүрэм, журмыг боловсруулж, гэрээндээ зохих ёсоор тусгасан байна. Тус журамд олдсон эд зүйлс, газар талбайн тухай холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж, төслийн ажилтан, гэрээгээр ажил гүйцэтгэгчид, туслан гүйцэтгэгчдийн ажилтан, ажилчдад энэ төрлийн тохиолдлын олдвор олдсон тохиолдолд дагаж мөрдөх заавар журмын талаар сургалт зохион байгуулж, тухайн эд зүйлс олдсон газрыг эвдрэл, сүйдлээс сэргийлэх арга хэмжээг тусгана. Зээлдэгч соёлын өвийн мэргэжилтэн(-үүд)-ээр үнэлгээ хийлгэж, үндэсний хууль, тогтоомж болон энэ ГШ-д нийцэх арга хэмжээг тодорхойлох хүртэл аливаа тохиолдлын олдворыг эвдэж сүйтгэлгүй хадгална.

Хуулиар хамгаалагдсан бөгөөд олон улсад танигдсан газар нутаг

15. Хуулиар, эсвэл бусад хүчин төгөлдөр арга хэрэгслээр хамгаалагдсан ба/буюу олон улсад танигдсан, эсвэл тухайн улс орны засгийн газрын зүгээс хамгаалалтад авахаар санал болгосон газар нутагт орших соёлын өвд төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тохиолдолд зээлдэгч тэрхүү нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ авна. Нөлөөллөөс зайлсхийх боломжгүй бөгөөд өөр боломжит хувилбар байхгүй нөхцөлд зээлдэгч гагцүү дараах шаардлагыг биелүүлсэн үед төслийг үргэлжлүүлж болно. Үүнд:

- тухайн соёлын өвд хамаарах орон нутгийн, үндэсний болон олон улсын шаардлагуудыг хангасан байх;
- санал дэвшүүлж буй аливаа үйл ажиллагаа нь хуулиар зөвшөөрөгдсөн, энэ хүрээнд тусгай хамгаалалттай газар нутагт төслийн улмаас нөлөөлөл үүсэх эсэхийг тогтоох үнэлгээ хийгдсэн болохыг харуулах;
- соёлын өвийн үнэлгээ ба холбогдох удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх замаар засгийн газраас баримталж буй тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын төлөвлөгөөний зүйл заалтуудад нийцүүлэх;
- санал болгож буй төслийн талаар тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, холбогдох эрх бүхий байгууллага, орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудтай ГШ.10-т заасны дагуу зөвлөлдөх; мөн
- тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын төлөвлөгөөний дагуу тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах бүрэн эрхийг сурталчлах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг судалж, хөтөлбөр хэрэгжүүлэх.

Соёлын өвийг төслийн хүрээнд ашиглах

16. Хэрэв төсөл нь уламжлалт амьдралын хэв маягийг тээж буй орон нутгийн иргэдийн соёлын нөөц баялаг, мэдлэг, шинэ санаачилга эсвэл арга туршлагыг арилжааны зорилгоор ашиглах бол зээлдэгч нь эдгээр орон нутгийн иргэдэд: (i) үндэсний хууль тогтоомжоор олгогдсон тэдний эрх, (ii) санал болгож буй бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ, шинж чанар, (iii) тухайн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй үр дагаврын талаар цаг тухай бүрт нь мэдээлнэ. Зээлдэгч нь тэрхүү бизнесийн үйл ажиллагааг дараах нөхцлийг хангасан тохиолдолд л явуулна. Үүнд: (i) тухайн уламжлалт амьдралын хэв маягийг тээж буй нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд олон нийттэй сайн санааны хэлэлцээр байгуулах, (ii) тэдний мэдээлэлд сүүрилсэн оролцоог хангасан болон хэлэлцээр амжилттай болсныг баримтжуулах, (iii) тэдний мэдлэг, шинэ санаачилга эсвэл арга туршлагыг ёс заншил, уламжлалтай нь нийцсэн байдлаар бизнесийн үйл ажиллагаандаа ашигласнаас олсон үр шимийг нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд шударга, тэнцүү хуваариалан хүртээх. Төсөл нутгийн уугуул иргэдийн соёлын баялаг, мэдлэг, шинэ санаачилга, эсвэл арга туршлагыг ашиглахыг санал болговол ГШ.7-д заасан шаардлагуудыг хангасан байна.
17. Зээлдэгч төслийн нөлөөлөлд өртсөн соёлын хөдлөх өвийн хулгай, наймаанаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авч, хэрэв тийм тохиолдол гарвал холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 9: Санхүүгийн зуучлагчид

Танилцуулга

1. Энэхүү ГШ-д Санхүүгийн зуучлагчид (СЗ) нь тогтвортой санхүүгийн зах зээлийг хөхиүлэн дэмжих гол хэрэгсэл бөгөөд хөрөнгө санхүүжилтийг бичил болон жижиг, дунд үйлдвэрлэл (БЖДҮ)-ийн салбар руу татан чиглүүлэх механизм болохыг онцлон тэмдэглэсэн. СЗ дотор янз бүрийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид, тухайлбал хувийн хөрөнгө оруулалтын сан, банк, лизингийн компани, даатгалын компани болон тэтгэврийн сангууд ордог.
2. Зуучлалын санхүүжилтийн мөн чанар нь СЗ байгаль орчин, нийгмийн үнэлгээ, эрсдлийн удирдлага, хяналт шинжилгээ, түүнчлэн үнэт цаасны багцын ерөнхий удирдлагын үүргийг төлөөлөн хариуцна гэсэн үг юм. Санхүүжилтийн ямар хэлбэрийг ашигласан зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамааран тухайн төлөөллийн шинж чанар нь өөр өөр байж болно. СЗ-ын байгаль орчин, нийгмийн эрсдлийн удирдлагын арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид тогтмол үнэлгээ өгч, хяналт шинжилгээ хийнэ.

Зорилт

3. Уг ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - СЗ өөрийн санхүүжүүлдэг дэд төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг хэрхэн үнэлж, удирдахыг төлөвлөх;
 - СЗ-ын санхүүжүүлсэн дэд төслүүдэд байгаль орчин, нийгмийн удирдлагын сайн туршлагыг нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжих;
 - СЗ-ын дунд байгаль орчин, хүний нөөцийн зөв, зохистой удирдлагыг хөхиүлэн дэмжих.

Үйлчлэх хүрээ

4. Тус ГШ-ын зорилгын үүднээс “дэд төсөл” гэж СЗ-ын төслийн хүрээнд ЕСБХБ-наас олгосон хөрөнгийг ашиглан СЗ-аас санхүүжүүлэх боломжтой хөрөнгө оруулалт, эсвэл үйл ажиллагааг хэлнэ.
5. Тус ГШ-ын шаардлагууд нь бүх дэд төслүүдэд үйлчилнэ.
6. ЕСБХБ-наас олгосон санхүүжилт нь тодорхой дэд төслүүдэд хүрсэн эсэх нь тодорхойгүй шууд хөрөнгө оруулах гэх мэт замаар компанийн ерөнхий санхүүжилтийг хамрах тохиолдолд энэхүү ГШ-ын шаардлагууд нь СЗ-ын ирээдүйн дэд төслүүдэд бүгдэд нь үйлчилнэ.
7. Хэрэв дэд төслүүдээс байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэл, сөрөг нөлөөлөл хамгийн бага буюу огт байхгүй бол СЗ нь байгаль орчин, нийгмийн эрсдлийн удирдлагын зарчмыг авч хэрэгжүүлэх шаардлагагүй.
8. ЕСБХБ нь СЗ, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааны мөн чанар, хөрөнгө оруулалтын багц ба дэд төслүүдэд нь холбогдох байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн түвшин, үйл ажиллагаа явуулж буй улс орны онцлогоос хамаарч байгаль орчин, нийгмийн нэмэлт эсвэл өөр шаардлагыг зохих хэмжээнд авч хэрэгжүүлэхийг СЗ-аас шаардаж болно. Тийм нэмэлт эсвэл өөр шаардлагыг ЕСБХБ-наас хөрөнгө оруулалт хийх үед ЕСБХБ ба СЗ нарын хооронд харилцан тохиролцох байгаль орчин, нийгмийн нарийвчилсан журамд тусгана.

Шаардлага

СЗ-ын байгууллагын чадавх

9. СЗ нь ГШ.2 (Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрийн нөхцөл)-ын дагуу хүний нөөцийн бодлого, удирдлагын тогтолцоогоо бэхжүүлж, ГШ.4 (Эрүүл мэнд, аюулгүй байдал ба хамгаалалт)-д заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох шаардлагуудад нийцүүлнэ. Эдгээ рарга хэмжээний талаар СЗ-ын ажилтан, ажилчдад мэдэгдэнэ.
10. СЗ нь байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн асуудлуудыг бүхэлд нь зохицуулах, түүний дотор энэхүү ГШ болон ГШ.2, мөн ГШ.4-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбох шаардлагуудын хэрэгжилтийг хариуцах нэг ба түүнээс дээш тооны төлөөлөгчийг дээд шатны удирдлага дотроос томилно. Тэрхүү хариуцсан дээд шатны удирдлагын төлөөлөгч (-ид) нь: (i) байгаль орчин, нийгмийн шаардлагын өдөр тутмын хэрэгжилтийг хариуцсан, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажилтныг томилно; (ii) байгаль орчин, нийгмийн асуудлаарх сургалтын хэрэгцээ, сургалтад шаардагдах төсвийг тодорхойлно; (iii) байгаль орчин, нийгмийн томоохон эрсдэл, сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй дэд төслийн үнэлгээг хийж, удирдахад зохих техникийн мэдлэг, туршлагатай мэргэжилтнүүдийг байгууллага дотроосоо эсвэл гаднаас хөлсөлж ажиллуулна.
11. СЗ нь өөрийн байгууллагын мөн чанар, дэд төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдлийн түвшинд нийцсэн байгаль орчин, нийгмийн бодлого болон байгаль орчин, нийгмийн журам бүхий тодорхой байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо (БОНУТ)-г бий болгоно.
12. Хэрэв СЗ нь БОНУТ-той гэдгээ нотолж чадах бол тухайн БОНУТ байгааг зохих баримтаар нотлон харуулах шаардлагатай. БОНУТ-г бий болгох, сайжруулах шаардлагатай тохиолдолд СЗ нь энэ чиглэлд авах арга хэмжээний төлөвлөгөөг ЕСБХБ-тай хэлэлцэн тохиролцоно.
13. Байгаль орчин, нийгмийн журамд эрсдлийн үнэлгээ ба хяналт шинжилгээний механизмыг дараах зорилгоор тусгасан байна. Үүнд:
 - бүх зээлдэгч/дэд төслийг ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)-ын баримт бичгийн Хавсралт 1 дэх Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалт болон уг ГШ-ын Хавсралт А дахь СЗ-ын Лавлагаа жагсаалтад багтсан үйл ажиллагааг явуулж байгаа эсэхийг шалгах;
 - санал болгосон дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдлийг (бага/дунд/өндөр) СЗ-д зориулсан ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн эрсдлийн ангиллын жагсаалтын дагуу ангилах;
 - үнэлгээгээр дамжуулан дэд төслүүд нь байгаль орчин, нийгмийн асуудлууд, тэр дундаа хэрэв шаардлагатай бол олон нийтийн хэлэлцүүлэг хийх, мэдээллийг ил тод болгохтой холбоотой үндэсний хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагад нийцүүлэн зохион байгуулагдсан эсэхийг баталгаажуулж, шаардлагатай бол засаж залруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг зээлдэгчээс шаардах;
 - дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн асуудлын талаарх мэдээллийг тогтмол шинэчилж байх;

- дэд төслүүдийг байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үндэсний хууль тогтоомжид нийцсэн байлгах үүднээс хяналт шинжилгээ хийх.
14. СЗ нь ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогын Хавсралт 2-т заасан “А” ангиллын төслийн жагсаалтын шалгууруудыг хангасан дэд төслүүдийг санхүүжүүлж байгаа нөхцөлд тэдгээр дэд төслүүд нь ГШ.1-ГШ.8 болон ГШ.10-ыг хангасан байх ёстой.
 15. Энэхүү ГШ-ын Хавсралт А-д харуулсан СЗ-ын лавлагаа жагсаалт нь байгаль орчин, нийгмийн хувьд нэн өндөр эрсдэлтэй олон тооны үйл ажиллагааг багтаасан. Тус ГШ-ын Хавсралт А-д жагсаасан үйл ажиллагааг агуулсан дэд төсөл байвал СЗ тэрхүү дэд төслийг ЕСБХБ-нд хянуулахаар хүргүүлнэ.

Оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаа

16. СЗ нь байгаль орчин, нийгмийн асуудлаарх гадаад харилцаа холбоог зохицуулах тогтолцоог бүрдүүлнэ. СЗ нь аливаа санал хүсэлтэд тухай бүр, шүүрхай хариу өгнө. Мөн СЗ нь байгаль орчин, нийгмийн асуудлаарх компанийн бодлого, эсвэл өөрийн БОНУТо-ны талаарх тойм мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан (хэрэв байгаа бол) олон нийтэд танилцуулж байх нь зүйтэй. Мөн бололцоотой тохиолдолд өөрийн санхүүжүүлж буй “А” ангиллын дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-ний тайланг олон нийтэд нээлттэй байршуулсан холбоосыг цахим хуудсандаа тавина. Мөн СЗ нь тус ГШ-ын 15-д заасны дагуу ЕСБХБ-нд хянуулахаар хүргүүлсэн дэд төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл болон тэдгээр эрсдлийг бууруулахаар санал болгож буй арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлнэ. Энэ нь холбогдох зохицуулалтын хязгаарлалт, зах зээлийн мэдрэмж, дэд төслийн ивээн тэтгэгчийн зөвшөөрлөөс хамаарна.

ЕСБХБ-нд тайлагнах

17. СЗ нь БОНУТо, үг ГШ ба ГШ.2, мөн ГШ.4-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагуудын хэрэгжилт, түүнчлэн дэд төслүүдийн багцын байгаль орчин, нийгмийн арга хэмжээний гүйцэтгэлийн талаарх жил тутмын тайланг ЕСБХБ-ны зөвшөөрсөн хэлбэрээр хүргүүлнэ.

Хавсралт А: СЗ-ын лавлагаа жагсаалт

Доорх үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх тохиолдолд СЗ нь төслийг ЕСБХБ⁹⁶ -нд хянуулахаар хүргүүлнэ. Үүнд:

- (i) Албадан нүүлгэн шилжүүлэхэд хүргэдэг үйл ажиллагаа – *ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 5*
- (ii) Хуулиар хамгаалагдсан ба/буюу олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үндэсний засгийн газраас ийм статус олгохоор санал болгосон нутаг дэвсгэрт явагдаж байгаа, эсвэл тийм нутаг дэвсгэр, чухал амьдрах орчин, биологийн тэргүүлэх чухал төрөл зүйлийг дэмждэг бусад экотогтолцоо, шинжлэх ухааны хувьд сонирхолтой газрууд, ховор/нэн ховор амьтан ургамлын амьдрах орчин, эдийн засгийн ач холбогдолтой загас үржүүлэг, эсвэл экологийн ач холбогдол бүхий анхдагч/хөгширсөн ойд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой үйл ажиллагаа – *ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6*
- (iii) Эрчимжсэн мал аж ахуйг хамарсан үйл ажиллагаа – *ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6*
- (iv) Малын бэлчээр, ан ав, загас агнуур гэх мэт амьжиргааны зориулалтаар ашиглаж буй газар, гол горхи зэрэг үүгүүл иргэд ба/буюу эмзэг бүлгийн иргэдийн эзэмшиж, оршин суудаг газарт, түүний зэргэлдээ, эсвэл түүний дээгүүр байрлах хэсэгт явагдаж буй үйл ажиллагаа – *ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 7*
- (v) Соёлын эсвэл археологийн хувьд чухал ач холбогдолтой газар нутаг, байршилд сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа – *ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 8*
- (vi) ГХӨО-ыг байгаль орчинд гаргахад хүргэж болзошгүй үйл ажиллагаа – *ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6*
- (vii) “А” ангиллын шаардлагыг хангаагүй аливаа бичил, жижиг эсвэл дунд оврын УЦС – *ЕСБХБ-ны Жижиг усан цахилгаан станцын төслүүдэд тавигдах шалгуур*
- (viii) ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогын Хавсралт 2-т багтсан “А” ангиллын төсөл

⁹⁶ Санал болгож буй ажил гүйлгээний хувьд хангасан байх шаардлагатай үндсэн Гүйцэтгэлийн Шаардлагыг налуу үсгээр бичсэн.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 10: Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоог хангах

Танилцуулга

1. Энэхүү ГШ-д зээлдэгч, түүний ажилтан, ажилчид, тэдгээрийн төлөөлөгчид, төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд болон хувь хүмүүс, мөн шаардлагатай бол бусад оролцогч талуудын хоорондох нээлттэй, ил тод хамтын ажиллагаа, оролцоо нь ОУСТ ба компанийн нийгмийн хариуцлагын зайлшгүй байх бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд маш чухал хэмээн үзэж байна. Талуудын оролцоог хангах нь тухайн төслийн байгаль орчин, нийгмийн болон ерөнхий тогтвортой байдлыг сайжруулах нэг арга зам юм. Ялангуяа, төслийн цар хүрээ, мөн чанарт тохирсон үр дүнтэй олон нийтийн оролцоо нь төслийн байгаль орчин, нийгмийн асуудлаарх зөв, тогтвортой гүйцэтгэлийг дэмжих ба санхүүгийн, нийгмийн болон байгаль орчны чиглэлд үр дүнг сайжруулан, олон нийтийн хүртэх үр ашгийг нэмэгдүүлнэ.
2. Талуудын оролцоо нь төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг амжилттай удирдахад зайлшгүй шаардлагатай бат бэх, бүтээлч, найрсаг харилцаа холбоог тогтооход чухал юм. Энэ нь тэгш оролцоог хангасан, тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд төслийн хэрэгжилтийн эхэн үед санаачилбал хамгийн үр дүнтэй байдаг, төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага, хяналт шинжилгээний салшгүй хэсэг болно.

Зорилт

3. Тус ГШ нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - зээлдэгчид оролцогч талуудтай бүтээлч харилцаа тогтооход тус дөхөм болох талуудын оролцоог хангах системтэй арга аргачлалыг тодорхойлох;
 - төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд төслийн оролцогч талуудыг үйл ажиллагаанд үр дүнтэй, тэгш хамран оролцуулах арга хэрэгслээр хангах;
 - байгаль орчин, нийгмийн талаар зохих мэдээллийг төслийн оролцогч талуудад хүргэх, тэдэнтэй бүтээлчээр зөвлөлдөх, мөн тийнхүү зөвлөлдөх явцад гарсан санал дүгнэлтүүдийг харгалзан үзэх;
 - оролцогч талуудын санал гомдолд хариу өгч зохих ёсоор шийдвэрлэж байгаа эсэхийг хянах.

Үйлчлэх хүрээ

4. Энэхүү ГШ нь бүх төсөлд хамаарна. Төсөл болгон ядаж оролцогч талуудыг тодорхойлох, гомдол барагдуулах механизмыг бий болгох, хэрэгжүүлэх арга хэмжээ авна. Тус ГШ-д заасанчлан цаашид талуудын оролцоог төслийн шинж чанар, цар хүрээ, оролцогч талууд, байгаль орчин эсвэл нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийн хэмжээнд нийцүүлэн хангана.

5. Зээлдэгч нь ГШ.1-т заасны дагуу төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, БОНУТо болон БОНУТө-ний хүрээнд оролцогч талуудыг тодорхойлж, тэдний оролцоог хангана. Энэхүү ГШ-ыг ажилтан, ажилчдын оролцооны тухай ГШ.2 болон онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний үед оролцоог хангах тухай ГШ.4-ийн шаардлагуудтай үйлдүүлэн ойлгоно. Нутгийн үүгүүл иргэдийг албадан нүүлгэн суурьшуулах, эсвэл эдийн засгийн агуулгаар нүүлгэн шилжүүлэхэд хүргэх, эсвэл соёлын өвд сөрөг нөлөөлөл үзүүлэх үр дагавартай төслийн хувьд зээлдэгч ГШ.5, ГШ.7 ба ГШ.8-д заасан мэдээллийг ил тод болгох, зөвлөлдөх тусгай шаардлагуудыг биелүүлнэ.

Шаардлага

6. Талуудын оролцоог хангах ажил дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: оролцогч талуудыг тодорхойлох болон дүн шинжилгээ хийх, талуудын оролцоог хангах төлөвлөгөөг боловсруулах, мэдээллийг ил тод болгох, бүтээлчээр зөвлөлдөх, гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх, мөн холбогдох талуудад тогтмол тайлагнах.
7. Зээлдэгч нь оролцогч талуудын оролцоог хангахдаа цаг үеийн, тэдэнд хамааралтай, ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллийг бүтээлчээр, үр дүнтэй, тэгш оролцоог хангасан, соёлын хувьд зохистой байдлаар хүргэх, аливаа мушгин гуйвуулах, хөндлөнгөөс нөлөөлөх, албадах, айлган сүрдүүлэх, өс хонзон авахаас ангид байдлаар зохион байгуулна.
8. Талуудын оролцоог хангах ажил нь төслийг боловсруулах шатанд аль болох эрт эхлэх бөгөөд төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд тасралтгүй үргэлжилнэ. Төслийг боловсруулах бүх үе шатан дахь талуудын оролцооны агуулга, давтамж нь төслийн мөн чанар, цар хүрээ болон түүний байгаль орчин, эсвэл нийгэмд үүсгэж болзошгүй эрсдэл, эсвэл нөлөөлөл, оролцогч талуудын ашиг сонирхлын түвшинтэй үялдсан байна. Зээлдэгч нь олон нийтэд мэдээлэл хүргэх, хэлэлцүүлэг өрнүүлэх талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох шаардлага болон хүлээн авагч улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах хууль тогтоомжид нийцүүлнэ.
9. Зээлдэгч нь талуудын оролцоог хангах үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт шинжилгээг хариуцан ажиллах боловсон хүчнийг тохоон томилж, тэдний үүрэг, хариуцлага, бүрэн эрхийг нарийн тодорхойлно.

Төслийн бэлтгэл шатан дахь талуудын оролцоо

Оролцогч талуудыг тодорхойлох нь

10. Зээлдэгч нь оролцогч талуудыг тодорхойлж, баримтжуулах бөгөөд тэдгээр нь: (i) төслийн нөлөөлөлд (шууд болон шууд бусаар) өртсөн, эсвэл өртөж болзошгүй (нөлөөлөлд өртсөн талууд), эсвэл (ii) төсөлд сонирхолтой байж мэдэх (бусад сонирхогч тал) хувь хүн ба бүлгүүд байна.

11. Зээлдэгч нь өөрсдийн тодорхой нөхцөл байдлаасаа шалтгаалан сул дорой эсвэл эмзэг байдалтай байж болох төслийн нөлөөлөлд өртсөн талууд (хувь хүн ба бүлгүүд)-ыг тодорхойлно. Энэхүү тодорхойлто дээр үндэслэн зээлдэгч нь цаашид төслийн нөлөөлөл, түүнийг бууруулах механизм, үр шимийн талаар янз бүрийн хөндөх асуудал, тэргүүлэх чиглэлтэй, мөн оролцоо нь өөр өөр, тусдаа хэлбэртэй байхыг шаардсан хувь хүмүүс ба бүлгүүдийг тодорхойлно. Төслийн хувьд тохиромжтой талуудтай харилцах арга зарчмыг сонгохын тулд оролцогч талуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх явцад тухайн оролцогч талуудын талаарх нарийвчилсан мэдээллийг цуглуулсан байвал зохино.

Талуудын оролцоог хангах төлөвлөгөө

12. Байгаль орчны ба/буюу нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төслийн хувьд зээлдэгч эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээ, төслийн хэрэгжилтийн үе шатанд нийцсэн талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ) боловсруулж хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) хийх шаардлагатай аливаа төслийн хувьд ТОХТ нь тус ГШ-ын 22-26-д заасан “А” ангиллын төслүүдэд тавигдах мэдээллийг ил тод болгох, зөвлөлдөх шаардлагыг тусгасан байна.
13. ТОХТ-нд төслийн төчлөгийн хугацаанд талуудтай хэрхэн хамтран ажиллах арга барил, тухайлбал оролцооны арга, цаг хугацаа, нийтэд ил болгох мэдээлэл, түүнийг түгээх хэл (нүүд) болон талуудаас авах мэдээллийн төрлийг заасан байна. Төслийн нөлөөлөлд өртсөн тал болон бусад сонирхогч талуудын үндсэн шинж (хүйс оролцуулан) ба ашиг сонирхлыг харгалзан, тус бүрт нь тохирсон оролцооны янз бүрийн түвшин, аргуудыг хооронд нь ялгаж зорилгоор ТОХТ-нд өөрчлөлт оруулна. ТОХТ хэр нарийвчлалтай байхыг тухайн төслийн онцлогоос хамаарч шийднэ. Талуудын оролцоог хангахад зориулсан боломжит санхүүжилтийг ТОХТ-нд тусгана. Төслийн явцад шаардлагатай бол ТОХТ-нд өөрчлөлт оруулна.
14. Талуудын оролцоо нь олон нийтийг төлөөлж буй төлөөлөгчдөөс⁹⁷ ихээхэн хамаарч байгаа тохиолдолд, зээлдэгч нь төлөөлөгч тухайн нөлөөлөлд өртсөн олон нийтийн санаа бодлыг бодитоор төлөөлж чадаж байгаа эсэх, мөн төлөөлж буй олон нийтдээ мэдээллийг түгээх болон тэдний санал хүсэлтийг зээлдэгч эсвэл эрх бүхий байгууллагад хүргэх замаар харилцаа холбоог зөвөөр чиглүүлж байгаа эсэхийг хянаж ажиллана.
15. Хэрэв талуудын оролцоог хангах үүрэг, хариуцлагыг холбогдох эрх бүхий байгууллага хүлээж байгаа тохиолдолд зээлдэгч нь энэхүү ГШ-д нийцсэн үр дүнд хүрэх зорилгоор тухайн хариуцсан төрийн байгууллагатай зохих хэмжээнд хамтран ажиллана. Дотоодын зохицуулалт болон тус ГШ-ын хооронд зөрүү байвал зээлдэгч нь албан ёсны зохицуулалтыг дэмжих зорилгоор талуудын оролцоог хангах нэмэлт арга хэмжээг тодорхойлж, шаардлагатай үед тэдгээрийг хэрэгжүүлэх үүрэг амлалт авна.
16. Төслийн байршил тодорхойгүй тохиолдолд ТОХТ нь зээлдэгчийн БОНУТО-ны нэг хэсэг болох зохицуулалтын хүрээ хэлбэртэй байх бөгөөд төслийн байршил тодорхой болмогц үг ГШ-ын дагуу хэрэгжих талуудыг тодорхойлох ерөнхий зарчим ба стратеги, мөн тэдний оролцоог хангах арга хэмжээний төлөвлөгөөг тусгасан байна.

17. Олон газарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ерөнхий корпорацын санхүү, эргэлтийн хөрөнгө эсвэл шууд хөрөнгө оруулалт бүхий төсөл хэрэгжүүлдэг зээлдэгч нь корпорацын түвшний ТОХТ-г авч хэрэгжүүлнэ. Корпорацын ТОХТ нь зээлдэгчийн бизнес, түүнээс үүдэлтэй байгаль орчин, эсвэл нийгэмд учирч буй эрсдэл, нөлөөлөл, мөн оролцогч талуудын сонирхлын түвшинтэй уялдсан байна. ТОХТ-г нийт үйлдвэрлэлийн байгууламжуудад цаг хугацаа алдалгүй түгээн хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөнд байгууламж тус бүрт талуудын оролцоог бүрэн хангах, тухайн байгууламжийн ойр байх талууд холбогдох байгаль орчин, нийгмийн асуудал хэрхэн шийдвэрлэгдсэн болон гомдол барагдуулах механизмын талаар мэдээлэл авдаг байх нөхцлийг бүрдүүлэх журам, хөрөнгө эх үүсвэрийг багтаасан байна.

Мэдээллийг ил тод болгох

18. Төсөл нь байгаль орчин, нийгэмд нөлөөлөл үзүүлэх бол зээлдэгч нь оролцогч талуудад төслийн эрсдэл, нөлөөлөл, боломжуудын талаар ойлголт авахад тус дөхөм болох зорилгоор төслийн холбогдох мэдээллийг ил тод болгоно. Зээлдэгч нь оролцогч талуудыг дараах мэдээллээр хангана. Үүнд:
- төслийн зорилго, мөн чанар, хамрах хүрээ болон үргэлжлэх хугацаа;
 - оролцогч талуудад учирч болзошгүй эрсдэл, нөлөөлөл, мөн эмзэг өртөмхий бүлгүүдэд харьцангуй ихээр учирч болох эрсдэл, нөлөөллийг онцолж, тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүдийг ялгаж салгасан, нөлөөллийг бууруулахаар санал болгож буй төлөвлөгөө;
 - талуудын оролцоог хангахаар төлөвлөсөн үйл явц, олон нийтийн оролцоо боломж, арга замууд;
 - төлөвлөж буй аливаа олон нийтийн зөвлөлдөх уулзалтууд, уулзалт болох газар, цаг, уулзалтын тухай мэдэгдэх, нэгтгэн дүгнэх болон тайлагнах үйл явц;
 - аливаа санал, гомдлыг барагдуулах үйл явц.

Дээрх мэдээллийг тухайн орон нутгийн иргэдийн ярьдаг хэл (-үүд) дээр, ойлгоход хялбар, соёлд нь нийцсэн хэлбэрээр түгээнэ. Ингэхдээ төслийн нөлөөлөлд ялгаатай байдлаар эсвэл хамгийн ихээр өртсөн бүлэг, хүн амын дундах мэдээллийн тусгай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээл, бичиг үсгийн боловсрол, хүйс, хөдөлгөөнт байдал, хэлний ялгаа, эсвэл мэдээллийн хүртээмжийн ялгаа) бүлгийн хэрэгцээг харгалзан үзнэ. Шаардлагатай, мөн соёлын хувьд зохистой бол, мэдээллийг нийтэд ил тод болгоход айлган сүрдүүлэх, албадах, мушгин гуйвуулахаас зайлсхийх зорилгоор гуравдагч этгээдийг хөлслөн ажиллуулж болно.

Бүтээлчээр зөвлөлдөх

19. Зээлдэгч нь төслийн эрсдэл, сөрөг нөлөөллийн мөн чанар, цар хүрээ болон оролцогч талуудын сонирхлын түвшинд үндэслэн бүтээлчээр зөвлөлдөх арга хэмжээ авна. Хэрэв зээлдэгч ийм үйл явцад аль хэдийн оролцсон бол тэр тухай нотлох хангалттай баримтыг гаргаж өгнө.
20. Бүтээлчээр зөвлөлдөх нь дараах шинжүүдийг агуулсан хоёр талт үйл явц юм. Үүнд:

⁹⁷ Жишээлбэл, олон нийт, шашны тэргүүнүүд, орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид, иргэний нийгмийн төлөөлөл, улс төрчид, багш нар ба/буюу нэг болон түүнээс дээш нөлөөлөлд өртсөн бүлгийг төлөөлж буй бусад этгээд.

- төслийн саналын тухай анхны сэтгэгдлийг сонсох, төслийн загвар боловсруулах мэдээлэл цуглуулахын тулд төслийн төлөвлөлтийн үйл явцын эхэн үеэс эхэлсэн байх;
 - байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, бууруулах чиглэлд талуудын зүгээс оролцох, төслийн явцыг мэдээллээр хангах нэг арга зам тул талуудын санал хүсэлт гаргахыг дэмжсэн;
 - тасралтгүй үргэлжилдэг;
 - хамаарах, ил тод, бодит, авахад хялбар мэдээллийг талуудтай зөвшилцөх боломжит хугацаанд урьдчилан ил тод болгох, түгээхэд үндэслэсэн;
 - холбогдох нутгийн хэл(-үүд)-ээр, соёлын хувьд зохистой, оролцогч талуудад ойлгомжтой бөгөөд тэдний шийдвэр гаргах үйл явцыг харгалзан үзсэн хэлбэрээр зохион байгуулагдсан;
 - санал хүсэлтэд анхаарал хандуулж, хариу өгдөг;
 - эмзэг өртөмхий бүлгийн иргэд зэрэг төслийн нөлөөлөлд өртсөн талуудын оролцоог хангах идэвхитэй, тэгш хамруулсан үйл ажиллагааг дэмжсэн;
 - гаднаас мушгин гуйвуулах, нөлөөлөх, албадах, алагчлах, айлган сүрдүүлэх, өс хонзон авахаас ангид;
 - зээлдэгчийн зүгээс баримжтуулсан байх.
21. Зээлдэгч олон нийтийн зөвлөлдөх үүлзалтад оролцсон талуудад төслийн талаар гаргасан эцсийн шийдвэр, түүнтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ, орон нутгийн иргэдийн төслөөс хүртэх үр шим, тухайн шийдвэрийг гаргах болсон үндэслэл, шалтгааны талаар мэдээлнэ. Үүнд оролцогчдоос ирүүлсэн санал хүсэлтийн хураангуй, тэдгээрийг хэрхэн харгалзан үзсэн, эсвэл авч хэлэлцээгүй тухай товч тайлбар, гомдол барагдуулах механизмын талаарх мэдээлэл багтана.
- “А” ангиллын төслийн мэдээллийг ил болгох болон зөвлөлдөх**
22. “А” ангилалд багтсан төслүүд нь зээлдэгчдийг төсөл ямар шатандаа явааг харгалзан, БОННУ-ний үе шат бүрт агуулагдах албан ёсны, оролцоонд суурилсан мэдээллийг ил болгох, зөвлөлдөх үйл ажиллагаа явуулахыг шаардана. Энэхүү үйл ажиллагаанд зээлдэгчдийг нөлөөлөлд өртсөн талуудын зүгээс ирүүлсэн, тэдэнд шууд нөлөөлж буй асуудлын талаарх санал бодлыг нь шийдвэр гаргах үйл явцдаа тусгахад хүргэх зохион байгуулалттай, тодорхой давтамжтай зөвшилцөх үйл явц багтана.
23. Зээлдэгч БОННУ-ний явцад үнэлэх гол эрсдэл, нөлөөллийг эхний шатанд урьдчилан тодорхойлохын тулд БОННУ-ний судалгаандаа талуудыг татан оролцуулна. Урьдчилсан судалгааны ажлын хүрээнд оролцогч талуудыг ТОХТ болон бусад баримт бичигт санал, зөвлөмж өгөх бололцоогоор хангана.
24. Зээлдэгч нь БОННУ ба ТОХТ-нөөс гадна төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) болон техникийн бус хураангуй тайлан (ТБХТ)-г нийтэд ил болгоно⁹⁸. Холбогдох удирдлагын төлөвлөгөөнүүдийг ГШ-д заасан болон Банктай тохиролцсон ёсоор нийтэд ил болгоно.
25. Зөвлөлдөх, нийтэд ил болгох үйл явц нь үндэсний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай болон бусад холбогдох хуулийн шаардлагад нийцсэн байх хэрэгтэй. Зээлдэгч БОННУ-ний тайланг төслийн мөчлөгийн туршид олон нийтэд нээлттэй байлгахын зэрэгцээ тайланд үе үе нэмэлт өөрчлөлт оруулж болох ба төсөл дууссаны дараа олон нийтээс мэдээлэлтэй танилцах хүсэлт ирэх бүрт гаргаж өгөх нөхцөлтэйгөөр архивлах ёстой.
26. Зээлдэгч нь оролцогч талуудад байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааныхаа талаар тогтмол тайлагнах ёстой. Энэхүү тайлан нь нөлөөлөлд өртсөн талуудад хүртээмжтэй, хэвлэмэл болон цахим хэлбэртэй, эсвэл ТОХТ-нд заасан хэмжээнд дэлгэрэнгүй байна. Тайланг холбогдох талуудын санал, хүсэлтэд нийцүүлэн жилд нэгээс багагүй удаа гаргана.
- Төсөл хэрэгжих хугацаанд оролцоог хангах болон гадагшаа тайлагнах**
27. Төсөл хэрэгжих хугацаанд зээлдэгч нь холбогдох талуудыг мэдээллээр тогтмол хангана. Мэдээллийн агуулга, давтамж, хүргэх аргачлал нь төслийн мөн чанар, түүний байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл, сөрөг нөлөөлөл болон оролцогч талуудын төслийн талаарх сонирхлын түвшинд нийцсэн байна. Төслийн гол үе шатуудад, мөн мэдээллийг ил болгох, зөвлөлдөх үйл явц, гомдол барагдуулах механизмаар дамжуулан тогтоосон талуудын санааг зовоож буй асуудлуудын тухайд зарим нэмэлт мэдээллийг нийтэд ил болгох хэрэгцээ үүсэж болно.
28. Боломжтой бол зээлдэгч нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүнгийн тухайд нөлөөлөлд өртсөн талуудаас санал авна. Нөлөөлөлд өртсөн олон нийтэд ихээхэн эрсдэлтэй эсвэл сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төслүүдийн хувьд зээлдэгч нь талуудын ашиг сонирхлын түвшинд нийцүүлэн ГШ.1-т заасан байгаль орчин, нийгмийн хяналт шинжилгээний үйл ажиллагаанд оролцохоор олон нийтийн төлөөлөл болон бусад холбогдох талуудыг татан оролцуулж болно.
- Гомдол барагдуулах механизм**
29. Зээлдэгч нь төсөлтэй холбоотойгоор талуудын санааг зовоосон асуудлыг мэдэж, цаг тухайд нь хариу өгөх ёстой. Энэ зорилгоор зээлдэгч нь талуудын санааг зовоож буй асуудал, ялангуяа зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг төсөл хэрэгжүүлэх явцад аль болох эрт бий болгосон байна. Гомдол барагдуулах механизм нь төслийн эрсдэл, үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээтэй уялдсан байна. Үүнд:
- гомдол барагдуулах механизм нь асуудлыг шуурхай, үр дүнтэй, соёлын хувьд зохистой, ил тод байдлаар, аливаа мушгин гуйвуулга, хөндлөнгийн нөлөө, албадлага, айлган сүрдүүлэг ба шийтгэлээс ангид, нөлөөлөлд өртсөн бүх талуудад хүртээмжтэй, үнэ

⁹⁸ ЕСБХБ-ны Мэдээллийн хүртээмжийн бодлогод Банк “А” ангиллын төслийн БОННУ-г хувийн хэвшлийн төслийн хувьд Захирлуудын Зөвлөл хэлэлцэхээс хуанлийн 60 хоногийн өмнө, төрийн хариуцсан төслийн хувьд Захирлуудын Зөвлөл хэлэлцэхээс хуанлийн 120 хоногийн өмнө нийтэд ил болгоно гэж заасан.

төлбөргүйгээр шийдвэрлэнэ. Уг гомдол барагдуулах механизм нь шүүх эсвэл захиргааны арга хэмжээ авахад саад болох ёсгүй. Зээлдэгч нь талуудын оролцоог хангахдаа тэдэнд гомдол барагдуулах механизмын тухай мэдэгдэж, өртсөн хүмүүсийн хувийн нүүцыг хамгаалан, хэрэгжилтийн талаар олон нийтэд тогтмол тайлагнана;

- санал гомдлыг соёлын хувьд зохистой хэлбэрээр, хянуур, бодитой, мэдрэмжтэй, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангахуйц байдлаар барагдуулна. Мөн уг механизм нь гомдол гаргах, шийдвэрлүүлэхдээ нэрээ нууцлах боломжийг олгосон байна;
- зээлдэгч нь олон нийтийн санааг ихээр зовоосон асуудалтай төслүүдэд гомдол барагдуулах зүүчлалын үйлчилгээ үзүүлэх боломжийг авч үзнэ;
- гомдол барагдуулах механизмын явцын хяналт болон хандлагын дүн шинжилгээг тогтмол хийнэ.

Төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл, нөлөөллийн өөрчлөлт

30. ТОХТ-нд төслийн хэрэгжилтийн аль ч үе шатанд байгаль орчны эсвэл нийгмийн эрсдэл, нөлөөллийг ихээр хувиргасан өөрчлөлт гарвал талуудын оролцоог хэрхэн хангах тухай заалтуудыг тусгана. Зээлдэгч тэдгээрийг хэрхэн бууруулах талаар талуудад мэдээлэл өгч, хэрэв нөлөөлөлд өртсөн талуудад ихээхэн эрсдэл, сөрөг нөлөөлөл үүссэн бол нэмэлт хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлагатай болно.

Тэмдэглэл

ЕСБХБ-ны холбогдох мэдээлэл

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк

Уан Эксчейнж Өргөн Чөлөө

Лондон хот EC2A 2JN

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

www.ebrd.com

Оператор/төвтэй холбогдох

Утас: +44 20 7338 6000

Мэдээллийн лавлах

Лавлагаа мэдээлэл авах, санал хүсэлт илгээхийг хүсвэл дараах холбоосыг дарна уу:

www.ebrd.com/eform/information-request

1096 Байгаль орчин, нийгмийн бодлого

© Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк